



ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН
ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙТГЭХ
ТОГТООЛЫН БҮТЭЦ,
БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ:
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Улаанбаатар хот
2025 он



ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ
ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛЫН БҮТЭЦ,
БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ:
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Улаанбаатар хот
2025 он

Хянасан: Б.Дөлгөөн, Шүүхийн академийн Судалгааны
төвийн дарга (Ph.D)

Боловсруулсан: Э.Баасанбямба, Шүүхийн академийн Эрүүгийн
эрх зүйн секторын эрхлэгч

Э.Эрхбилгүүн, Шүүхийн академийн Үндсэн
хуулийн болон олон улсын эрх зүйн секторын
эрхлэгч (LL.M)

С.Жансая, Шүүхийн академийн судлаач (LL.M)

С.Лувсандолгорхулан, Шүүхийн академийн
судлаач (LL.M)

Б.Оюунзаяа, Шүүхийн академийн судлаач

Э.Хишигсүрэн, Шүүхийн академийн судлаач

П.Эрхэмбаяр, Шүүхийн академийн судлаач
(LL.M)

Эх бэлтгэсэн: Б.Нямдорж

Цаасны хэмжээ: 148x210 A5

Хэвлэлийн хуудас: 9хх

© Шүүхийн академи, 2025

Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан тул энэхүү бүтээлийг
зөвшөөрөлгүй хэвлэх, нийтлэх, олшруулах, хуулбарлахыг хориглоно.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	4
ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ	4
ӨМНӨХ ҮГ	6
ОРШИЛ	8
 НЭГ. ЭХ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН БҮЛИЙН УЛСУУД	11
1. ЭХ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН БҮЛ ДЭХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН БҮТЦИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, ОНЦЛОГ	12
2. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС	22
3. ЯПОН УЛС	34
4. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС	40
5. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС	47
6. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС	55
7. МОНГОЛ УЛС	64
БҮЛГИЙН ДҮГНЭЛТ	89
 ХОЁР. ЖИШГИЙН ЭРХ ЗҮЙН БҮЛИЙН УЛСУУД	93
1. ЖИШГИЙН ЭРХ ЗҮЙН БҮЛ ДЭХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН БҮТЦИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, ОНЦЛОГ	94
2. АНГЛИ УЛС	102
3. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС	116
БҮЛГИЙН ДҮГНЭЛТ	122
НОМ ЗҮЙ	125

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
МУШТХ	Монгол Улсын шүүхийн тухай хууль
ОХУ	Оросын Холбооны Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХ	Эрүүгийн хууль

ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ №1.	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц
Шигтгээ №2.	Япон Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц
Шигтгээ №3.	Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц
Шигтгээ №4.	Бүгд Найрамдах Франц Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц
Шигтгээ №5.	Оросын Холбооны Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц
Шигтгээ №6.	Монгол Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц
Шигтгээ №7.	Англи Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц
Шигтгээ №8.	Америкийн Нэгдсэн Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

- Шигтгээ №9.** Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 2025/ДШМ/605 дугаар магадлал
- Шигтгээ №10.** Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 499 дугаар магадлал
- Шигтгээ №11.** Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 1058 дугаар магадлал
- Шигтгээ №12.** Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 2025/ДШМ/856 дугаар магадлал
- Шигтгээ №13.** Улсын дээд шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 2024/ХШТ/118 дугаар тогтоол
- Шигтгээ №14.** Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 17 дугаар магадлал
- Шигтгээ №15.** Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 688 дугаар магадлал
- Шигтгээ №16.** Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 423 дугаар магадлал
- Шигтгээ №17.** Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 2023/ДШМ/12 дугаар магадлал
- Шигтгээ №18.** Улсын дээд шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 594 дүгээр тогтоол

ӨМНӨХ ҮГ

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи нь Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар шүүн таслах ажиллагааг судалгаа, мэдээллээр хангах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэхүү чиг үүргийн хүрээнд Шүүхийн академи нь шүүх, шүүгчийн захиалгаар судалгаа хийхээс гадна эрх зүйн ач холбогдол бүхий мөн Монгол Улсад төдийлөн бүрэн судлагдаагүй сэдвээр бие даан судалгаа хийдэг бөгөөд эрхэм шүүгч, хуульч, судлаач, эрх зүйч та бүхэнд бие даан хийсэн 26 дахь судалгааны бүтээлээ танилцуулж байгаадаа баяртай байна.

Энэ удаагийн бие даасан судалгааг Эрүүгийн эрх зүйн сектор болон Үндсэн хуулийн болон олон улсын эрх зүйн секторын судлаачид хамтран “Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын бүтэц, боловсруулах арга зүй: харьцуулсан судалгаа” нэртэйгээр гаргаж байна.

Монгол Улсад шүүхийн шийдвэрийн чанар, үндэслэл, ил тод байдлыг хангах нь шүүх эрх мэдлийн хариуцлага, шударга ёсны хэрэгжилтийг илтгэх гол хэмжигдэхүүний нэг юм. Иймд шүүхийн шийдвэрийг боловсруулах хэлбэр, бүтэц, хэл найруулгын оновчтой, зохистой байдлыг сайжруулах, нэгдсэн загварчлалын жишигт нийцүүлэх асуудал сүүлийн жилүүдэд онцгой анхаарал татах болжээ. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр нь хүний эрх, эрх чөлөөнд шууд нөлөөлөх, эрүүгийн хариуцлага оногдуулах эрх зүйн үр дагавартай тул түүний бүтэц, найруулга, хууль зүйн үндэслэлээ тайлбарласан байдал нь хууль ёсны байдлыг баталгаажуулах чухал нөхцөл болдог.

Иймд эх газрын болон жишгийн эрх зүйн бүлд хамаарах улсуудын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц, шийдвэрт тавигдах шаардлагыг харьцуулсан судалгаа нь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц, агуулга, хууль

зүйн үндэслэл, бичгийн соёлын талаар системтэй мэдлэг олгоход тус болно гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү гарын авлагыг төлөвлөж удирдсан Шүүхийн академийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Дөлгөөн, боловсруулсан судлаач Э.Баасанбямба, Э.Эрхбилгүүн, С.Жансая, П.Эрхэмбаяр, Б.Оюунзаяа, С.Лувсандолгорхулан, Э.Хишигсүрэн нартаа талархал илэрхийлье.

Шүүхийн академиас гаргасан судалгааны бүтээл, гарын авлагыг шүүгч, хуульч, судлаач, эрх зүйч, оюутан бүхний өдөр тутмын ажлын хэрэглээнд ойртуулах, судалгааны эх сурвалжийг нэмэгдүүлэх зорилгоор хэвлэмэл болон цахим хэлбэрээр эмхэтгэн хүргэж байгаа бөгөөд уг гарын авлагыг та бүхэн цахим хэлбэрээр Шүүхийн академийн www.jtrii.mn сайтаас, хэвлэмэл хэлбэрээр Төв номын сан, хууль зүйн их дээд сургуулиудын болон Улсын дээд шүүхийн номын сангаас унших боломжтой.

Шүүхийн сургалт, судалгаа,

мэдээллийн академийн захирал

Хууль зүйн доктор, дэд профессор, Д.Эрдэнэчимэг

ОРШИЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)¹-ийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “*анхан шатны шүүх хуралдаанаар* тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэх, гэм буруутай бол түүнд оногдуулах Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хянан шийдвэрлэнэ” хэмээн заасан. Анхан шатны шүүх нь энэхүү чиг үүргийн хүрээнд хэргийг хянан шийдвэрлээд Монгол Улсын нэрийн өмнөөс шийдвэр гаргадаг бөгөөд уг шийдвэр нь шийтгэх эсхүл цагаатгах хэлбэртэй байна.

Шүүхээс гарч буй шийдвэрт хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлага тавигддаг. Шударгаар шүүлгэх эрх, шүүхийн шийдвэрийг нээлттэй байлгах эрхийн дагуу шүүх нь шийдвэрийнхээ үндэслэлийг тайлбарлаж өгөх үүрэгтэй бөгөөд үндэслэл бүхий шүүхийн шийдвэр авах эрх нь хууль дээдлэх ёсыг хангах, хэргийг дур зоргоороо шийдвэрлэхээс хамгаалагдах үндсэн баталгаа болдог.² Энэ талаар Английн алдарт шүүгчдийн нэг Лорд Деннинг (Lord Denning 1899-1999) “хууль ёсны шүүхийн шийдвэрийг дур зоргоор гаргасан шүүхийн шийдвэрээс ялгах зүйл нь шүүхийн шийдвэрийн үндэслэл юм” хэмээн хэлжээ.

Шүүх үндэслэл бүхий шийдвэрийг бичгээр гаргаснаар нэг талаас хэргийг дур зоргоор бус, зөвхөн хуульд үндэслэн шийдвэрлэснийг харуулах, нөгөө талаас үндэслэл бүхий шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогч хүлээн авснаар шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэх эрх хангагдах, цаашлаад давж заалдах гомдол гаргах, гомдлын үндсэн дээр дээд шатны шүүхээс доод шатны шүүхийн шийдвэрийг хянах нөхцөл бүрдэх зэрэг ач холбогдолтой байна.

Шүүхийн шийдвэрийг хангалттай үндэслэлтэйгээр, талуудад хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд боловсруулах нь сайн шийдвэр бичих үндэс бөгөөд шийдвэрийг бичихийн тулд шүүгчээс хуулийн зүйл, заалт, түүнтэй холбогдох улс төрийн бодлого болон нийгмийн

1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017, <https://legalinfo.mn/mn/detail?lawid=12694>, (Сүүлд үзсэн: 2025.09.05).

2 Эмнести Интернэшнл, Шударгаар шүүлгэх эрх, Гарын авлага, (2 дахь хэвлэл), 2014, 174 дэх тал.

зөвшилцөл, шийдвэрээ үндэслэлтэй, тодорхой, ойлгомжтой, логик дэс дараалалтай бичих чадварыг шаарддаг.³ Гэвч манай улсад шүүхийн шийдвэрийн бүтэц, шүүхийн шийдвэр боловсруулах арга зүйн талаар бичигдсэн ном, гарын авлага хомс байна.⁴ Үүнээс гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017) болон Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2021 оны 09 дүгээр сарын 20-ний өдрийн “Шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлалыг батлах тухай” 29 дүгээр тогтоолд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал, бүтцийн агуулга, түүнд тавигдах шаардлагын талаар тогтоосон ч зарим шүүхийн шийдвэр хуульд заасан шаардлагад нийцээгүй, шийдвэр хууль ёсны ба үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй үндэслэлээр дээд шатны шүүхээс хүчингүй болгох тохиолдлууд байна.

Иймд шүүхийн шийдвэрийг бичгээр боловсруулахын зорилго, ач холбогдол, арга зүйг харьцуулсан болон онолын судалгааны үндэслэлтэйгээр судалж, хуульч, шүүгчдэд зориулсан гарын авлагыг бэлтгэх нь шүүн таслах ажиллагааны үр дүн болох шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулахад түлхэц болохын зэрэгцээ иргэдийн шүүхэд итгэх итгэл, шударгаар шүүлгэх эрхийн баталгааг хангахад эерэг нөлөөтэй хэмээн үзэв.

Энэхүү гарын авлага нь эрүүгийн хэргийг хянан шийдвэрлээд шүүхийн шийдвэрийг бичгээр гаргаж байгаагийн зорилго, ач холбогдол, шийдвэрийг хэнд зориулан бичгээр гаргадаг, шүүгч шийдвэрийг боловсруулахад анхаарвал зохих асуудлыг эх газрын болон жишгийн эрх зүйн бүлд хэрхэн авч үздэг талаар өгүүлнэ. Үүнээс гадна гадаадын зарим орны Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын бүтэц, түүний агуулга, нотлох баримтыг шүүхийн шийдвэрт бичих арга зүй, латин нэр томьёог шийдвэрт буулгах хэв маяг зэргийг дэлгэрүүлэн танилцуулна.

3 Йоахим Кают, Монгол Улсын шинэ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, Шүүхийн шийдвэр, тогтоол бичих арга техник, (Тэнгэрлэг Үсэг ХХК, 2015), 3 дахь тал.

4 Йоахим Кают, Монгол Улсын шинэ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, Шүүхийн шийдвэр, тогтоол бичих арга техник, Хайнрих Шоллер, Хууль зүйн дүгнэлт болон шүүхийн шийдвэр гаргах зарим асуудал зэрэг номыг дурдаж болно.

Гарын авлага нь бүтцийн хувьд:

- i. Эх газрын эрх зүйн бүлд шүүхийн шийдвэрийг бичгээр гаргахтай холбоотой асуудлыг хэрхэн авч үздэг талаар мөн уг бүлд хамаарах зарим улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын бүтэц, онцлогийн талаар;
- ii. Жишгийн эрх зүйн бүлд шүүхийн шийдвэрийг бичгээр гаргахтай холбоотой асуудлыг хэрхэн авч үздэг, мөн жишгийн эрх зүйн бүлд хамаарах зарим улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын бүтэц, онцлогийн талаар гэсэн 2 хэсэгтэй байна.

Уг гарын авлагыг боловсруулахдаа эрх зүйн социологийн судалгааны аргууд болох задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх буюу судалгааны ерөнхий арга зүй болох анализ, синтез, харьцуулсан судалгааны аргуудыг тус тус ашиглав.

НЭГ. ЭХ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН БҮЛИЙН УЛСУУД

1. ЭХ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН БҮЛ ДЭХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН БҮТЦИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, ОНЦЛОГ

Шүүхийн шийдвэр нь хэрэг, маргааныг шүүх хуралдаанаар хянан хэлэлцүүлээд гаргаж буй шүүгчийн оюун дүгнэлт байдаг. Шүүгч хэм хэмжээ болон үйл баримт (факт) гэсэн үндсэн элементүүдийг оролцуулан уг оюун дүгнэлтэд хүрдэг⁵ бөгөөд шүүгчийн сонгон авсан хэм хэмжээ нь эрх зүйн бүлийн онцлогоос хамааран ялгаатай байдаг. Тухайлбал, эх газрын эрх зүйн бүлд шүүгчийн хэрэглэх хэм хэмжээний үндсэн эх сурвалж нь хууль тогтоомж байдаг бол жишгийн эрх зүйн бүлд шүүхийн прецедентийг эх сурвалжаар ашиглахыг зөвшөөрдөг. Иймээс хэрэглэж буй ялгаатай эх сурвалжаас хамааран шүүгч дедуктив эсвэл индуктив оюун дүгнэлтийг хийдэг гэж зарим судлаач үздэг байна.⁶ Тодруулбал, эх газрын эрх зүйн бүлд хамаарах улсуудад шүүгч эрх зүйн дүгнэлт хийхдээ норматив хэм хэмжээнд тодорхой нэг үйл баримтыг субсумци хийх замаар дүгнэлт гаргадаг ба энэ нь логик-дедуктик оюун дүгнэлтийн аргыг ашиглаж байгаа нэг хэлбэр юм.

Шүүгчийн оюун дүгнэлтийн үндсэн дээр бий болсон шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчдод амаар танилцуулахаас гадна бичгээр үйлдэж гардуулан өгдөг. Түүхэн үүднээс авч үзвэл Ромын эрх зүйн түүхэн хөгжлийн явцад шүүхийн шийдвэрийг бичгээр (schriftliche Urteil)⁷ гаргадаг байсан ч тухайн үед гаргаж буй шүүхийн шийдвэр нь тогтсон бүтэцгүй, мөн шүүгч тухайн шийдвэрт хүрсэн үндэслэлийн талаар бичдэггүй байж.

Бичгээр гаргаж буй шүүхийн шийдвэрийн бүтэц нь эрх зүйн тогтолцоо, тухайн шүүхийн чиг үүрэг, хэрэг, маргааны төрөл зэргээс хамааран ялгаатай байдаг ч **“шүүгч үндэслэгээ бүхий шийдвэр гаргах”** ерөнхий шаардлагыг тавьдгаараа ижил байна. Шүүхийн шийдвэр нь ямар бүтэцтэй байх талаар тусгайлан хуульчилсан улс байхад зарим улсад энэ талаар тусгаагүй ч шүүхийн шийдвэрийн

5 Товуусүрэнгийн Саруул, Эрх зүйг хэрэглэх арга зүй, (Хууль зүйн үндэсний хүрээлэн хэвлэх үйлдвэр, 2014), 22 дахь тал.

6 Suzanna Ballansat, “Attendu que” Französische Gerichtsurteile als Herausforderung für den Übersetzer“, 2014, S.1.

7 Susanne Hahnchen: Rechtsgeschichte, 2021, S.120.

бүтцийн нэг хэсэг болох “**шүүхийн шийдвэрийн үндэслэл**” хэсэгт юу бичих талаар тусгайлан хуульчилжээ. Шийдвэрийн бүтцийг тусгайлан хуульчилсан улсаар Монгол Улсыг нэрлэж болох бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “*Шүүхийн шийдвэр нь удиртгал, тодорхойлох, тогтоох хэсгээс бүрдэнэ*” хэмээн заасан байна. Шийдвэрийн бүтцийг тусгайлан хуульчлаагүй ч үндэслэл хэсгийн талаар хуульчилсан улсаар Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид “Герман Улс” гэх) -ийг нэрлэж болох бөгөөд тус улсын Эрүүгийн процессын хууль (1950)⁸-ийн 267 дугаар зүйлд “Шүүхийн шийдвэрийн үндэслэл”-ийн талаар хуульчилсан байна.

Шүүх нь хууль хэрэглэсэн аливаа шийдвэрээ хуульд тулгуурласан үндэслэлээр зөвтгөх, түүнийгээ тайлбарлах үүрэгтэй бөгөөд шүүхэд яагаад ийм үүрэг хүлээлгэдэг шалтгааныг хууль тогтоогчийн үүрэг болон шүүх эрх мэдлийн зорилготой харьцуулан мэдэх боломжтой байдаг. Хууль тогтоох эсвэл гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгчийн шийдвэр ийнхүү зөвтгөгдөхийг шаарддаггүй. Харин шүүх эрх мэдэл нь хууль дээдлэх ёс (the Rule of Law)-ыг хэрэгжүүлэхэд зориулагдсан бөгөөд **шүүх хууль дээдлэх ёсыг сахиулахын зэрэгцээ өөрөө түүндээ захирагдах ёстой учраас өөрийн шийдвэрийг хууль зүйн үндэслэлээр зөвтгөж, хуулийг хэрхэн дээдэлж байгаагаа ил харуулах хэрэгтэй байдаг байна.**⁹

Иймд Европын зарим улсад тухайлбал, Бүгд Найрамдах Итали Улсын Үндсэн хууль¹⁰ болон Испанийн Хаант Улсын Үндсэн хуульд¹¹ шүүх шийдвэрийн үндэслэлийг бичгээр гаргах үүрэгтэй хэмээн заажээ.¹² Харин бусад улсад шүүх үндэслэл бүхий шийдвэрийг

8 Strafprozeßordnung (StPO), 1950, <https://www.gesetze-im-internet.de/stpo/>, (Сүүлд үзсэн:2025.09.15).

9 Одонхүүгийн Мөнхсайхан, “Шүүхийн шийдвэр яагаад үндэслэгдсэн байх ёстой вэ” Шүүх эрх мэдэл 2016 №2, 2016, 10 дахь тал.

10 Verfassung der Italienischen Republik, 1947, Art.111 Para.6, https://www.senato.it/sites/default/files/media-documents/Costituzione_TEDESCO.pdf, (Сүүлд үзсэн: 2025.09.15).

11 Constitución Española, 1978, Art 120, <https://www.verfassungen.eu/es/verf78-index.htm>, (Сүүлд үзсэн: 2025.09.15).

12 Sten Lind, Magister iuris Richter des Oberlandesgerichts Tallinn, erfassungsrechtliche Grundlagen der Pflicht zur Begründung von Gerichtsurteilen, Juridica, 24 (2016), S.116, Verfassungsrechtliche Grundlagen der Pflicht zur Begründung von Gerichtsurteilen | Juridica International, (Сүүлд үзсэн:2025.09.19).

бичгээр гаргах талаар ихэвчлэн эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульдаа тусгасан байна. Жишээлбэл, Бүгд Найрамдах Эстони Улсын эрүү, иргэн, захиргааны процессын хуулиудад шүүхийн шийдвэрийн үндэслэлийг бичгээр гаргах талаар заасан бөгөөд хэрэв үндэслэлийг бичээгүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил хэмээн үзэж, шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үр дагавартай байдаг. Гэхдээ тус улсад шүүхээс гаргаж байгаа бүх шийдвэрийн үндэслэлийг бичгээр гаргадаггүй. Тухайлбал, хяналтын журмаар гаргасан гомдлыг дээд шүүхээс хянан хэлэлцүүлэхээс татгалзах тухай шийдвэр гаргасан бол татгалзсан шалтгаан, үндэслэлийг тусгасан шийдвэрийг бичгээр гаргадаггүй.¹³

Шүүхийн шийдвэрийн үндэслэлийг бичгээр гаргах үүргийг түүхэн талаас нь судлан үзвэл анхандаа шүүхийн тогтолцоо дотор хэрэгжүүлдэг байжээ. Дундад зууны үед хэргийн оролцогчид шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхтэй байсан бөгөөд уг эрхийн хүрээнд давж заалдах гомдол гаргасан тохиолдолд шүүх үндэслэлээ давж заалдах шатны шүүхэд гаргаж өгдөг байсан. Өөрөөр хэлбэл хэргийн оролцогч, олон нийтэд хандаж буюу гадагшаа чиглэж шүүх шийдвэрийн үндэслэлийг тайлбарладаггүй, зөвхөн шүүх байгууллага дотроо гаргадаг байв. Ингэснээр хэргийн оролцогч болон иргэд, олон нийтэд шүүхийн шийдвэрийн үндэслэл нууц хэвээр үлдэж байсан. Франц Улсын хувьд шүүхүүд 14-р зуунаас 1810 он хүртэл хэргийн оролцогч болон иргэдэд шүүхийн шийдвэрийн үндэслэлийг нээлттэй байлгахыг хориглодог байсан бол¹⁴ Швед Улсад мөн адил шүүхийн шийдвэрийн үндэслэлийг нууц үлдээдэг байжээ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсгийг нээлттэй гаргадаггүй, нууцлах шалтгааныг дараах байдлаар тайлбарласан байна. 1641 онд Швед Улсын давж заалдах шатны шүүх (Svea Hovrätt)-ээс хэргийн оролцогчид шүүх яагаад ийм шийдвэр гаргасан талаар мэдээлэл авахыг хүсэхэд уг шүүхээс шийдвэрийн үндэслэлийг шүүхийн дээр

¹³ Sten Lind, S.117.

¹⁴ Sten Lind, S.120.

байгаа эзэн хаан, засгийн газарт л тайлагнадаг, шийдвэрийн үндэслэл нь хэргийн оролцогч талуудад хамааралгүй гэж үзсэн байна. Мөн 1789 онд Герман Улсын хуульч Юстус Клапрот (Justus Claproth 1728-1805) “шүүх өөрийн байр суурийг хэргийн оролцогч болон олон нийтэд бус, харин эрхэм дээдэст (гер.Obgigkeit) мэдээлэх учиртай бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэлийг хэргийн талуудад нээлттэй байлгах нь шүүхийн нэр төрийг гутааж буй явдал” хэмээн тайлбарлаж байжээ.¹⁵ Дээрхээс харвал шүүхийн шийдвэрийн үндэслэлийг хэргийн оролцогч талууд болон олон нийтэд мэдэгдэх нь зохисгүй гэж үздэг байж.

Гэвч 18-р зуунд шүүх эрх мэдэлд хөндлөнгийн хяналт тавих үүднээс иргэд шүүхийн шийдвэрийн үндэслэлийг шаардаж эхэлсэн, мөн иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх үүднээс зарим улсад шүүхийн шийдвэрийн үндэслэлийг шийдвэрт тусгах болсон. Тухайлбал, Герман Улсын зарим мужид шүүхийн шийдвэрийн үндэслэлийг бичих үүргийг хуульчилж эхэлсэн¹⁶ бол зарим мужид зөвхөн дээд шатны шүүхийн шийдвэрт үндэслэлийг бичих талаар хуульчилсан байна.¹⁷

Шүүхийн шийдвэрийн бүтцийн чухал хэсэг болох шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэг нууц үлддэг байсныг халж, үндэслэлийг шүүхийн шийдвэрт тусгах болсноор шүүгч өөрийн үзэмжээр шийдвэр гаргах явдлыг таслан зогсоох, шүүхийн нээлттэй байдлыг нэмэгдүүлэх чухал алхам болжээ.

Шүүхийн шийдвэрийг бичгээр гаргаж байгаагийн шалтгааныг судлан үзвэл хэд хэдэн шалтгаантай байна. Үүнд:¹⁸

- 1) Шүүгдэгч болон хэргийн бусад оролцогч, олон нийтэд шүүх эрх мэдэл нь хэн нэгний нөлөөнд авталгүйгээр, зөвхөн хуульд захирагдан, шударгаар шийдвэр гаргасан гэдгээ мэдээлэх зорилготой байдаг.

¹⁵ Sten Lind, S.120.

¹⁶ Тухайлбал, Саксин мужид 1751 оноос, Ваймар мужид 1723 оноос эхлэн хуульчилсан байна.

¹⁷ Бадеш мужийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд энэ талаар хуульчилсан байна.

¹⁸ Jurg-Peter Becker, Volker Erb, Robert Esser, Kirsten Graalman-Scheerer, Hans Hilger, Alexander Ignor: Die Strafprozeßordnung und das Gerichtsverfassungsgesetz, Großkommentar, 77. Aufl., 2021, S. 556- 558.

- 2) Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрх болох шүүхэд мэдүүлэх эрхийг хангаж байгааг шүүхийн шийдвэрийг бичгээр гаргах замаар харуулдаг.
- 3) Шүүхийн шийдвэрийг бичгээр гаргаснаар хэргийн оролцогч үр дүнтэй давж заалдах, хяналтын гомдол гаргах боломжтой бөгөөд уг гомдолд тулгуурлан дээд шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг хянах боломжтой болдог.
- 4) Шүүхийн шийдвэрийг бичгээр гаргах нь шүүгч тухайн шийдвэрийг нотлох баримтад тулгуурлан өөрийн дотоод итгэлээр үндэслэл бүхий, ойлгомжтой шийдвэр гаргаж байгаа эсэхээ өөрөө хянах боломжтой байдаг.

Бичгээр боловсруулан гаргаж буй шүүхийн шийдвэр нь бүтцийн хувьд удиртгал, тодорхойлох (үндэслэх), тогтоох гэсэн хэсгүүдэд хуваагдах нийтлэг тал байгаа ч тодорхойлох болон тогтоох хэсгийн байршил нь тухайн улсын онцлогоос хамааран өөр өөр байж болдог. Тухайлбал, Герман Улсын шүүхийн шийдвэрийн бүтэц нь удиртгал, тогтоох, үндэслэх гэсэн дараалалтай байхад Франц Улсын хувьд удиртгал, үндэслэх, тогтоох гэсэн дараалалтай байна. Гэвч судлаачид **шүүхийн шийдвэрийн бүтцэд хамаарах хэсгүүд аль хэсэгт байрлаж байгаагаас илүүтэй тухайн шийдвэрийг хэнд зориулж гаргаж байгаа, шүүхийн шийдвэрийг хэрхэн яаж бичих тухай асуудалд илүүтэй анхаарал хандуулдаг.**

Аливаа бичвэр нь хүмүүс хоорондын харилцааны хэрэгсэл болохын хувьд:

- Бичвэр илгээгч (rep.Textsender) болон бичвэр боловсруулагч (rep. Textproduzent),
- Бичвэрийг хүлээн авагч (rep.Empfdnger)-тай байна.¹⁹

Эрүүгийн хэргийн шүүхээс гаргаж буй шийдвэр нь мэргэжлийн бичвэрийн нэг төрөл бөгөөд уг бичвэрийн илгээгч, боловсруулагч, хүлээн авагч нь хэн байх талаар судлан үзсэнээр шийдвэрийг

¹⁹ Iwona Jacewicz: Didaktik des Fachübersetzens am Beispiel der Rechtstexte: polnische und deutsche Strafurteile im Vergleich, Dissertation, Universität Wien, 2010, S.61-66.

гаргаж байгаа зорилго, шийдвэрийг бичих хэв маягийг тодорхойлох боломжтой. Бичвэрийг илгээгч болон боловсруулагч нь нэг эсхүл өөр өөр этгээд байж болох бөгөөд шүүхийн шийдвэрийн хувьд өөр өөр этгээд байдаг. Тодруулбал, **шийдвэрийг илгээгч нь** аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэх хууль ёсны эрх олгосон байгууллага байдаг ба үүнийг улс орнууд Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид тусгайлан заадаг. Жишээлбэл, Монгол Улсын Үндсэн хууль (1992)²⁰-ийн Дөчин долдугаар зүйлийн 1-д “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэж, Герман Улсын Шүүхийн тухай хууль (1950)²¹-ийн 1 дүгээр зүйлд “Шүүх эрх мэдлийг хараат бус, зөвхөн хуульд захирагддаг шүүх хэрэгжүүлнэ” хэмээн тус тус заажээ. Шүүхийн шийдвэрийн эхлэл хэсэгт тухайн шийдвэрийг гаргасан шүүхийн нэрийг бичдэг нь шийдвэрийг илгээгч нь шүүх гэдгийг батлан харуулдаг байна.²²

Харин **шүүхийн шийдвэрийг боловсруулагч нь** шүүгч байна. Шүүгч нь шийдвэрийг боловсруулдаг ч шийдвэрийг илгээгч нь шүүх байгууллага байдаг. Иймээс шүүхийн шийдвэр нь хувь хүмүүсийн хоорондын харилцаа бус харин байгууллага болон хувь хүний хооронд үүссэн харилцаа байдаг учраас объектив байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, байгууллагаас гаргаж буй шийдвэр нь хувь хүний бодол бус байгууллагын хүсэл зоригийг илэрхийлсэн байх ёстой. Харин шүүхийн шийдвэрийн төгсгөлд шүүгч өөрийн гарын үсгээ зурах бөгөөд энэ нь уг бичвэрийн агуулгыг шүүгч хариуцна гэдгийг илтгэх зорилготой байдаг.

Шүүхийн шийдвэрийг хүлээн авагч нь нэг биш хэд хэдэн этгээд байдаг. Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн хувьд хүлээн авагч нь хэд хэдэн этгээд байх бөгөөд хүлээн авагчийг 2 төрөлд ангилна.²³

20 Монгол Улсын Үндсэн Хууль, 1992, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>, (Сүүлд үзсэн: 2025.09.15).

21 Gerichtsverfassungsgesetz (GVG), 1950, <https://www.gesetze-im-internet.de/gvg/index.html>, (Сүүлд үзсэн: 2025.09.15).

22 Iwona Jacewicz, S.65.

23 Iwona Jacewicz, S.70.

- 1) Мэргэжлийн бус этгээд²⁴ (хэргийн оролцогчид, олон нийт)
- 2) Мэргэжилтнүүд (хуульчид, дээд шатны шүүхүүд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар гэх мэт)

Шүүхийн шийдвэрт (шийдвэрийн удиртгал хэсэгт) нэрлэн дурдсан хэргийн оролцогч талууд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчид шийдвэрийг хүлээн авагч болдог. Харин бусад хүлээн авагчийг шүүхийн шийдвэрийн удиртгал хэсэгт дурдахгүй бөгөөд тэд Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжид заасан шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангах, давж заалдах гомдлыг баталгаатай эдлүүлэх эрхийн хүрээнд шүүхийн шийдвэрийн хүлээн авагч болдог байна. Шүүхийн шийдвэр нь ийнхүү олон хүлээн авагчид хандсан байдаг бөгөөд үүнийг Хоппманн (Hoffmann) “хэд хэдэн хүлээн авагчтай бичвэр” хэмээн нэрлэжээ.

Эрүүгийн шүүхийн шийдвэрийн хамгийн чухал хүлээн авагч нь шүүгдэгч буюу мэргэжлийн бус этгээд байдаг. Иймээс “бичвэр хүлээн авагчид ойлгомжтой байх ёстой” гэсэн шаардлагыг тавьдаг. Гэвч дээрх зорилгод хүрэхэд асуудал үүсдэг байна. Учир нь бичвэрийг хүлээн авагч нь мэргэжлийн бус этгээд (шүүгдэгч) байдаг бол шийдвэрийг илгээгч нь хувь хүн бус байгууллага байдаг, уг бичвэрийг боловсруулагч нь шүүгч буюу мэргэжлийн этгээд байдаг. Энэ нь шүүхийн шийдвэрийг хүлээн авагч болон илгээгч нь хэвтээ байрлалд бус босоо байрлалд (мэргэжилтэн болон мэргэжилтэн бус харилцаанд) байгааг харуулдаг. **Мөн шийдвэрийг илгээгч болох шүүхээс гаргаж буй шийтгэх тогтоол нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүнд тохирсон ял шийтгэл оногдуулж, шударга ёсыг цогцлоох зорилготой байдаг. Иймээс хүлээн авагч нь хэн байхаас илүүтэй бичвэрийн агуулга болон хэлбэрт голчлон анхаардаг байна.**

Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр нь эрх зүйн онолын талаас авч үзвэл дараах 2 үүргийг гүйцэтгэдэг.

24 Хуульч бус хүмүүсийг энэхүү ангилалд хамруулан үзэв.

- Нотлох баримтад тулгуурлан хэргийн үйл баримтыг сэргээн тогтоох;
- Сэргээн тогтоосон үйл баримт нь хуульд хийсвэр байдлаар тусгасан гэмт хэргийн шинжийг хангасан эсэх.

Харин бичвэр илгээгч болон хүлээн авагч хооронд бий болсон харилцааны талаас авч үзвэл эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг илгээгч нь хэд хэдэн хүлээн авагчид **өөр өөр зорилгын хүрээнд шийдвэрийг илгээсэн** байдаг. Тухайлбал, хэргийг хуульд захирагдан шийдвэрлэсэн бөгөөд уг шийдвэрийг хүчин төгөлдөр болгох зорилгоор хэргийн оролцогч талуудад хандах, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэгдэх зорилгын хүрээнд хэргийн оролцогч, өмгөөлөгч, дээд шатны шүүх, олон нийтэд тус тус хандсан байдаг.

Дээрх ялгаатай зорилгод тулгуурлан шүүхийн шийдвэрийн бүтэц доторх хэсгүүд (удиртгал, тодорхойлох, тогтоох) нь ялгаатай чиг үүрэгтэй байна. Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн хувьд:²⁵

- Удиртгал хэсэг нь зарлан тунхаглах чиг үүрэгтэй байна. Шүүх, шүүгдэгч болон бусад оролцогчийн талаарх мэдээллийг өгөх.
- Тодорхойлох (үндэслэл) хэсэг нь мэдээлэх чиг үүрэгтэй байна. Шүүх шүүгдэгчийг гэм буруутай гэж үзсэн үндэслэлийг энэ хэсэгт мэдээлнэ.
- Тогтоох хэсэгт зарлан тунхаглах чиг үүрэгтэй байна. Шүүхээс гаргаж буй шийдвэрийг шүүгдэгчид мэдээлэх.

Шүүхийн шийдвэрийг нэг бүхэл бичвэр гэж үзвэл мэргэжилтэн болон мэргэжлийн бус этгээдүүдэд хандсан байдаг бөгөөд шийдвэрийн бүтцийн хэсгүүд нь ямар чиг үүрэгтэй, хэнд хандаж байгаагаас шалтгаалан найруулгын ялгаатай хэв маягтай байж болдог. Жишээлбэл, **шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг** богино өгүүлбэрээр товч, тодорхой бичих ёстой гэж үздэг. Энэ нь дээр

25 Iwona Jacewicz, S.77.

дурдсанчлан зарлан тунхаглах чиг үүргийг харгалзах, мөн шүүх хуралдааны төгсгөлд шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг хэргийн оролцогч талуудад уншиж сонсгодог учраас богино өгүүлбэрээр товч, тодорхой бичих ёстой байдаг. Харин **шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг нь** мэргэжлийн болон мэргэжлийн бус этгээдэд хоёуланд нь хандсан байдаг. Шүүхийн шийдвэрийн үндэслэлээс шүүгдэгч шүүх яагаад түүнд бус гэрч нарын мэдүүлэгт итгэсэн, яагаад түүнд оногдуулсан ялын төрөл, хэмжээнээс бага ял шийтгэл оногдуулаагүй зэргийг мэдэхийг хүсэж байдаг. Иймээс шүүгч нэг талаас шүүгдэгчид ойлгомжтой байдлаар бичих, нөгөө талаас шүүгч уг шийдвэр зөв гэдгийг дээд шатны шүүхэд батлан харуулах ёстой болдог.²⁶ Мөн процессын онолын дагуу үндэслэх хэсэг нь тогтоох хэсгийн эрх зүйн үнэлгээг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгах чиг үүрэгтэй байдаг.²⁷

Шүүхийн шийдвэрийн үндэслэл нь эрдэм шинжилгээ, шинжлэх ухааныг нотлох зорилгогүй байдаг. Иймээс шийдвэрийг боловсруулж байгаа хүн бодит, амьдралд нийцсэн байхаас гадна эцсийн үр дүнд харуулах ёстой байдаг. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан шүүх шийдвэрээ боловсруулах ёстой бөгөөд шүүхийн шийдвэрийг олон талын хүлээн авагчид тохирох хэв маягаар бичих нь шүүхийн нэр хүндийг дээшлүүлдэг байна.

Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөл (CCJE)-өөс 2008 онд “Шүүхийн шийдвэрийн чанарын асуудлаар Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхааралд хүргэх нь” гэсэн дүгнэлт гаргасан. Уг дүгнэлтэд **шүүхийн шийдвэрийн чанар нь гадаад болон дотоод хүчин зүйлсээс хамаарна**²⁸ гэсэн байх бөгөөд гадаад хүчин зүйл буюу шүүгчээс үл хамаарах хүчин зүйлд:

- Хууль тогтоогчийн баталсан хуулийн чанар;

26 Ekkehard Appl, S.37.

27 Бат-Эрдэнийн Буянхшиг, “Иргэний хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”, Шүүх эрх мэдэл, 2015 №3, 57 дэх тал.

28 Лхагвасүрэнгийн Галбаатар, Шуларга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг хангах нь: Шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулах хүчин зүйлс, legaldata.mn, 2016, 7-8 дахь тал, <https://legaldata.mn/buteel/pdf?id=307>, (Сүүлд үзсэн: 2025.09.11).

- Хүний, санхүүгийн болон материалын нөөц;
- Эрх зүйн бус асуудлаар шүүгчдийг сургах, шүүхийн захиргааны ажилтнуудыг шүүгчид захиргааны болон техникийн дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах оюуны ажилд төвлөрөхийг дэмжих,

Харин дотоод хүчин зүйл буюу шүүгчээс хамаарах хүчин зүйлд:

- Шүүгчийн мэргэшсэн байдал;
- Хэргийн хөдөлгөөний удирдлага;
- Шүүхийн шийдвэрийн үндэслэл;
- Шүүхийн шийдвэрийн чанарыг үнэлэх явдал байдаг байна.

Дээрхээс харвал шүүхийн шийдвэрийн чанар нь гадаад болон дотоод хүчин зүйлээс хамаарах бөгөөд дотоод хүчин зүйлд шүүхийн шийдвэрийн үндэслэл хамаардаг байна.

Орчин үед техник, технологийн үсрэнгүй хөгжлийн ачаар хэргийн бодит байдлыг нотлоход өргөн хүрээний нотлох баримтыг ашиглах боломжтой болсон. Иймд шүүхийн шийдвэрийн үндэслэлд бичих баримт мэдээллийн цар хүрээ өргөссөн байна. Энэ хэрээр шүүхийн шийдвэрийг бичгээр гаргах хугацааг уртасгасан байдаг. Тухайлбал, 1877 онд Герман Улсын Эрүүгийн процессын хуульд шүүхийн шийдвэрийг бичгээр гаргах хугацааг 3 хоног байхаар хуульчилж байсан бол 1921 онд 7 хоног болгон сунгасан байдаг.²⁹ Харин одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн процессын хуульд уг хугацааг хамгийн багадаа 5 долоо хоног³⁰ байхаар тусгасан байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын бүтэц, түүний агуулгыг дэлгэрүүлэн судлах зорилгоор эх газрын эрх зүйн бүлд хамаарах улсуудыг сонгов. Улсуудыг сонгохдоо шийдвэрийн бүтэц нь “*удиртгал, тогтоох, үндэслэх*” гэсэн бүтцийн дагуу бичигддэг улсуудыг төлөөлүүлэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсыг, шүүхийн

29 Ekkehard Appl, S.39.

30 § 275 Absatz 1 StPO

шийдвэрийн бүтэц нь “*удиртгал, үндэслэл, тогтоох*” гэсэн хэсгүүдээс бүрдэх Бүгд Найрамдах Франц Улс, Оросын Холбооны Улс, Монгол Улсыг тус тус сонгон судлав.

2. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС (ХБНГУ)

Герман Улсын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн бүтэц, шийдвэрт зайлшгүй тусгах мэдээлэл, түүний агуулгын талаар 1950 онд батлагдсан Эрүүгийн процессын хуульд заасан байна.

Тус улсад эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр (гер. Urteil) нь Sachurteil болон Prozessurteil гэсэн хоёр хэлбэртэй байдаг. Шүүхээс Prozessurteil-ыг гэм буруугийн асуудлыг хэлэлцэхгүйгээр бусад шалтгаанаар тухайлбал, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гаргах бол Sachurteil-ыг шүүгдэгчийн гэм буруугийн талаар хэлэлцүүлснээр гаргадаг байна. Шийдвэр нь **шийтгэх, цагаатгах, зарим хэсгийг цагаатгах** гэсэн хэлбэртэй. Эдгээрээс шийтгэх тогтоолыг бичгээр гаргахад дараах бүтцийг баримтална:³¹

Шигтгээ 1. ХБНГУ-ын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Шийтгэх тогтоолын бүтэц:

- 1) *Удиртгал хэсэг (гер. Rubrum);*
- 2) *Тогтоох хэсэг (гер. Tenor);*
- 3) *Шүүхийн шийдвэрт хэрэглэсэн хуулийн зохицуулалт (гер. Angewandte Vorschriften);*
- 4) *Шүүхийн шийдвэрийн үндэслэл (гер. Urteilsgründe);*
- 5) *Шүүгчийн гарын үсэг.*

Дээрх бүтцийн дагуу шүүхийн шийтгэх тогтоолын доторх агуулгад дараах зүйлийг бичих шаардлагатай байдаг.

31 Volker Erb, Robert Esser, Ulrich Franke, Kirsten Graalman-Scheerer, Hans Hilger, Alexander Ignor: Die Strafprozeßordnung und das Gerichtsverfassungsgesetz, Großkommentar, 26., neu bearbeitete Auflage, 2013, S.182

1. Удиртгал хэсэг

Удиртгал хэсгийг Rubrum хэмээн нэрлэдэг бөгөөд энэ нь “ruber” гэх латин үгнээс гаралтай, “улаан” гэх утгыг илэрхийлнэ. Түүхийн үүднээс авч үзвэл шүүхийн шийдвэрийн удиртгал хэсгийг өмнө нь улаан бэхээр бичдэг байснаас үүдэн ийнхүү нэрлэх болсон бөгөөд энэ нь өнөөг хүртэл хадгалагдаж иржээ.³² Шүүхийн шийдвэр нь удиртгал хэсэгтэй байх бөгөөд энэ хэсэгт ямар мэдээлэл тусгахыг Эрүүгийн процессын хуулийн 275 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт³³ “Шүүх хуралдаан болсон өдөр, шүүх хуралдаанд оролцсон шүүгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, өмгөөлөгч, нарийн бичгийн даргын нэрийг шүүхийн шийдвэрт тусгана” хэмээн хуульчилсан байна.

Хуульд дээрх байдлаар ерөнхий тусгасан ч шүүхийн практикт шүүхийн шийдвэрийн удиртгал хэсэг нь дараах мэдээллийг агуулна гэж үздэг. Удиртгал хэсэгт хэргийг шийдвэрлэж байгаа шүүх болон шийдвэрийн дугаар, “Ард түмний нэрийн өмнөөс”³⁴ шийдвэрлэх нь гэсэн гарчгийг бичнэ. Герман Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх өгүүлбэр “Төрийн эрх мэдэл ард түмнээс эхтэй”³⁵ хэмээн заасан бөгөөд төрийн эрх мэдлийн нэг болох шүүх эрх мэдэл шийдвэр гаргаж байгааг энэхүү үгээр илэрхийлдэг.³⁶

Үүний дараа “Шийдвэр” буюу “Urteil” гэх гарчгийг бичдэг. Шүүхийн шийдвэр гэх нэр томъёог 16-р зуунд “сануулга бүхий шийдвэр”, 17-р зуунаас “мэдэгдэх шийдвэр” гэж тус тус нэрлэж байснаа 18-р зуунд “шийдвэр” гэх үгийг ашигласан түүхтэй.³⁷

Шийдвэрийн гарчгийн дараа шүүгдэгчийн хувийн мэдээллийг бичнэ. Шүүгдэгчийн хувийн мэдээлэлд шүүгдэгчийн овог, нэр, мэргэжил, оршин суугаа газар, эсвэл шүүхийн шийдвэрийг сонсгох үед түр оршин суугаа газар, гэрлэлтийн байдал, төрсөн он, сар,

32 Urs Kindhuser, Kay H. Schumann: Strafprozessrecht, 7. überarbeitete Auflage, 2023, S.325

33 Strafprozeßordnung (StPO), 1950, <https://www.gesetze-im-internet.de/stpo/index.html>, (Сүүлд үзсэн:2025.09.01).

34 Шийдвэр нь ард түмний нэрийн өмнөөс гарна. § 268 Absatz 1 StPO

35 Grundgesetz für die Bundesrepublik Deutschland, GG, 1949, <https://www.gesetze-im-internet.de/gg/BJNR000010949.html>, (Сүүлд үзсэн: 2025.09.01).

36 Lutz Meyer-Goßner, Ekkehard Appl, Theodor Kroschel, Karl Doerner, Die Urteile in Strafsachen, 2021, S.5.

37 Ekkehard Appl, S.36.

өдөр, төрсөн газар, үндэс, угсаа, насанд хүрээгүй хүний хувьд хууль ёсны төлөөлөгчийн мэдээлэл тус тус хамаарна. Шүүгдэгчийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй бичиж байгаа нь **байгууллагууд хоорондоо хавтаст хэргийг дамжуулахгүйгээр шүүгдэгчийн хувийн мэдээллийг тодруулах боломжтой мөн хавтаст хэрэг утсан тохиолдолд уг мэдээллийг шүүхийн шийдвэрийн удиртгал хэсгээс харах боломжтой гэж үздэгтэй холбоотой** байна.³⁸

Мөн энэ хэсэгт шүүгдэгч цагдан хоригдсон бол уг арга хэмжээ авагдсан огноог тэмдэглэнэ. Харин өмнө нь ял шийтгэл хүлээж байсан талаарх мэдээллийг энэ хэсэгт бичихгүй, уг мэдээллийг шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт бичдэг байна. Хэд хэдэн шүүгдэгчтэй хэргийн хувьд шүүгдэгчийн хувийн мэдээллийг бичихдээ яллах дүгнэлтэд бичсэн дарааллыг баримтална.

Удиртгал хэсэгт шүүгдэгчийн холбогдсон хэргийн талаар товч дурдана. Тухайлбал хулгайлах, залилах гэмт хэргийн улмаас гэх зэргээр бичдэг. **Шүүгдэгч хэд хэдэн гэмт үйлдэл хийсэн тохиолдолд хамгийн хүнд ялтай гэмт хэргээс эхлэн бичдэг байна.** Шүүгдэгчийн холбогдсон хэргийн талаар дурдахдаа яллах дүгнэлтээс шууд хуулбарлахгүй байхыг зөвлөдөг.³⁹

Үүний дараа шүүх хуралдаанд оролцсон бусад хүний талаарх мэдээллийг тусгана. Үүнд тухайн хэргийг шийдвэрлэж буй шүүгч, прокурор, өмгөөлөгч, шүүхийн нарийн бичгийн даргын талаарх мэдээлэл хамаарна. Хэрэгт хэд хэдэн прокурор, өмгөөлөгч оролцсон бол бүгдийнх нь мэдээллийг тусгана. Удиртгал хэсэгт шүүх хуралдаан болсон өдрийг тэмдэглэнэ. Шүүх хуралдаан хэд хэдэн өдөр үргэлжилсэн бол шүүхийн шийдвэрийг амаар танилцуулсан өдрийг шүүх хуралдаан болсон өдрөөр тэмдэглэдэг байна.

2. Тогтоох хэсэг

Тогтоох хэсэг нь шүүхийн шийдвэрийн хамгийн чухал хэсэг байдаг. **Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг шүүх хуралдааны**

38 Iwona Jacewicz, S.78.

39 Lutz Meyer-GoЯner, S.6.

шийдвэрийг танилцуулах үеэр хэргийн оролцогчдод аль хэдийн амаар танилцуулсан байдаг учраас шүүхийн шийдвэрийг бичгээр гаргахдаа уншиж сонсгосон агуулгыг өөрчлөхийг хориглодог. Тогтоох хэсгийг бичихдээ богино өгүүлбэрээр бичих бөгөөд хэрэглэх шаардлагагүй үг ашиглахаас татгалзах ёстой. Мөн тогтоох хэсгийг тодорхой, ойлгомжтой бичих, хэт уянгын халилтай үгээр найруулан бичдэггүй.

Шийтгэх тогтоолын тогтоох хэсэг нь шүүгдэгчийн гэм буруугийн талаарх дүгнэлт хэсэг бөгөөд дараах 3 хэсгээс бүрдэнэ:

- 1) Гэм буруутай эсэх;
- 2) Эрх зүйн үр дагавар;
- 3) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал.

Гэм буруутай эсэх: Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ямар гэмт хэрэг үйлдсэн талаар мөн уг гэмт хэргийг нэг үйлдлээр эсвэл нийлмэл үйлдлээр үйлдсэн эсэхийг тодорхой бичдэг.

Жишээ: Шүүгдэгч бусдын бие махбодод гэмтэл учруулах болон хууль сахиулах байгууллагын ажилтанд халдах нийлмэл гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай байна.

Эрх зүйн үр дагавар: Шүүхээс оногдуулсан үндсэн ялын төрөл, хэмжээг дурдана. Нэмэгдэл ял оногдуулсан бол мөн төрөл, хугацааг тусгана. Харин шүүгдэгчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаар энэ хэсэгт тусгахгүй.

Жишээ: Шүүгдэгчийг нэг жилийн хорих ялаар шийтгэв. Оногдуулсан ялыг тэнсэв.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал:⁴⁰ Анхан шатны шүүхээс шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай гэж үзсэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал, бусад шаардлагатай зардлыг шүүгдэгч хариуцна.

40 Шүүхийн шийдвэр, захирамж, мөрдөн шалгах ажиллагааг хаах шийдвэрт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг хэн төлөх талаар тусгана. § 464 Abs 1 StPO

3. Шүүхийн шийдвэрт хэрэглэсэн хуулийн зохицуулалт

Шүүхээс цагаатгах тогтоол гаргаж байгаа тохиолдолд шийдвэрт ашигласан зохицуулалтыг дурдахгүй, зөвхөн шийтгэх тогтоолд уг жагсаалтыг дурддаг. Жагсаалтыг дурдаж байгаа нь Холбооны төв бүртгэлд шүүгдэгч хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр ял шийтгэл хүлээсэн талаарх мэдээллийг оруулах зорилготой байна.⁴¹

Уг жагсаалт нь удиртгал эсвэл шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт хамаардаггүй, бичгээр гаргасан шүүхийн шийдвэрийн бие даасан хэсэг хэмээн үздэг байна. Шийдвэрт ашигласан бүх хуулийн зүйл, заалтыг тоочин жагсаана. **Ингэхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн хүнд ангилалд хамаарах зүйл, заалтаас эхлэн хөнгөрүүлэх зүй тогтлоор дурдана.** Дараа нь мөн эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан гэмт хэргийн гүйцэтгэгч, хамтран оролцогчтой холбоотой заалтууд, хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах журмын заалтуудыг дурдаж, үүний дараа бусад зэрэгцээ Эрүүгийн хуульд хамаарах хуулиудыг (жишээ нь Татварын тухай хууль, Мансууруулах бодисын эргэлтийн хууль гэх мэт) бичнэ. Хуулийн зохицуулалтыг бичихдээ зүйл, хэсэг, заалт, өгүүлбэрээр зэргээр нь тодорхой бичдэг.

Жишээ: Ашигласан Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалтууд: §§113 Abs.1, Abs.2 Nr.2, 185, 223 Abs.1, 52, 53 StGB, §29 Abs.1 Nr.3 BtMG (Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн №2, 185 дугаар зүйл, 223 дугаар зүйлийн 1, 52 дугаар зүйл, 53 дугаар зүйл, Мансууруулах бодисын эргэлтийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн №3).

4. Шийдвэрийн үндэслэл

Эрүүгийн процессын хуулийн 267 дугаар зүйлд “Шүүхийн шийдвэрийн үндэслэл”-ийн талаар хуульчилсан бөгөөд уг зүйл, заалт нь Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон “шүүхийн шийдвэрийн

41 Kindhduser, S.325.

үндэслэлийг бичих үүргийг өргөжүүлсэнтэй холбогдуулан хууль тогтоогчоос олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.⁴²

Хуульд шүүхийн шийдвэрийн үндэслэлийг 2 хэлбэрээр танилцуулахаар заасан. Тодруулбал, шүүх хуралдааны дараа амаар шийдвэрийн үндэслэлийг танилцуулах,⁴³ үүний дараа бичгээр шийдвэрийн үндэслэлийг гардуулан өгнө. Шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдал шийдвэрийг уншиж сонсгосноор бий болдог бол шүүх тухайн шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай гэж дүгнэсэн үндэслэлийг зөвхөн бичгээр гаргаж буй шүүхийн шийдвэрт тусгадаг. Иймээс бичгээр гаргасан шүүхийн шийдвэрт тайлбарлаж байгаа шийдвэрийн үндэслэл амаар танилцуулсан шүүхийн шийдвэрийн үндэслэлийг нэмсэн мөн өөрчилсөн байж болно.⁴⁴ Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэг нь иргэний процессоос ялгаатай нь зөвхөн яллах дүгнэлтэд тусгасан хүрээгээр хязгаарлагддаг.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэг нь дотроо ямар бүтэцтэй байх, ямар шаардлагыг хангасан байх талаар Эрүүгийн процессын хуульд заасан (§ 267) -аас гадна тухайн улсын эрүүгийн шүүхийн практикт тогтсон шаардлагуудыг багтаадаг. Тэр дундаа шүүхээс шийтгэх тогтоол гарч байгаа тохиолдолд хэрэгт шинжлэн судалсан бүх нотлох баримтыг тусгадаг. Ингэснээр уг шийдвэрт давж заалдах гомдол гаргасан тохиолдолд дээд шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг хянах боломжтой гэж үздэг байна.⁴⁵

Шүүхийн шийдвэрт гомдол гаргасан тохиолдолд дээд шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсгийг хянадаг учраас уг хэсэг нь ойлгомжтой, тодорхой бичигдсэн байх ёстой. Шийдвэрийг уншиж буй хүн хавтаст хэрэгт авагдсан баримтууд тухайлбал, шүүх хуралдааны тэмдэглэл зэргийг харахгүйгээр шүүхийн шийдвэрийн үндэслэлд тулгуурлан уг үндэслэл нь тогтоох

42 Jurg-Peter Becker, S.551.

43 § 268 Absatz 2 StPO

44 Kindhduser, S.326.

45 Kindhduser, S.326.

хэсгийг дэмжиж байгаа эсэхийг дүгнэх боломжтой байх ёстой.⁴⁶ Харин хэрэгт авагдсан зургийг (гер. Abbildung) хавтаст хэргээс харахыг зөвшөөрнө хэмээн Эрүүгийн процессын хуулийн 267 дугаар зүйлд заасан.

Шийдвэрийн үндэслэл бичих хэлбэрийн хувьд мэргэжлийн үг хэллэгээр бичихийг зөвшөөрдөг. Гэхдээ шийтгэх тогтоол нь хүний эрхэд ноцтойгоор нөлөөлдөг, төрийн бүрэн эрхэд хамаарах үйлдэл гэдгийг харуулах үүднээс шийдвэрийн үндэслэлд ашигласан үгийн сонголт, найруулга нь мэргэжлийн болон объектив байх ёстой гэж үздэг байна.⁴⁷

Шийдвэрийн үндэслэл ойлгомжтой бичигдэх талаар хуульд заасан ч тухайн баримт бичгүүд нь хавтаст хэрэгт байгаа тохиолдолд бүтнээр нь эсвэл зарим хэсгийг иш татахыг хориглоно. Мөн яллах дүгнэлтийн хэсгээс шууд шүүхийн шийдвэрийн үндэслэлд оруулахыг хориглодог.⁴⁸ Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой байх шаардлагын хүрээнд хавтаст хэрэгт байгаа тойм зураг болон гэрэл зургийг дурдаад өнгөрөхийг зөвшөөрдөггүй, харин эдгээрийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй тусгадаг. Гэхдээ хууль тогтоогч хавтаст хэрэгт байгаа зургийг шийдвэрийн үндэслэлд иш татах байдлаар оруулах боломжийг олгосон байна.⁴⁹ Өмнө нь зургийг шийдвэрийн үндэслэлд иш татахгүйгээр нарийвчлан тайлбарлаж бичдэг байсан ч үүнийг хялбарчлах мөн үндэслэл хэсгийн бичилтийг багасгах зорилгоор хавтаст хэрэгт байгаа зургийг иш татдаг болжээ. Хуульд хавтаст хэрэгт тусгасан зургийг шүүхийн шийдвэрийн үндэслэлд хэрхэн иш татах талаар тусгаагүй ч тухайн зургийг хавтаст хэргийн хаана байгаа талаар тодорхой дурдах ёстой байдаг.

46 Steffen Breyer, Koblenz, Volkmar Mehle, Bonn: Strafprozessrecht, 2005, S.217.

47 Jurg-Peter Becker, Volker Erb, Robert Esser, Kirsten Graalman-Scheerer, Hans Hilger, Alexander Ignor: Die Strafprozeßordnung und das Gerichtsverfassungsgesetz, Großkommentar, 27 nd. ed, 2021, S. 560.

48 Großkommentar, S.562.

49 § 267 Abs 1 Satz 1 StPO

Шийдвэрийн үндэслэл хэсэг нь дараах бүтцээс бүрдэх бөгөөд хэсэг бүрийг нь Ром тоогоор дугаарлан бичнэ:

- I. Шүүгдэгчийн хувийн байдлыг тогтоох
- II. Хэргийн үйл баримтыг тогтоох
- III. Нотлох баримтыг үнэлэх
- IV. Эрх зүйн дүгнэлт
- V. Ял оногдуулах үндэслэл

Шийдвэрийн үндэслэл хэсгийг дээрх байдлаар хуваан авч үзсэнээр шийдвэр ойлгомжтой байх шаардлагыг хангадаг гэж үздэг.

1) Шүүгдэгчийн хувийн байдлыг тогтоох

Шийдвэрийн үндэслэл хэсэгт нь шүүгдэгчийн хувийн байдлыг тогтоох хэсгээр эхлэх бөгөөд шүүгдэгчийн төрсөн он, сар, өдөр, мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн байдал, эрүүл мэндийн байдал, гэр бүлийн байдал, эдийн засгийн байдал, өмнө нь ял шийтгэл хүлээж байсан эсэх, гэмт хэрэг үйлдэхээс өмнөх болон дараах зан байдал зэрэг мэдээллийг нарийвчлан тусгана. Эрүүгийн процессын хуулийн 267 дугаар зүйлд заасан шийдвэрийн үндэслэлд шүүгдэгчийн хувийн байдлыг нарийвчлан тусгах талаар дурдаагүй ч энэ төрлийн мэдээллийг шийдвэрийн үндэслэл хэсэгт оруулснаар шүүгдэгчийн гэм бурууд тохирсон ял оногдуулах, цаашлаад ялын нийгэмшүүлэх зорилгыг хангана гэж үздэг байна.⁵⁰

2) Хэргийн үйл баримтыг тогтоох

Хэргийн үйл баримтын талаарх тайлбар нь шүүхийн шийдвэрийн чухал хэсэг бөгөөд тодорхой бичигдсэн байх ёстой гэсэн шаардлагыг тавьдаг байна. Энэ хэсэгт Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг хангасан талаар дэлгэрэнгүй, харин шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдэхээс өмнө нь болон дараах зан байдлыг товч байдлаар дурддаг. Шүүгдэгч гэмт хэрэг үйлдэх болсон шалтгааныг тодруулах үүднээс түүний гэмт хэрэг үйлдэхээс өмнө болон дараах нөхцөл байдлын талаар шүүхийн шийдвэрт бичих нь зүй ёсны боловч зарим

50 Manfred Heinrich: Deutsches Strafverfahrensrecht. 2nd ed, 2018. S.427.

шүүхийн шийдвэрт хэт урт агуулга бүхий олон хуудсанд энэ талаарх мэдээллийг бичсэн байх тохиолдол байдаг байна. Энэ нь шүүгч зайлшгүй шаардлагатай болон шаардлагагүй мэдээлэлд оюун дүгнэлт хийж чадаагүйг харуулдаг хэмээн зарим эрдэмтэд шүүмжилжээ.⁵¹

Шүүх хэргийн үйл баримтыг тогтоохдоо шийдвэрийн үндэслэл болж буй баримтыг тусгах ёстой. Шүүх хэргийн нөхцөл байдлыг тайлбарлахдаа гэмт хэргийн объектив, субъектив талд тулгуурлан дүгнэлтээ гаргана. Гэмт хэргийн объектив талд гэмт хэрэг үйлдсэн газар, хугацаа, хамтран оролцогч, хохирогч, хохирлын хэмжээг нотлох баримтад тулгуурлан тогтоосон байх ёстой. Гэмт хэргийн субъектив талд гэмт хэрэгтний гэмт санааг тогтоох ёстой. Санаатай гэмт хэргийн хувьд гэмт санааг тайлбарлах нь хүндрэлтэй байдаг. Тиймээс шүүх хэргийн нөхцөл байдал, шүүгдэгчийн зан харьцааг тайлбарлах замаар шүүгдэгч тухайн гэмт хэргийг хүсэж болон мэдэж үйлдсэн гэдгийг харуулах ёстой. Тухайлбал, Эрүүгийн хуулийн⁵² тусгай ангийн 316 дугаар зүйлд заасан согтуурсан буюу мансуурсан үедээ замын хөдөлгөөнд оролцох гэмт хэрэгт шүүгдэгч машин жолоодох чадваргүй болохоо мэдэж байсан эсэхийг хэргийн нөхцөл байдал, шүүгдэгчийн зан харьцааг тайлбарлах замаар дүгнэлт хийж болно.⁵³

Жишээ: Шүүгдэгч нь 2004 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр буурчийн газар их хэмжээний согтууруулах ундааны зүйл хэрэглэж 22 цаг 45 минутад уг буурчийн газраас гарсан. Түүнийг ... улсын дугаартай автомашиныг жолоодон гэр лүүгээ явж байхад цагдаа зогсоожээ. Түүний цусан дахь спиртийн агууламж 2.1 промилль гарсан байна. Шүүгдэгч машин жолоодох чадваргүй байснаа мэдэж байсан. Учир нь тэрээр буурчийн газраас гараад хэд хэдэн удаа шургаж унасан мөн гэрч Х болон Ү нар шүүгдэгчийн согтууруулах ундааны зүйл их хэрэглэсэн хэмээн мэдүүлжээ.

51 Ekkehard Appl, S.43.

52 Strafgesetzbuch (StGB), 1871, <https://www.gesetze-im-internet.de/stgb/index.html>,

53 Steffen Breyer, S.218.

Гэмт санааг тайлбарлахад өөр анхаарах асуудал нь тухайн гэмт хэргийн шинжээс хамааран гэмт санааг өргөн хүрээнд эсвэл товч байдлаар тайлбарлах эсэхийг шүүгч шийдвэрлэдэг байна. Банк дээрэмдэх, хулгайлах зэрэг санаатай гэмт хэрэгт шүүгдэгчийн гэмт санааг тайлбарлахад хүндрэл үүсдэггүй бол зарим гэмт хэргийн хувьд хүндрэлтэй байдаг. Жишээлбэл, Шүүгдэгч хохирогчийн цээжин хэсэг рүү хутгаар хатгасан гэх үйл баримтын хувьд тэрээр хохирогчид гэмтэл учруулах санаатай байсан эсвэл алах санаатай байсан эсэхийг заавал хэлэлцэх, тогтоосон байхыг шаарддаг байна.

3) Нотлох баримтыг үнэлэх

Шүүх дээр дурдсан хэргийн нөхцөл байдлыг зөв тогтоосон гэдгийг өөрийн дотоод итгэл үнэмшлээр нотлох баримтыг үнэлэх замаар бататгах бөгөөд нотлох баримт үнэлэх хэсэгт гэмт хэргийн шинж нь нэг эсвэл хэд хэдэн нотлох баримтаар нотлогдсон эсэх асуултад хариулах байдлаар хийнэ. Шүүхийн шийдвэрт нотлох баримт бүрийг бичих шаардлагагүй, зөвхөн ач холбогдолтой гэж үзсэн хэсгээ тусгадаг байна. Тухайлбал, гэмт хэрэг гарах үед хэргийн газрын ойролцоо явж байсан, гэмт хэрэг гарсны дараа шүүгдэгч их хэмжээний зардал гаргасан учраас шүүгдэгчийг хулгайлах гэмт хэрэгт гэм буруутай хэмээн үзэх тохиолдолд эдгээр баримтуудыг дурдах шаардлагатай.⁵⁴

Нотлох баримт үнэлэх ажиллагаа нь **шүүгдэгчийн мэдүүлгээр эхлэх** бөгөөд шүүгдэгч хэргийн талаар мэдүүлэг өгсөн бол гэм буруугаа хүлээсэн эсэхээс үл хамааран эхлээд үндэслэл хэсэгт энэ талаар дурдана. Шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрөөгүй бол шүүх яагаад шүүгдэгчийн мэдүүлгийн эсрэг байгаагаа гэмт хэрэгт хамтран оролцогчийн мэдүүлэг, гэрчийн мэдүүлэг, хэрэгт авагдсан бусад нотлох баримтыг бүхэлд нь үнэлэх замаар тайлбарлана. Ингэхдээ гэрчийн мэдүүлгийг хуулбарлах шаардлагагүй байдаг.⁵⁵ Шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол шүүх “шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн. Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн

54 Steffen Breyer, S 221.

55 Steffen Breyer, S 220.

нь үндэслэлтэй байна. Учир нь...” гэх зэргээр ийм шийдвэрт хүргэх болсон дотоод итгэлийг нотлох баримтад тулгуурлан тайлбарлаж бичнэ.

Жишээ: Р, С, Т нарын гэрчийн мэдүүлэг, эд мөрийн баримтаар авагдсан зураг (Bl. 18-19, 107-111 д.А.)56-т үндэслэн тогтоов.

1. хохирогчийн тайлбарласан нүүр болон мөрөнд үүссэн гэмтэл хавтаст хэрэгт авагдсан зурагтай таарсан бөгөөд гараар цохих болон алгадах үед иймэрхүү төрлийн гэмтэл үүсдэг учраас хохирогчид гэмтэл үүссэн гэж шүүх дотоод итгэлтэй болов. Мөн хохирогчийн гэрт очиход тэрээр нүүрэн хэсэг болон мөр хэсэг дээр харагдахуйц гэмтэлтэй байсан талаар гэрч С, Т нар мэдүүлсэн байна.

2. ...

Эргэлзээтэй тохиолдолд шүүгч шүүгдэгчийн талд шийдвэр гаргах ёстой – in dubio pro geo. Гэхдээ энэ нь шүүх нотлох баримтыг үнэлж дууссаны дараа бүрэн ял оноох боломжгүй тохиолдолд л мөрдөх ёстой шийдвэрийн дүрэм юм.

4) Эрх зүйн дүгнэлт хийх

Эрх зүйн дүгнэлт хэсэг нь шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэсэн өгүүлбэрээр эхэлж тухайн гэмт хэргийн шинжийг хэрхэн хангасан талаар бичдэг байна. Өөрөөр хэлбэл, шүүгдэгч Эрүүгийн хуульд заасан ямар гэмт хэргийн шинжийг хангасан талаар бичдэг байна.

Жишээ: Шүүгдэгчийг эд зүйл гэмтээх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэв. Шүүгдэгч нь хууль бусаар бусдын эд зүйлийг эвдэлж, гэмтээсэн байх тул Эрүүгийн хуулийн 303 дугаар зүйлийн 1, 303с дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдүүнийг хангасан байна. Шүүгдэгч хохирогч В-ийн гэрт байрлуулсан тавилга, телевиз,

56 Хавтаст хэргийн аль хэсэгт байгааг дурдаж буй тэмдэглэгээ.

эд хогшлыг эвдэлж, ашиглах боломжгүй болгожээ. Хохирогч шүүгдэгчид тухайн эд зүйлийг гэмтээхийг зөвшөөрөөгүйг мэдсээр байж эд зүйлийг гэмтээсэн нь санаатай үйлдэл байна. 2013 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Эрүүгийн хуулийн 303с дугаар зүйлд заасан эд зүйл гэмтээх гэмт хэрэгт холбогдуулан хохирогч гомдол гаргасан.

5) Ял оногдуулах үндэслэл

Ял оногдуулах үндэслэлийн талаар Эрүүгийн процессын хуулийн 267 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шийдвэрийн ял шийтгэлийн үндэслэл хэсэгт эрүүгийн хуулийн хэрэглэсэн заалт болон ял оногдуулахад баримталсан нөхцөлийг тусгана” хэмээн заажээ. Уг зохицуулалт нь шүүх ял шийтгэл оногдуулахад баримталсан бүх нөхцөл байдлыг энэ хэсэгт дурдахыг шаарддаггүй, зөвхөн ач холбогдолтой гэж үзвэл нөхцөлүүдийг дурдахад хангалттай гэж үздэг байна.⁵⁷ Мөн шүүгдэгчийн хувийн байдлыг энд дурдах талаар хуульд заагаагүй байна. Гэхдээ практикт шүүгдэгчийн хувийн байдал, эдийн засгийн байдал болон бусад байдлыг дурдахгүй байх нь ял шийтгэл гэм бурууд тохирсон байх, шүүгдэгчийг нийгэмшүүлэх ялын зорилгод дүгнэлт хийх боломжгүйд хүрэх болох учраас тусгах нь зүйтэй гэсэн байр суурь давамгайлдаг байна. Шүүгч ялын төрөл, хэмжээг тогтооход эхлээд Эрүүгийн хуульд заасан тусгай эсвэл хүндрүүлэх тохиолдол байгаа эсэхийг шалгана. Тусгай хүндрүүлэх тохиолдол гэдэгт Эрүүгийн хуулийн 243 дугаар зүйл Онц ноцтой хулгай, 253 дугаар зүйлийн 4-т заасан албадлага үзүүлэх зэрэг гэмт хэрэг, хүндрүүлэх тохиолд гэдэгт Эрүүгийн хуулийн 213 хүний амь насыг хөнөөх гэмт хэргийн хүндэвтэр тохиолдол, 250 дугаар зүйлийн хүнд хэлбэрийн дээрэм, 213 хүний амь насыг хөнөөх гэмт хэргийн хүндэвтэр тохиолдол зэрэг хамаарна. Шүүхийн шийдвэрт шүүх хүндэвтэр тохиолдол байгаа эсэхийг шалгасан гэдгээ дурдах ёстой байдаг. Мөн шүүгдэгч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах журмыг хэрхэн ашигласны дурддаг байна.

⁵⁷ GroЯkommentar, S. 594

5. Шүүгч гарын үсэг зурах

Шүүхийн шийдвэрт хэргийг шийдвэрлэсэн шүүгч гарын үсэг зурна. Хэргийг шүүх бүрэлдэхүүнээр (нэг мэргэжлийн шүүгч, хоёр иргэдийн төлөөлөгч (гер. Schöff)) шийдвэрлэсэн бол зөвхөн мэргэжлийн шүүгч гарын үсэг зурж баталгаажуулдаг байна. Шийдвэр гаргасан шүүгч өвчний улмаас чөлөө авсан, өөр газар сэлгэн ажиллаж байгаа зэрэг шалтгааны улмаас байхгүй байгаа тохиолдолд уг шалтгааныг дурдсан тэмдэглэл бичдэг. Тэмдэглэлийг шүүхийн дарга, түүний эзгүйд хамгийн олон жил шүүгчээр ажилласан шүүгч бичнэ.⁵⁸

3. ЯПОН УЛС

Шүүхийн шийдвэрийг бичгээр үйлдэх нь шүүхийн шийдвэрийн агуулгыг нотлох баримт бичгийн хувьд чухал ач холбогдолтой бөгөөд шийдвэрийг гүйцэтгэхэд бичгээр үйлдсэн шүүхийн шийдвэр шаардлагатай.⁵⁹ Түүнчлэн, Res judicata⁶⁰ зарчимд хамаарах хэргийг тогтооход үндсэн эх сурвалж болохоос гадна шүүхийн шийдвэрт гомдол гаргасан тохиолдолд шүүхийн шийдвэрийг хянахад суурь эх сурвалж болдог.⁶¹ Япон Улсад эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр ямар агуулгатай бичигдэх талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (1948),⁶² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам (1948)⁶³-д тус тус заасан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (яп.刑事訴訟法) -д зааснаар шүүхийн шийдвэр нь дараах агуулгатай байна.

- “Шүүхийн шийдвэрт үндэслэх хэсгийг заавал бичих шаардлагатай” (44 дүгээр зүйлийн 44.1);

58 Kindhuser, S. 326.

59 司法研修所編『刑事判決書記案の手引』(法曹会・2007年)

60 Шүүхээр нэгэнт хянан шийдвэрлэгдсэн маргааны талаар шүүхэд дахин маргахгүй гэсэн утгыг илэрхийлэх процессын эрх зүйн ойлголт.

61 司法研修所編『刑事判決書記案の手引』(法曹会・2007年)

62 Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1948
<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000131>

63 Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, 1948
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3893/ja>

- “Гомдол гаргах эрхгүй шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид үндэслэл хэсэг бичихийг шаардахгүй. Гэхдээ тус хуулийн 428 дугаар зүйлийн 428.2⁶⁴ дахь хэсгийн дагуу гомдол гаргаж болох шүүхийн тогтоолд үндэслэл хэсгийг заавал бичнэ” (44 дүгээр зүйлийн 44.2);
- “Гэм буруутай гэсэн шийдвэр гаргах тохиолдолд гэмт хэргийн шинжид хамаарч байгаа үйл баримт, нотлох баримтын жагсаалт болон хууль хэрэглээг заах ёстой” (335 дугаар зүйлийн 335.1);
- “Хуульд заасан гэмт хэргийн нөхцөлийг үгүйсгэх эсхүл ялыг хөнгөрүүлэх үйл баримт байгаа тохиолдолд шүүх үүний талаарх дүгнэлтийг тусгана” (335 дугаар зүйлийн 335.2).

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид “ЭХХШтХ” гэх)-ийн 44 дүгээр зүйлд заасан **“шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэг” нь шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг бичих үндэслэл болдог.** Иймээс шийдвэрийн үндэслэл хэсэгт тогтоох хэсэгт дурдсан шийдвэр болгоны үндэслэлийг тодорхой бичих шаардлагатай.⁶⁵ Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг нь ЭХХШтХ-ийн 335 дугаар зүйлд заасан нөхцөлөөр хязгаарлагдахгүй бөгөөд тус зүйлийн 335.2-т заагаагүй тайлбарыг талууд гаргасан тохиолдолд энэ талаар шүүхийн шийдвэрт бичих эсэх, ямар хэмжээнд бичих эсэх нь шүүхийн бүрэн эрхэд хамаарна.⁶⁶

Түүнчлэн тус хуулийн 378 дугаар зүйлд заасны дагуу анхан шатны шүүхийн шийдвэрт үндэслэл дурдаагүй, эсхүл үндэслэл хэсэгт бичигдсэн зүйлс зөрүүтэй гэсэн үндэслэлээр давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах тохиолдолд, уг үндэслэл байгаа гэж үзэхэд хангалттай баримт нотолгоог гомдолд иш татах ёстой.

64 Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 428.2 “Давж заалдах шатны шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхтэй, мөн энэ хуулийн 419 болон 420 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргах боломжтой бол давж заалдах шатны шүүхэд эсэргүүцэл гаргаж болно”.

65 司法研修所編『刑事判決書起案の手引』(法曹会・2007年)

66 Мөн тэнд.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам⁶⁷ (яп. 刑事訴訟規則)-ийн 53 дугаар зүйл “Хэргийг хянан шийдвэрлэсэн тохиолдолд шүүхийн шийдвэрийг бичгээр заавал үйлдэх ёстой. Гэхдээ шүүхийн тогтоол эсвэл шүүгчийн захирамжийг танилцуулан сонсгох тохиолдолд шүүхийн шийдвэрийн хэлбэрээр биш шүүх хуралдааны тэмдэглэл хэлбэрээр бичиж болно” гэж зааснаас үзвэл хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр заавал бичгээр үйлдэгдэх ёстой байдаг байна.

Шүүхийн шийдвэрийн дарааллын талаар заасан тухайлсан заалт байхгүй боловч эхлээд шүүгдэгчийн ерөнхий мэдээллийг дурдсаны дараа удиртгал хэсэг, тогтоох хэсэг, үндэслэх хэсэг, шүүхийн шийдвэрийг бичсэн он сар өдөр, шүүхийн нэр, шүүгч эсхүл шүүх бүрэлдэхүүний нэрс гэсэн дарааллаар бичих нь нийтлэг байна.⁶⁸

Шигтгээ №2. Япон Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Шийтгэх тогтоолын бүтэц:

- 1) Удиртгал хэсэг;
- 2) Тогтоох хэсэг;
- 3) Үндэслэх хэсэг.

Шүүхийн шийдвэрийг аман ярианы хэллэг ашиглан бичих боловч найруулга зүйн хувьд өндөр шаардлага тавигдана. Жишээ нь нуршсан үг, хэллэг ашиглахгүй байх, албан ёсны үг хэллэг ашиглах, цифр бичих тохиолдолд нэг бичсэн техникээ хадгалах, цэг таслал болон холбоос үгийг өгүүлбэрт зөв ашиглах шаардлагатай.

Шүүхийн шийдвэр нь өндөр түвшинд алдаагүй бүрэн бичигдсэн байх шаардлагатай учраас санаандгүй алдаа гаргахаас зайлсхийх ёстой. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 59 дүгээр зүйлд зааснаар шүүхийн шийдвэрт үг хэллэг нэмсэн, хассан эсхүл захын хэсэгт нэмэлт оруулах гэх зэргээр өөрчлөлт оруулсан бол ойлгомжтой байлгахын тулд тухайн зассан хэсэгт тамга дардаг байна.

67 Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, 1948

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3893/ja>

68 司法研修所編『刑事判決書起案の手引』(2007年) 2頁。

Шүүхийн шийдвэрийн бүтцэд хамаарах хэсгүүдийг дэлгэрүүлэн авч үзвэл:

1. Удиртгал хэсэг

Энэ хэсэгт “Удиртгал” гэсэн гарчиг бичихгүйгээр дараах мэдээллүүдийг бичдэг.⁶⁹ Үүнд:

- Шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосон он сар өдөр;
- Хэргийн дугаар;
- Шүүхийн шийдвэр (Үүнийг дунд хэсэгт бичнэ);
- Шүүгдэгчийн биеийн байцаалт (ургийн харьяалал⁷⁰, оршин суугаа хаяг, эрхэлж буй ажил, овог нэр, нас)
- Шүүгдэгчийн холбогдсон эрүүгийн хэргийн товч агуулга

Тэгэхдээ аль мужийн анхан шатны шүүх гэдгээс хамааран дээрх дараалал ялгаатай байдаг. Түүнчлэн шүүгдэгчийн биеийн байцаалтыг дурдаагүй, эрүүгийн хэргийн товч агуулга хэсэгт шүүгдэгч, прокурорыг дурдалгүй зөвхөн ямар эрүүгийн хэрэг болохыг дурдсан шүүхийн шийдвэрүүд түгээмэл харагдаж байна.⁷¹

2. Тогтоох хэсэг

Шүүгдэгчид оногдуулсан ялын хэмжээг бичихдээ Эрүүгийн хуульд заасан ямар гэмт хэрэг үйлдсэн учир ийм төрлийн ялын хэмжээг оногдуулсан болохыг дурддаггүй. Жишээ нь Шүүгдэгчид 3 жилийн хорих ял оногдуулав. Эрүүгийн хуульд заасан ямар гэмт хэрэг үйлдсэн учир ийм төрлийн ялын хэмжээг оногдуулсан болох үндэслэлийг шийдвэрийн үндэслэх хэсэгт дурддаг.

Түүнчлэн тогтоох хэсэгт шүүгдэгчид оногдуулах ялын хэмжээнээс гадна хэрэгт хамаарах бусад шийдвэрийг тусгана. Жишээ нь “Цагдан хоригдсон 1 сарын хугацааг үндсэн ялын хугацаанд нэгтгэн тооцов. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 5 хүртэлх жилийн

69 Мөн тэнд, 6-11 дахь тал.

70 Ургийн харьяалал (яп. 本籍) гэдэг нь оршин суугаа хаягаас ялгаатай. Жишээ нь А гэдэг хүний оршин суугаа хаяг Айчи мужийн Нагояа хотын Шоова дүүрэг бол, ургийн харьяалал нь Хоккайда мужид бүртгэлтэй.

71 Дэлгэрэнгүйг доорх хэсгээс үзнэ үү:
https://www.courts.go.jp/app/hanrei_jp/list4?page=2&sort=1&filter%5Btext%5D=%E6%AE%BA%E4%BA%BA&filter%5BcourtType%5D=%E5%9C%B0%E6%96%B9 (Сүүлд үзсэн: 2025.08.29)

хугацаагаар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, шүүгдэгч эрх бүхий байгууллагын хяналтад байна. Шүүхийн зардлыг шүүгдэгч хариуцна”. Ял оногдуулахгүй тэнсэх шийдвэр гаргах тохиолдолд тэнсэх тухай дурдсан хэсгийн өмнөх хэсэгт заавал үндсэн ялын хэмжээг дурддаг.

Шүүгдэгч нь 2 ба түүнээс дээш байгаа тохиолдолд оногдуулах ялын хэмжээ хамгийн хүнд этгээдээс эхлэн дараалуулан бичдэг.⁷²

3. Үндэслэх хэсэг

Шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт шийдвэрийн тогтоох хэсэгт яагаад ийм шийдвэр бичигдэх болсон үндэслэлийг нарийвчлан дурддаг. Энэхүү хэсэг нь:

- 1) Шүүхээс тогтоосон үйл баримт;
- 2) Нотлох баримт;
- 3) Эрүүгийн хариуцлага өмнө нь хүлээж байсан эсэх;
- 4) Хууль тогтоомжийн хэрэглээ;
- 5) Ял оногдуулахад харгалзан үзсэн хүчин зүйлс гэсэн дарааллын дагуу бичигддэг. Түүнчлэн эдгээрийг дэд гарчиг болгон бичих нь түгээмэл.

1) Шүүхээс тогтоосон үйл баримт

Шийдвэрийн үндэслэх хэсэгт доорх дарааллын дагуу үйл баримтуудыг дурддаг.

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 335 дугаар зүйлд заасан үйл баримтуудыг дурдана. Эдгээр нь шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн эсэхийг нотлоход ач холбогдолтой.
 - Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн⁷³ болон ял оногдуулахад хамаарах үйл баримтууд;
 - Гэм буруугийн санаатай болон болгоомжгүйд хамаарах үйл баримт;

72 司法研修所編『刑事判決書起案の手引』(法曹会・2007年)

73 Японд гэмт хэргийн 2 бүрэлдэхүүнтэй онолыг баримталдаг.

- Гэмт хэргийн завдалтад хамаарах үйл баримт;
 - Хамтран гэмт хэрэг үйлдсэн эсэхэд хамаарах үйл баримт;
 - Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл.
 - Хэрэг хариуцах чадвар (сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдол, гэмтлийн дараах стрессийн эмгэг (Post-traumatic stress disorder) гэх мэт)
2. Гэмт хэргийн сэдэлтийг товч дурдана. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд сэдэлтийг дурдах шаардлагагүй.
3. Хүнийг алах, галдан шатаах гэх мэт хүнд гэмт хэрэгт шүүгдэгчийн ажил мэргэжил эрхэлдэг, эрхэлж байсан болон гэмт хэрэг үйлдэх хүртэлх нөхцөл байдлыг дурдаж болох ч дийлэнх тохиолдолд энэ талаар дурддаггүй. Эдгээр нөхцөлийг дурдах тохиолдолд үйл баримтын эхний хэсэгт товчхон дурдана.
4. Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байгаа тохиолдолд дурдана.

Үндэслэх хэсэгт шүүхээс тогтоосон үйл баримтыг ойлгомжтой бичихээс гадна хэзээ, хаана, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан арга хэрэгсэл зэргийг тодорхой дурдана.⁷⁴

2) Нотлох баримт

Хэрэгт ач холбогдолтой нотлох баримтыг жагсаалт хэлбэрээр дурддаг. **Жагсаалтад дурдагдах нотлох баримтууд нь нотолгооны чадвартай бөгөөд шүүхээр шинэчлэн судалсан нотлох баримт байх шаардлагатай.**⁷⁵ Нийтэд илэрхий нотлох баримт байх тохиолдолд үндэслэл хэсэгт дурдах шаардлагагүй. Шууд бус нотлох баримтаар хэргийн үйл баримтыг тогтоох тохиолдолд нэмэлт тайлбар бичнэ.⁷⁶

Давхардсан агуулгатай нотлох баримтуудыг нэг бүрчлэн дурдах тохиолдол практикт байдаг боловч аль болох нотолгооны чадвар хамгийн их нотлох баримтыг зөвхөн дурддаг.⁷⁷

⁷⁴ 司法研修所編『刑事判決書起案の手引』（法曹会・2007年）26頁～33頁。

⁷⁵ Мөн тэнд.

⁷⁶ Мөн тэнд, 34 дэх тал.

⁷⁷ Мөн тэнд, 35 дахь тал.

3) Эрүүгийн хариуцлага өмнө нь хүлээж байсан эсэх

Энэ хэсэгт шүүгдэгч өмнө нь эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх, эсхүл тэнсэн харгалзах хугацаа байгаа эсэхийг дурддаг. Харин өмнө нь эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тохиолдолд энэ хэсгийг дурдахгүй.

4) Хууль хэрэглээ

Шүүхээс тогтоосон үйл баримт нь ямар гэмт хэрэгт хамаарах, мөн тус гэмт хэрэгт ямар ял оногдуулах эсэхийг хууль хэрэглэн ойлгомжтой бичих шаардлагатай.⁷⁸ Үндэслэх хэсэгт хуулийн хэрэглээг бичихдээ үргэлжилсэн өгүүлбэрийн хэлбэр (яп.文章体) -ээр, эсхүл хэрэглэх хуулийн хэм хэмжээг доош цувуулан бичсэний дараа үйл баримттай холбон дэлгэрэнгүй бичих арга (яп.羅列式)-ийг ашигладаг.⁷⁹ Сүүлийн аргыг шүүхийн шийдвэрт түгээмэл ашиглаж байна.

Шүүхээс тогтоосон үйл баримтад тулгуурлан хууль хэрэглэх үед эхлээд гэмт хэргийн бүрэлдэхүүн хангагдсан эсэх талаар авч үзэх бөгөөд үүний дараа ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал байгаа эсэх талаар авч үздэг.⁸⁰

5) Ял оногдуулахад харгалзан үзэх хүчин зүйлс

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгийн төгсгөлд тогтоох хэсэгт заасан ялыг оногдуулахад харгалзан үзсэн нөхцөл байдлуудыг бичдэг.

4. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС (БНСУ)

Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид “БНСУ” гэх)-д эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн бүтэц, тусгах шаардлагатай агуулгыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (1954)⁸¹ болон БНСУ-

78 Мөн тэнд, 48 дахь тал.

79 Мөн тэнд.

80 Мөн тэнд, 49 дахь тал.

81 대한민국 형사소송법 <https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%86%8C%EC%86%A1%EB%B2%95>, (Сүүлд үзсэн: 2025.09.15).

ын Дээд шүүхээс баталсан Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр боловсруулах тухай журам (2014)⁸²-д тус тус заасан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд шүүхийн шийдвэрийн бүтцийг нэг бүлэгт бус өөр өөр бүлэгт ерөнхий байдлаар хуульчилсан байдаг. Харин Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр боловсруулах тухай журам (цаашид “Журам” гэх)-д анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрхэн боловсруулах талаар дэлгэрэнгүй зааж өгснөөр шүүхийн шийдвэрийг нэг мөр, ойлгомжтой, цэгцтэй боловсруулж эхэлжээ. Мөн уг журамтай ижил эсхүл төсөөтэй дүрэм, журам батлах тохиолдолд дээрх журмыг удирдлага болгоно.⁸³ Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол нь дарах бүтэцтэй байна.⁸⁴

Шигтгээ №3. БНСУ-ын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Шийтгэх тогтоолын бүтэц:

- 1) *Гарчиг (сол. 표제): Шүүхийн нэр*
- 2) *Удиртгал хэсэг (сол. 형식적 기재사항)*
- 3) *Тогтоох хэсэг (сол. 주문):*
 - *Ял оногдуулах*
 - *Ялаас чөлөөлөх, шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах*
- 4) *Үндэслэх хэсэг (сол. 이유):*
 - *Хэргийн үйл баримт*
 - *Нотлох баримтыг үнэлж, дүгнэсэн байдал*
 - *Хууль тогтоомжийн хэрэглээ*
 - *Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой талуудын мэдүүлэг.*

Шийтгэх тогтоол дээрх дурдсан бүтэцтэй байх бөгөөд агуулгыг дэлгэрэнгүй авч үзье.

1. Удиртгал хэсэг

Удиртгал хэсэгт шүүхийн шийдвэрийн дугаар, хэргийн

82 대법원 형사재판서 작성 방식 적정화에 관한 예규.

83 대법원 형사재판서 작성 방식 적정화에 관한 예규 제2조 제2항.

84 사법정책연구원 “법조일원화 시대에 걸맞은 제1심 판결서 작성 방식의 개선 방안”, (2023) 34-36, supra note 3, 34-36.

нэр,⁸⁵шүүгдэгчийн биеийн байцаалт, улсын яллагчийн мэдээлэл, шүүх хуралдаанд оролцож буй өмгөөлөгчдийн мэдээлэл, иргэний нэхэмжлэгч байгаа бол иргэний нэхэмжлэгчийн мэдээлэл, шийдвэрийн огноог тус тус тусгана.

2. Тогтоох хэсэг

Шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт шүүгдэгчийг ямар гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон тухай дүгнэлт гаргаж, түүнд оногдуулсан ялын талаар шүүхээс гаргасан шийдвэрүүдийг заана. Ингэхдээ, үндсэн ял болон нэмэгдэл ялын төрөл, хэмжээ мөн нэмэлт арга хэмжээ авсан эсэх талаар товч бичнэ.

Тус улсын **Шүүхийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн 31 дүгээр зүйлд⁸⁶ Иргэний нэхэмжлэлийг гэм буруутайд тооцсон шийдвэрийн хамт нэгэн зэрэг шийдвэрлэх ёстой хэмээн заасан.** Иймд тухайн хэргийг шийдвэрлэхдээ иргэний нэхэмжлэлийг ханган тодорхой хэмжээний мөнгө гаргуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт нөхөн төлбөрийн хэмжээг тусгана. Иргэний нэхэмжлэлийг хангасан шийдвэрийн үндэслэлийг онцгой шаардлагатай биш бол тусгахгүй байж болно.

3. Үндэслэх хэсэг

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 323-р зүйлд шийтгэх тогтоол гаргахдаа **тогтоолын үндэслэх хэсэгт хэргийн үйл баримт, нотлох баримтын товч болон холбогдох хууль тогтоомжийг тодорхой зааж бичнэ. Хэрэв хуульд заасны дагуу гэмт хэргийн бүрэлдэхүүн хангагдсан шалтгаан, эсвэл ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх үндэслэл болсон баримтууд байгаа бол эдгээрийн талаар гаргасан дүгнэлтийг мөн тодорхой зааж бичих ёстой гэж тусгажээ.** Шийтгэх тогтоолын үндэслэх хэсэг нь дараах бүтэцтэй байна:

85 Солонгос Улсад тухайн хэргийг бусад хэргээс ялгаж зорилготой гэмт хэргийн төрөл, шинжээр нь ялгаж нэр өгдөг. Жишээ нь, залилан, дээрэм гэх мэт.

86 대한민국 소송촉진 등에 관한 특례법
<https://www.law.go.kr/LSW/LsiJoLinkP.do?docType=JO&lsNm=%EC%86%8C%EC%86%A1%EC%B4%89%EC%A7%84+%EB%93%B1%EC%97%90+%EA%B4%80%ED%95%9C+%ED%8A%B9%EB%A1%80%EB%B2%95&joNo=003100000&languageType=KO¶s=1#>.(Сүүлд үзсэн:2025.08.13).

- 1) Хэргийн үйл баримт;
- 2) Нотлох баримт;
- 3) Хууль тогтоомжийн хэрэглээ;
- 4) Ял оногдуулах үндэслэл гэсэн дэд хэсгүүдээс бүрдэнэ.

1) Хэргийн үйл баримт

- Гэмт хэргийн үйл баримт

Шүүхийн шийдвэрт тусгах хэргийн үйл баримт гэдэг нь **шүүхээр шинжлэн судалсан нотлох баримтууд байх бөгөөд гэм буруугийн талаарх үндсэн баримтуудыг тусгана**. Үүнд: гэмт хэргийн бүрэлдэхүүнд хамаарах тусгай үйл баримт, гэмт хэргийн зорилго, сэдэл, гэмт хэргийн үр дагавар, гэмт үйлдэл ба эс үйлдэхүй, гэм буруу, гэмт хэрэгт хамтран оролцогчдын хоорондын харилцааг тусгана.

Дээд шүүхээс баталсан Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр боловсруулах тухай журамд шүүхээс хэргийн үйл баримтыг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд шүүхийн шийдвэрийн хавсралт хэсгээс үзэж болохоор тусгана гэж заасан байна.

- Ял оногдуулах үндэслэл бүхий баримтууд

Шүүхийн практикт ихэвчлэн “Хэргийн баримт” гэсэн ангилалд ялын үндэслэлтэй тохирч байгаа баримтуудыг авч үздэг. Тухайлбал,

- Ял хөнгөрүүлэх зайлшгүй шаардлагатай нөхцөлүүд (хэл, сонсголын бэрхшээлтэй хүн), шүүгч өөрийн эрх хэмжээний хүрээнд ял хөнгөрүүлэх нөхцөл байдал 87(сэтгэцийн өөрчлөлттэй гэх мэт) байгаа бол шийтгэх тогтоолын хууль хэрэглээ хэсэгт тусгаж өгнө.
- Гэмт хэргийн сэдлийг голдуу хүн амины хэрэг, галдан шатаах гэмт хэрэг дээр тодорхой тусгаж өгөх ба өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт шаардлагагүй тохиолдолд дурдахгүй байж болно.
- Өмнө нь ял шийтгэл эдэлж байсан эсэх (сол.전과)

87 Тухайн шүүгдэгч сэтгэцийн өөрчлөлт зэргийн улмаас ял хөнгөвчлөх шаардлагатай эсэхийг шүүгч шинжээчийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

- Нэмэгдэл арга хэмжээ авах үндэслэл:

Албадан эмчилгээ, тогтоосон хугацаанд цахилгаан гав зүүх гэх мэт нэмэлт шийтгэл оногдуулах тохиолдолд шийтгэх тогтоолд тавигдах тусгай шаардлагуудыг эрүүгийн хэргийн баримтын хамт шийтгэл оногдуулах үндэслэлд дурдана.

Хэргийн үйл баримтыг тодорхойлохдоогэмт хэргийн бүрэлдэхүүнд хамаарах бүх шаардлагыг бүрэн, алдаагүй бичих хэрэгтэй. Мөн хэд хэдэн шүүгдэгчтэй тохиолдолд шүүгдэгч тус бүрийн үйлдлийг ялгаж, тодорхой бичнэ. Ингэхдээ ерөнхий байдлаар бичихгүй нарийвчилж бичнэ. Тухайлбал, хулгайлах гэмт хэрэг хийсэн тохиолдолд зөвхөн хулгай гэж бичихгүй тухайн өдөр ямар газраас юу хулгайлсан зэргээр нарийвчлан бичих шаардлагатай.⁸⁸

2) Нотлох баримт

Нотлох баримтыг тогтоолын үндэслэх хэсэгт бичих ба нотлох чадвартай, хуульд заасан үндэслэл журмын дагуу олж авсан баримтыг шүүх үнэлнэ. Түүнчлэн хэрэгт авагдаагүй нотлох баримтуудыг хэрэгт авагдаагүй шалтгааныг дурдах шаардлагагүй бөгөөд ижил утга бүхий олон тооны нотлох баримт байгаа тохиолдолд хэрэгт хамгийн ач холбогдолтой нэг нотлох баримтыг сонгон тусгана.⁸⁹

Нотлох баримтыг дурдахдаа зөвхөн гол агуулгыг тайлбарлаж нотлох баримтуудыг жагсаалтын дагуу ерөнхийд нь дурдана. Ингэхдээ,

- баталгаажуулах
- бичгийн нотлох баримт
- эд мөрийн баримт гэсэн дарааллаар дурддаг.⁹⁰

Баталгаажуулах гэдэг нь нотлох баримтыг хуульд заасан үндэслэл журмын дагуу олж авсан эсэхийг баталгаажуулахыг хэлнэ. Харин бичгийн нотлох баримт гэдэг нь шүүгдэгчээс авсан мэдүүлэг, байцаалтын тэмдэглэл, нүдээр харсан гэрчийн мэдүүлэг, гэрчийн

88 사법정책연구원, supra note 84, 36

89 사법정책연구원, supra note 48, 36

90 대법원 1984. 5. 29. 선고 84도682 판결 참조.

мэдүүлэг мөн баримтжуулсан нотлох баримтын хувьд прокурорын тэмдэглэлийг хэлнэ.

3) Хууль тогтоомжийн хэрэглээ

Шийдвэрийн үндэслэх хэсэгт хууль тогтоомжийг дурдахдаа **огүүлбэрийн хэлбэр** болон **жагсаалтын хэлбэр** гэсэн 2 төрлөөр бичих бөгөөд эдгээрээс жагсаалтын хэлбэрээр бичих нь түгээмэл байдаг. Учир нь хуулийг үргэлжилсэн үгээр бичих нь ойлгоход хүндрэлтэй байж болох тул доош жагсааж бичих нь илүү ойлгомжтой гэж үздэг. Жишээ нь,

- Эрүүгийн хуулийн 347-р зүйл залилах гэмт хэрэг,
- Эрүүгийн хуулийн 348-р зүйл компьютер, тоног төхөөрөмж ашиглан хүнийг залилах гэмт хэрэг гэх мэт.

Эрүүгийн хариуцлага оногдуулахдаа Эрүүгийн хууль (1953)⁹¹-ийн 56-р зүйлд заасан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Түүнчлэн, **хэд хэдэн шүүгдэгч байгаа тохиолдолд** шүүгдэгч тус бүрээр нь хуваан бичих бөгөөд үйлдсэн гэмт хэрэг нь ямар бүрэлдэхүүнтэй болохыг тодорхойлон зүйл, заалтыг бичнэ. Мөн өөр хуулийн заалтыг иш татах шаардлагатай бол тэрхүү заалтыг дурдана. **Хэд хэдэн гэмт хэргийг нэг зэрэг үйлдсэн тохиолдолд** нэг гэмт хэрэгт холбогдох хуулийн зүйл заалтыг бичиж, хаалт дотор тодорхой үйлдлийг бичин дараагийн гэмт хэрэгт холбогдох зүйл заалтыг тэмдэглэнэ.

4) Ял оногдуулах үндэслэл

2007 оны 01 дүгээр сарын 26-ний өдөр “Шүүхийн бүтэц, зохион байгуулалтын тухай хууль⁹²” (1949)-ийн шинэчилсэн найруулгаар “Ялын хороо” (сол. 양형위원회) байгуулагдсан. Уг хороо нь шүүхээс оноох ялын хэмжээ нь шүүгдэгчийн эрүүл мэндийг дордуулахгүй, нийтийн ёс суртахууныг хангасан, шударга, бодитой ял оноож байгаа эсэхэд хяналт тавих, ялын дундаж хэмжээг тогтоох, өөрчлөх, ялын

91 대한민국 헌법

<https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9%ED%98%95%EB%B2%95>

92 대한민국 법원조직법

талаар бодлого боловсруулж судлах, ялын удирдамж гаргах чиг үүрэг бүхий Дээд шүүхийн дэргэдэх байгууллага юм.

Ялын хорооноос гаргасан ялын удирдамж нь хуулийн хүчин чадалтай биш ч шүүх уг удирдамжтай зөрчилдсөн шийдвэр гаргасан тохиолдолд ялын үндэслэлийг шүүхийн шийдвэрт тусгах үүрэг хүлээдэг.⁹³ Мөн хэд хэдэн шүүгдэгчид ялын хэмжээг өөр өөрөөр оногдуулж байгаа тохиолдолд ял оногдуулсан үндэслэлийг заавал бичих үүрэгтэй байна.⁹⁴

Хэрэв шүүхийн шийдвэр алдаатай бичигдэж хохирлын тооцоолол, тоо, үг, үсгийн алдаа гарсан бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх журмын⁹⁵ (2022) 25-р зүйлийн дагуу эрх бүхий этгээд болон талуудын хүсэлтийг үндэслэн алдаатай шийдвэрийг засах захирамж (сол. **경정 결정**) гаргана. Уг захирамжийн дагуу шүүхийн шийдвэрийн эх хувь ба хуулбарыг засаж бичих бөгөөд хуулбар хувийг засах боломжгүй бол шийдвэрийг зассан захирамжийг хуулбар хувь авсан хүнд гардуулах үүрэгтэй байна. Түүнчлэн шийдвэрийг зассан захирамжид давж заалдах гомдол гаргах эрхтэй.

Эрүүгийн хэргийн шүүхийн шийтгэх тогтоолд **үндэслэлээ тодорхой заах шаардлага** тавигддаг боловч давж заалдахыг хориглосон шийдвэр болон захирамжийн⁹⁶ хувьд бичихгүй байж болно хэмээн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан байна. Мөн **шүүхийн шийдвэрийг богино өгүүлбэр ашиглан энгийн, ойлгоход хялбар байдлаар** бичих нь зүйтэй гэж Дээд шүүхээс баталсан журамд заажээ.⁹⁷ Түүнчлэн, БНСУ-д **“Шүүхийн шийдвэр боловсруулах цахим систем”** (сол. **판결문 작성관리 시스템**) байх бөгөөд энэхүү системийг ашиглан дээр дурдсан бүтцийн дагуу шүүхийн шийдвэрийг бичдэг. Энэхүү цахим

93 대한민국 법원조직법 제81조의7.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsId=001710&ancYnChk=0#0000>

94 사법정책연구원, *supra* note 4, 39.

95 대법원 형사소송규칙

96 Тухайлбал, шүүхээс торгуулийн ял оноосон тохиолдолд давж заалдах гомдол гаргахыг хориглосон шийдвэр гаргадаг. Мөн ЭХХШ тухай хуулийн 382-р зүйлд давж заалдах гомдол гаргахыг хориглох шалтгааныг дэлгэрэнгүй заасан байна.

97 대법원 형사재판서 작성 방식 적정화에 관한 예규 제3조 제2항

систем нь шүүгчийн ажлыг хөнгөвчилж өгдгөөрөө давуу талтай.⁹⁸

Дээр дурдсанаас бусад шүүхийн шийтгэх тогтоол боловсруулахтай холбоотой харилцааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулдаг. Тухайлбал, 321-р зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгдэгчийн гэм буруутай нь нотлогдсон тохиолдолд ялаас чөлөөлөх эсхүл шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахаас бусад тохиолдолд тогтоол гаргаж эрүүгийн хариуцлага оногдуулах ёстой”, мөн зүйлийн 2 дах хэсэгт “Ялын биелэлтийг хойшлуулах, тогтоол гарахаас өмнө цагдан хоригдсон хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцох, хорих ангид хөдөлмөр эрхэлсэн хугацааг ялын хугацаанд оруулан тооцох асуудлыг ялын тогтоол гаргахтай зэрэгцэн тогтоол гаргаж шийдвэрлэх ёстой” гэж ял оногдуулахтай зэрэгцүүлэн шийдвэрлэх нөхцөл байдлыг хуульчилсан байна. Харин **ялаас чөлөөлөх болон шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах тохиолдолд тогтоол гаргана** гэж 322 дугаар зүйлд тус тус хуульчилжээ.

5. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС (БНФУ)

Франц Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (1959)⁹⁹-д (фр.Code de procédure рйнале) анхан шатны шүүхийн шийдвэрийн үндсэн бүтцийг хуульчилсан байна. Тодруулбал, тус хуулийн 485 дугаар зүйлд “шүүхийн ямар ч шийдвэр заавал үндэслэл (*фр.motifs*) болон шийдвэрлэх хэсэг (фр.dispositif)-тэй байх ёстой” гэж заажээ. **Үндэслэл хэсэг нь** шүүхийн шийдвэрийн агуулгыг бүрдүүлэх бөгөөд шүүгчийн гаргасан шийдвэрийн хууль зүйн болон баримтын үндэслэлийг дэлгэрэнгүй тайлбарласан байдаг бол **шийдвэрлэх хэсэгт** шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэргийн зүйл, заалт, шүүгдэгчид оногдуулсан ял шийтгэл, хэрэглэсэн хуулийн заалтууд болон нөхөн төлбөрийн талаар тус тус тодорхой дурддаг байна.¹⁰⁰

98 사법정책연구원, *supra* note 4, 41.

99 Code de procédure pénale, 1959, https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006071154/, (Сүүлд үзсэн: 2025.09.05).

100 Me Manuel Abitbol, *La forme du jugement*, <https://manuel-abitbol-avocat-penaliste.fr/la-forme-du-jugement/>, (Сүүлд үзсэн: 2025.09.05).

Шүүхийн шийдвэрийг амаар танилцуулах үед шүүхийн шийдвэрийн зөвхөн шийдвэрлэх хэсэг буюу *dispositiv* хэсгийг уншиж сонсгодог бол бичгээр гаргаж буй шүүхийн шийдвэр(*фр.minute*)-т заавал үндэслэл хэсгийг бичдэг байна.¹⁰¹

Шүүхийн шийдвэрийн албан ёсны бүтцэд тавигдах шаардлагыг хуульд нарийвчлан тогтоожээ. Тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 486 дугаар зүйлд “Бичгээр гаргасан шүүхийн шийдвэрт шүүхийн нэр, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцсон улсын яллагч зэргийг дурдаж, шийдвэр гаргасан огноо, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын нэрийг тус тус бичиж, төгсгөлд нь шүүх хуралдаан даргалагч болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна” хэмээн заажээ.¹⁰²

Шийтгээ №4. БНФУ-ын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Шийтгэх тогтоолын бүтэц:

- 1) *Толгой хэсэг (Фр. En-tête)*
- 2) *Ориил хэсэг (Фр. Préambule / Rappel de la procédure)*
- 3) *Нотлох баримт, хэлэлцүүлгийн тэмдэглэл (Фр.Exposé des faits et des débats)*
- 4) *Үндэслэл хэсэг (Фр. Motifs / Attendus)*
- 5) *Тогтоох хэсэг (Фр.Dispositif)*

Ийнхүү Франц Улсын хууль тогтоомжид эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг бичих хэлбэр, бүтцийн гол шаардлагуудыг тодорхой хуульчилсан байх бөгөөд шүүгч хуульд заасан эдгээр шаардлагын хүрээнд шийдвэрээ бичихдээ шүүхийн практикт хэвшсэн загварыг баримталдаг. Тухайлбал, шүүхийн шийдвэр нь эхэндээ “энтете” буюу шийдвэрийн толгой хэсэг (шүүхийн нэр, огноо, оролцогчдын мэдээлэл гэх мэт), шүүхийн хэлэлцүүлгийн товч тэмдэглэл, цаашлаад үндэслэл (нотлох баримтууд, дүгнэлтүүд),

¹⁰¹ Susanne Bannansat, *Attendu que*“ Französische Gerichtsurteile als Herausforderung für den Übersetzer“, 2014, S.2.

¹⁰² European court of human rights, *De la requête no 53607/99 présentée par André COHEN et Gilbert SMADJA contre la France*, <https://hudoc.echr.coe.int/app/conversion/docx/pdf?library=ECHR&id=001-43970&filename=C,EDH.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.09.05).

эцэст нь “par ces motifs” гэх шийдвэрлэх хэсэг гэсэн ерөнхий бүтэцтэй бичигддэг байна.

1) Шүүхийн шийдвэрт тавигдах шаардлага

Шүүхийн шийдвэр тодорхой, ойлгомжтой, эргэлзээ төрүүлэхгүй байх шаардлагатай талаар хуульд тусгагдаагүй ч шийдвэр “үндэслэл бүхий” байх шаардлага нь хууль зүйн үндсэн зарчим болж тогтсон байдаг. Франц Улсын Үндсэн хууль болон Европын хүний эрхийн конвенцын хүрээнд шүүхийн шийдвэр үндэслэлтэй байх үүрэг нь шударга шүүхийн нэг чухал элемент гэж хүлээн зөвшөөрсөн байна.¹⁰³

Шүүгч шийдвэр бичихдээ аль болох энгийн, тодорхой хэллэг хэрэглэхийг сүүлийн жилүүдэд чухалчилж байна. Судлаачдын тэмдэглэснээр, **шүүхийн шийдвэр нь юуны өмнө маргааны талуудад чиглэгдсэн баримт бичиг тул хуульч бус этгээдэд ч ойлгогдохуйц байдлаар бичигдэх ёстой гэж үздэг.**¹⁰⁴ Энэ нь мэргэжлийн түвшинд ашигладаг ойлгоход хүндрэлтэй зарим хууль зүйн нэр томьёо, тэр дундаа латин хэлний хуучин хэллэгийг тайлбарлах буюу орлох үг хэрэглэх хандлагатай байгааг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, хуульд заасан шийдвэр үндэслэл бүхий, хууль ёсны байх (d’cision liyale et bien-fondie) шаардлага нь бичвэрийн чанарт шууд нөлөөлдөг бөгөөд шүүхийн шийдвэр нь ойлгомжтой бус, эсвэл хууль зүйн үндэслэл дутмаг бол давж заалдах шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг хүчингүйд тооцох боломжтой байдаг байна.¹⁰⁵

Түүнчлэн, хяналтын шатны шүүх (cour de cassation)-ээс 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдөр гаргасан шийдвэртээ **анхан шатны шүүх ял оногдуулахдаа үндэслэлээ тайлбарлах үүрэгтэй болохыг онцолсон байна.** Мөн 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдөр оруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт

103 Cour de cassation, La definition de la motivation enrichie, 2023, https://www.courdecassation.fr/files/files/Demain/Guide_de_r%C3%A9adaction_en_motivation_enrichie_sept_2023.pdf, (Сүүлд үзсэн: 2025.09.07).

104 Hélène Colombet, Alice Gouttefangeas, La qualité des décisions de justice. Quels critères?, <https://shs.cairn.info/revue-droit-et-societe1-2013-1-page-155?lang=fr>, (Сүүлд үзсэн: 2025.09.07).

105 European court of human rights, De la requête no 53607/99 présentée par André COHEN et Gilbert SMADJA contre la France, <https://hudoc.echr.coe.int/app/conversion/docx/pdf?library=ECHR&id=001-43970&filename=C,EDH.pdf> (Сүүлд үзсэн: 2025.09.07).

өөрчлөлтөөр ял шийтгэлийг оногдуулахдаа гэмт хэрэг гарсан нөхцөл байдал, шүүгдэгчийн хувийн байдал зэргийг харгалзан үзсэн талаарх тайлбар заавал хийх шаардлагыг тусгайлан хуульчилсан (CPR, 485-1 дүгээр зүйл) байна.¹⁰⁶ Энэ нь шийдвэрийн үндэслэл илүү тодорхой, дэлгэрэнгүй байх шаардлагыг нэмэгдүүлжээ. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэр нь зөвхөн хуульд нийцсэн байх төдийгүй тухайн шийтгэлийг “яагаад оногдуулсан” нь ойлгогдохуйц бичигдэх ёстой байдаг байна.¹⁰⁷

2) Шүүхийн шийдвэрт нотлох баримтыг тусгах нь

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт хэргийн үйл баримт болон нотлох баримтыг дэлгэрэнгүй дурдан тайлбарладаг. Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай гэсэн дүгнэлтэд хүргэсэн чухал нотлох баримтуудыг шүүгч шийдвэрийн үндэслэл хэсэгт оруулж, эдгээрээс ямар дүгнэлт хийснээ тодорхой бичнэ. Харин гэрчийн мэдүүлгийг шүүх хэрхэн үнэлж байгааг шүүхийн шийдвэрт дараах байдлаар тусгадаг байна. “Гэрч Сецил Д.-ийн мэдүүлэгт дурдсанаар 2015 оны Парисын хэлэлцээрийг Франц улс хэрэгжүүлээгүй, төрийн зүгээс улс төрийн хүсэл зориг дутуу байгааг онцолсон...” гэх гэрчийн мэдүүлгийн агуулгыг шүүхийн шийдвэрт оруулсан байна.¹⁰⁸ Ийнхүү шүүх гэрчийн мэдүүлгийг эх сурвалжтай нь (гэрчийн нэр, албан байр суурийг дурдан) товчлон өгүүлж, түүний үндсэн дээр ямар дүгнэлт хийж байгаагаа үргэлжлүүлэн бичдэг.

Мөн шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт шинжээчийн дүгнэлт, эд мөрийн баримт зэрэг бусад нотлох баримтыг дурдана. Хэргийг шалгах явцад гарсан шинжээчийн дүгнэлт, бичиг баримтад агуулагдсан мэдээлэл зэргийг шүүхийн шийдвэрт бичихдээ “...*гэсэн шинжээчийн дүгнэлтээр батлагдсан*”, “*мөрдөн байцаалтын явцад*

106 Article 485-1 du Code de procédure pénale, <https://justice.pappers.fr/loi/LEGITEXT000006071154/article/LEGIARTI000049778753>

107 Article 485-1 du Code de procédure pénale, <https://justice.pappers.fr/loi/LEGITEXT000006071154/article/LEGIARTI000049778753>, (Сүүлд үзсэн: 2025.09.07).

108 Cour d'Appel de LYON, 16 l'ÉVRIER 2019, 19168000015, <https://web.lexisnexis.fr/LexisActu/TGILYONDécrocheurs.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.09.07).

цугларсан баримтаар нотлогдсон нь тогтоогдлоо” гэх зэргээр дурдаж, тэдгээрээс хэргийн ямар нөхцөл тогтоогдсоныг тайлбарладаг. Жишээлбэл “... мөрдөн байцаалтын явцад цугларсан баримтууд болон шүүх хуралдааны үеэр гаргасан мэдүүлгийн үндсэн дээр шүүгдэгч хулгайн гэмт хэрэг үйлдэгдсэн нь тогтоогдлоо; Учир нь шүүгдэгч нар өөрсдөө үнэ цэнтэй уг зүйлийг санаатайгаар авсан болох нь тэдний мэдүүлгээс харагдаж байна” гэх зэргээр бичдэг.¹⁰⁹

Энэ нь шүүгч мөрдөн байцаалтын явцад цуглуулсан нотлох баримт (энэхүү тохиолдолд – хэргийн газрын үзлэг болон гэрч/яллагдагчийн мэдүүлэг) болон шүүхийн хэлэлцүүлэгт гаргасан мэдүүлгийг үндэслэлдээ нэгтгэн дүгнэж буй жишээ юм.

Дээрх байдлаар Франц Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт нотлох баримт бүрийг тусгайлан жагсаах гэхээс илүү, тэдгээрийн агуулга, ач холбогдлын талаар дүгнэдэг байна. Үүний үр дүнд шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсгийг уншсанаар тухайн хэрэгт гэрч юу мэдүүлсэн, ямар баримт юу гэрчилж байгааг болон шүүгч тэдгээрт ямар үнэлэлт өгснийг ойлгож болдог. Энэ нь шүүхийн шийдвэрийг үндэслэлтэй, ойлгомжтой болгоход чухал үүрэг гүйцэтгэхээс гадна давж заалдах шатны шүүх хэргийг хянах тохиолдолд шүүхийн шийдвэр ямар баримтад тулгуурласныг хянан үзэх боломжийг бүрдүүлдэг байна.

3) Хуульд заасан шаардлага хангаагүй шүүхийн шийдвэрт гомдол гаргах талаар

Франц Улсад шүүхийн шийдвэр нь хуульд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд уг шийдвэрийг хүчингүй болгуулахаар дээд шатны шүүхэд гомдол гаргадаг. Анхан шатны шүүхийн шийдвэр хангалттай үндэслэлтэй бичигдээгүй бол давж заалдах шатны шүүх уг шийдвэрийг хүчингүй болгодог. Жишээлбэл, Греноб (Grenoble)-ийн давж заалдах шатны шүүх 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр гаргасан шийдвэртээ анхан шатны шийтгэх тогтоолыг “үндэслэлгүй”

¹⁰⁹ Cour d'Appel de LYON, 16 l'ÉVRIER 2019, 19168000015, <https://web.lexisnexis.fr/LexisActu/TGILYONDecrocheurs.pdf> (Сүүлд үзсэн: 2025.09.07).

(dйfaut de motifs) гэж үзэн хүчингүй болгосон.¹¹⁰ Уг хэрэгт анхан шатны шүүх бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт холбогдсон шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай хэмээн үзэж, ял шийтгэл оногдуулсан бөгөөд шийдвэрт яагаад уг ялыг оногдуулсан талаарх үндэслэлийг тодорхой тусгаагүй байна. Иймд давж заалдах шатны шүүхээс уг шийдвэрийг хүчингүйд тооцжээ.¹¹¹

Үүнээс гадна шүүхийн шийдвэрт тавигдах зарим формаль шаардлагыг зөрчсөн нь давж заалдах шатны шүүхэд гаргах гомдлын үндэслэл болох боломжтой. Тухайлбал, шийдвэр гаргасан огноо, шүүгчдийн нэр эсхүл шүүх хуралдаанд улсын яллагч оролцсон талаарх тэмдэглэл зэрэг заавал бичигдэх ёстой мэдээлэл дутуу орхигдсон тохиолдолд хэргийн оролцогч талуудаас энэ үндэслэлээр давж заалдах гомдол гаргаж болдог.¹¹² Гэхдээ хуульд зааснаар, хэрэв шүүхийн шийдвэрт ийм төрлийн формаль мэдээлэл дутсан ч тухайн мэдээллийг шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг өөр баримтаар нотолж болох тохиолдолд уг алдааг засан залруулах боломжтой байдаг байна. Иймд практикт зөвхөн бичилтийн техникийн алдааны улмаас биш, харин шийдвэрийн агуулгын ноцтой доголдол (хууль зүйн үндэслэлгүй байх гэх мэт) гарсан тохиолдолд л дээд шатны шүүх шийдвэрийг хүчингүй болгодог гэж дүгнэж болохоор байна.

4) Шүүхийн шийдвэрт латин нэр томьёог тусгах нь

Франц Улсын шүүхийн практикт хууль зүйн латин нэр томьёог тодорхой хэмжээнд ашигладаг. Зарим түгээмэл зарчим, нэр томьёог латин хэл дээр ашигладаг. Жишээлбэл, “Ne bis in idem” гэх латин нэр томьёо нь дахин шийтгэхгүй байх зарчим (нэг үйлдэлд хоёр удаа ял оногдуулахгүй байх) нь шүүхийн шийдвэрт латин нэр томьёогоороо шууд бичигдсэн байдаг.¹¹³ Мөн “in dubio pro reo” (эргэлзээг

110 Léa Fernandes, Absence de motifs et nullité soulevée in limine litis, une opportunité pour la juridiction d’appel de réaffirmer la culpabilité du prévenu ainsi que la légitimité de la peine, 2024, <https://publications-prairial.fr/bacage/index.php?id=832b> (Сүүлд үзсэн: 2025.09.10).

111 Léa Fernandes, Absence de motifs et nullité soulevée in limine litis, une opportunité pour la juridiction d’appel de réaffirmer la culpabilité du prévenu ainsi que la légitimité de la peine, 2024, <https://publications-prairial.fr/bacage/index.php?id=832>, (Сүүлд үзсэн: 2025.09.10).

112 Me Manuel Abitbol, La forme du jugement, <https://manuel-abitbol-avocat-penaliste.fr/la-forme-du-jugement/>, (Сүүлд үзсэн: 2025.09.10).

113 Stéphane de Navacelle, Ne bis in idem: France stays on the sidelines of the European stance, <https://navacelle.law/>

яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэх) зарчмыг шүүн таслах ажиллагаанд баримталдаг ч шийдвэрийн бичвэрт заавал латинаар нь дурдалгүйгээр франц хэлээр тухайн санааг илэрхийлэх тохиолдол байдаг. Тухайлбал, шүүхийн шийдвэрт “эргэлзээтэй тохиолдолд яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэв” гэх мэтээр бичих нь “in dubio pro geo” зарчмыг хэрэгжүүлж буй хэрэг бөгөөд заавал латин үгээр бичих шаардлагагүй гэж үзэх нь бий.

Гэхдээ өнөө үеийн шүүхийн шийдвэрүүдэд латин нэр томьёо бус, орчин үеийн хэлээр бичих чиг хандлага давамгайлж байна.¹¹⁴ Учир нь латин нэр томьёог хуульчид ойлгодог ч хэргийн оролцогч, энгийн иргэд ойлгоход төвөгтэй байж болох тул шүүх шийдвэрийн ойлгомжтой байдлыг хангах үүднээс эх хэл дээр нь тайлбарлах хандлага давамгайлж байна. Жишээлбэл, Парисын давж заалдах шатны шүүхийн шийдвэрт “*gr.Audi alteram partem* (нөгөө талынхаа үгийг сонс) зарчмыг зөрчсөн” хэмээн дурдахын оронд шууд “маргааны нөгөө талын хэлэхийг сонсолгүйгээр шийдвэр гаргасан нь эрх зүйн зарчмыг зөрчсөн” гэж тодорхой бичсэн байна.

Латин нэр томьёо хэрэглэх зайлшгүй шаардлагагүй бол франц хэлээр орлуулан хэрэглэдэг нь сүүлийн үеийн шүүн таслах ажиллагааны бичгийн соёлын чиг хандлага болсон. Гэхдээ шүүхийн шийдвэрийн зарим хэсэгт, тухайлбал хууль зүйн онол, зарчим тайлбарлах үед шаардлагатай гэж үзвэл латин хууль зүйн хэллэгийг хэвээр нь оруулах тохиолдол хадгалагдсаар байна.¹¹⁵ Тийм тохиолдолд латин нэр томьёоны тайлбарыг нь нэмж бичих буюу тухайн латин хэллэгийн утгыг шийдвэрийн бусад өгүүлбэрээр дам ойлгогдохуйц байдлаар тусган томьёолох нь түгээмэл байдаг.

5) Нууцаар мөрдөн шалгасан ажиллагааны үр дүнг шүүхийн шийдвэрт тусгах нь

Франц Улсад нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах үндэслэл, зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг Эрүүгийн хэрэг хянан

114 Hélène Colombet, Alice Gouttefangeas, La qualité des décisions de justice. Quels critères?, <https://shs.cairn.info/revue-droit-et-societel-2013-1-page-155?lang=fr>

115 Dalloz Etudiant, À propos des adages latins du droit français, 2017, <https://actu.dalloz-etudiant.fr/>

шийдвэрлэх тухай хуулийн 706-81 болон түүнээс хойших зүйл, заалтад нарийвчлан зохицуулсан. Гэмт хэргийг илрүүлэх зорилгоор мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулсан тохиолдолд уг ажиллагааны үр дүнг шийдвэрийн үндэслэл хэсэгт бусад баримтын адил тусгана. Шүүхийн шийдвэрт тухайн нотлох баримтыг ямар аргаар олж авсан талаар дурдалгүйгээр, нотлох баримтын агуулгад тулгуурлан дүгнэлт хийдэг байна.

Мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад утасны ярианы бичлэгийг нотлох баримтаар цуглуулсан бол энэ талаар шүүхийн шийдвэрт тусгахдаа “уг ажиллагааны явцад шүүгдэгч мансууруулах бодис худалдаалахад оролцсоныг нотолсон утасны ярианы бичлэгт мөрдөгч үзлэг хийж, тэмдэглэл хөтөлсөн байна” гэх байдлаар бичжээ.¹¹⁶ Энэ нь шүүх нууц аргаар олж авсан нотлох баримтыг хууль ёсны гэж үзэж, хэргийн үйл баримтыг тогтоох эх сурвалжийн нэг болгон шийдвэртээ оруулж буй хэрэг юм. Мөн нууц ажиллагааны явцад цуглуулсан гэрэл зураг, дүрс бичлэг, эсвэл шүгэл үлээгч (informant) -ийн мэдээллийг шүүх хуралдаан дээр шинжлэн судалж, шийдвэрт дурддаг. Жишээлбэл “... цагдаагийн ажилтан хяналтын худалдан авалт хийх үеэр шүүгдэгч мансууруулах бодис хууль бусаар худалдаалахад оролцсон гэдгийг нотолсон” гэх зэргээр шүүхийн шийдвэрт тусгадаг байна.

Мөрдөн шалгах нууц ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж явуулсан тохиолдолд шүүх тухайн нотлох баримтыг хүчингүйд тооцож, улмаар шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт ашигладаггүй. Харин хууль ёсны дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнд олж авсан баримтууд нь хэрэгт ач холбогдолтой гэж үзвэл шүүхийн шийдвэрийн үндэслэлд тодорхой дурдагдана.

116 Cour de cassation, criminelle, Chambre criminelle, 2 février 2022, <https://www.legifrance.gouv.fr/juri/id/JURITEXT000045133327> (Сүүлд үзсэн: 2025.09.10).

6. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС (ОХУ)

Оросын Холбооны Улс (цаашид “ОХУ” гэх)-ын Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн бүтэц, агуулгыг ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2001)-ийн 39 дүгээр бүлэгт¹¹⁷ тусгасан байна. Уг хуулийн 296 дугаар зүйлд¹¹⁸ зааснаар **шүүх тогтоолыг Оросын Холбооны Улсын нэрийн өмнөөс гаргана.**

ОХУ-ын Эрүүгийн хэргийн анхан шатны болон бүх шатны шүүхийн тогтоол (шийдвэр) нь удиртгал, тайлбарлан – тодорхойлох болон тогтоох хэсгээс бүрддэг байна. Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 303 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт болон ОХУ-ын Дээд Шүүхийн Нийт Шүүгчдийн хуралдааны “Шүүхийн тогтоолын тухай” тогтоолын¹¹⁹ 1 дэх хэсэгт зааснаар шүүхийн тогтоол бүх тохиолдолд удиртгал, тайлбарлан – тодорхойлох болон тогтоох хэсгээс бүрдэнэ.

Шигтгээ №5. ОХУ-ын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Шийтгэх тогтоолын бүтэц:

- 1) Удиртгал;
- 2) Тайлбарлан – тодорхойлох;
- 3) Тогтоох.

ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 302 дугаар зүйлийн¹²⁰ 1 дэх хэсэгт **“шүүхийн тогтоол нь шийтгэх эсвэл цагаатгах”** гэсэн төрөлтэй байна хэмээн заажээ. Цагаатгах тогтоолын тайлбарлан – тодорхойлох болон тогтоох хэсэгт тусгах мэдээллүүд нь шийтгэх тогтоолын тайлбарлан – тодорхойлох болон тогтоох хэсэгт тусгах мэдээллүүдээс ялгаатай байдаг. Иймээс тэдгээрийг тус тусад нь ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн өөр өөр

117 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39 дүгээр бүлэг. Тогтоол гаргах.

118 Оросын Холбооны Улсын нэрийн өмнөөс тогтоол гаргах.

119 Постановление Пленума Верховного Суда РФ от 29 ноября 2016 г. № 55 «О судебном приговоре» // Бюллетень Верховного Суда Российской Федерации. – 2017. – № 1. // (Шүүхийн тогтоолын тухай: ОХУ-ын Дээд Шүүхийн Нийт Шүүгчдийн Хуралдааны 2016.11.29 № 55 тогтоол. //ОХУ-ын Дээд шүүхийн мэдээллийн эмхэтгэл. -2017.- № 1).

120 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 302 дугаар зүйл. Тогтоолын төрлүүд.

зүйлүүдэд тусгасан байна. Харин шийтгэх болон цагаатгах тогтоолын удиртгал хэсэг нь адилхан бичигддэг байна. Энэхүү судалгааны хүрээнд судалж буй шүүхийн шийтгэх тогтоолын бүтэц нь дараах агуулгыг багтаана.

1. Тогтоолын удиртгал хэсэг

ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 304 дүгээр зүйлийн¹²¹ 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоолын удиртгал хэсэгт дараах мэдээллийг заана.

- 1) Оросын Холбооны Улсын нэрийн өмнөөс тогтоол гаргах тухай;
- 2) Тогтоол гаргасан огноо болон газар;
- 3) Тогтоол гаргасан шүүхийн нэр, шүүх бүрэлдэхүүн, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, прокурор, өмгөөлөгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч болон тэдгээрийн төлөөлөгчдийн тухай мэдээлэл;¹²²
- 4) Шүүгдэгчийн овог, нэр, төрсөн огноо болон газар, оршин суугаа газар, ажлын байр, эрхэлсэн ажил, боловсрол, гэр бүлийн байдал болон эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий шүүгдэгчийн хувийн байдлын талаарх бусад мэдээллүүд;
- 5) Шүүгдэгчийг буруутгаж буй гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг заасан ОХУ-ын Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалт.

2. Шийтгэх тогтоолын тайлбарлан – тодорхойлох хэсэг

ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 307 дугаар зүйлд¹²³ заасны дагуу шийтгэх тогтоолын тайлбарлан – тодорхойлох хэсэгт дараах агуулгыг тусгасан байх ёстой. Үүнд:

- 1) Гэмт хэрэг үйлдсэн газар, цаг хугацаа, үйлдсэн арга, гэм буруугийн хэлбэр, сэдэл, зорилго болон үр дагаврыг зааж, шүүхээр нотлогдсон гэмт үйлдлийг дурдана;

121 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 304 дүгээр зүйл. Тогтоолын удиртгал хэсэг.

122 Уголовно-процессуальный кодекс Российской Федерации от 18.12.2001 № 174-ФЗ // Собрание законодательства РФ. - 24.12.2001. - № 52 (ч. 1). - ст. 4921. // (2001 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн № 174 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга. – 2001.12.24. -№ 52 (1 х.). 4921 х).

123 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 307 дугаар зүйл. Шийтгэх тогтоолын тайлбарлан – тодорхойлох хэсэг.

- 2) Шүүгдэгчийн тухай (*орос хэлээр. в отношении подсудимого*) шүүхийн дүгнэлтэд үндэслэл болсон нотлох баримт болон шүүх бусад нотлох баримтаас татгалзсан үндэслэл;
- 3) Ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал, харин ялын ямар нэгэн хэсгийг үндэслэлгүй гэж үзсэн эсвэл гэмт хэргийг буруу зүйлчилсэн нь тогтоогдсон тохиолдолд ялыг өөрчлөх шалтгаан болон үндэслэлийг заах;
- 4) Ял оногдуулах, ялаас чөлөөлөх эсвэл түүнийг ял эдлэхээс чөлөөлөх, бусад нөлөөллийн арга хэмжээ хэрэглэхтэй холбоотой бүх асуултуудыг шийдвэрлэх шалтгаан;

4.1) Хураахаар болсон эд хөрөнгийг гэмт хэрэг үйлдсэний үр дүнд олж авсан эсвэл тус эд хөрөнгөөс олсон орлогыг гэмт хэрэг үйлдэхийн тулд зэвсэг, тоног төхөөрөмж эсвэл бусад хэрэгсэлд зориулж, эсхүл терроризм, экстремист үйл ажиллагаа, зохион байгуулалттай бүлэг, хууль бус зэвсэгт бүлэглэл, гэмт хэргийн нийгэмлэг (гэмт хэргийн байгууллага), ОХУ-ын аюулгүй байдлын эсрэг чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашигласан эсвэл ашиглахад зориулагдсан тухай шүүхийн дүгнэлтэд үндэслэл болсон нотлох баримтууд¹²⁴;

- 5) Энэ хуулийн 299 дүгээр зүйлд¹²⁵ заасан бусад асуултаар (*орос хэлээр. по другим вопросам*) гаргасан шийдвэрийн үндэслэл.¹²⁶

3. Шийтгэх тогтоолын тогтоох хэсэг

ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 308 дугаар зүйлийн¹²⁷ 1 дэх хэсэгт зааснаар шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт дараахыг тусгасан байх ёстой:

¹²⁴ Орос хэлээр. доказательства, на которых основаны выводы суда о том, что имущество, подлежащее конфискации, получено в результате совершения преступления или является доходами от этого имущества либо использовалось или предназначалось для использования в качестве орудия, оборудования или иного средства совершения преступления либо для финансирования терроризма, экстремистской деятельности (экстремизма), организованной группы, незаконного вооруженного формирования, преступного сообщества (преступной организации), деятельности, направленной против безопасности Российской Федерации;

¹²⁵ ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 299 дүгээр зүйл. Тогтоол гаргах явцад шүүхээс шийдвэрлэх асуултууд.

¹²⁶ Уголовно-процессуальный кодекс Российской Федерации от 18.12.2001 № 174-ФЗ // Собрание законодательства РФ. - 24.12.2001. - № 52 (ч. 1). - ст. 4921. // (2001 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн № 174 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга. – 2001.12.24. -№ 52 (1 х.). 4921 х).

¹²⁷ ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 308 дугаар зүйл. Шийтгэх тогтоолын тогтоох хэсэг.

- 1) Шүүгдэгчийн овог, нэр;
- 2) Шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон тухай шийдвэр;
- 3) Шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг заасан ОХУ-ын Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалт;
- 4) Шүүгдэгчийн гэм буруу нь тогтоогдсон гэмт хэрэг тус бүрд оногдуулсан ялын төрөл болон хэмжээ;
- 5) ОХУ-ын Эрүүгийн хуулийн 69-72 дугаар зүйлд заасны дагуу шүүгдэгчийн үйлдсэн гэмт үйлдэлд эцсийн байдлаар оногдуулсан ял (*орос хэлээр. окончательная мера наказания*);
- 6) Хорих ял оногдуулсан шүүгдэгч ял эдлэх хүмүүжүүлэх байгууллагын төрөл болон тус хүмүүжүүлэх байгууллагын дэглэм;
- 7) Тэнсэн харгалзах ялын үргэлжлэх хугацаа болон ялтанд оногдуулсан үүрэг;
- 8) ОХУ-ын Эрүүгийн хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу гаргасан нэмэгдэл ялын тухай шийдвэр;¹²⁸
- 9) Хэрвээ шүүхийн шийдвэр гарахаас өмнө шүүгдэгчийг саатуулсан эсвэл цагдан хорих, гэрийн хорио, энэ хуулийн 105.1 дүгээр зүйлийн зургадугаар хэсгийн 1 дэх заалтад заасан тодорхой үйлдлүүдийг хориглосон хэлбэрээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан эсвэл түүнийг хэвтэн эмчлүүлэх нөхцөлд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн байгууллагад, эсвэл хэвтэн эмчлүүлэх нөхцөлд сэтгэцийн тусламж үзүүлдэг эмнэлгийн байгууллагад байрлуулсан бол урьдчилан хорих хугацааг ял эдэлсэн хугацаанд тооцох тухай шийдвэр;
- 10) Тогтоол хүчин төгөлдөр болохоос өмнө шүүгдэгчид авсан таслан сэргийлэх арга хэмжээний тухай шийдвэр;

128 Уголовный кодекс Российской Федерации от 13.06.1996 N 63-ФЗ // Собрание законодательства РФ, 17.06.1996, N25, ст. 2954.// (Оросын Холбооны Улсын Эрүүгийн хууль 1996.06.13 N 63-XX // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга.1996.06.17, N 25, х. 2954.)

- 11) Хорих ялыг суурин-колони хорих газарт эдлүүлэхээр тогтоосон бол ял эдлэх этгээдийг ял эдлэх газар руу хүргэх тухай шийдвэр;
- 12) Эрх чөлөөг хязгаарлах ялын¹²⁹ хэлбэрээр шүүгдэгчид тогтоосон хязгаарлалт; Мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэрвээ шүүгдэгч эрүүгийн хуулийн хэд хэдэн зүйлээр гэмт хэрэгт буруутгагдсан бол тогтоолын тогтоох хэсэгт шүүгдэгч тэдгээрийн алинаас нь цагаатгагдаж, алинаар нь яллагдсан гэдгийг тодорхой заана.¹³⁰

Мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу шүүгдэгчийг ял эдлэхээс чөлөөлөх, ял эдлэхийг хойшлуулах эсвэл ял оногдуулахгүйгээр тогтоол гаргах тохиолдолд энэ тухай тогтоолын тогтоох хэсэгт заана. Мөн зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хэрэв торгуулийг ялын үндсэн эсвэл нэмэлт төрөл болгон оногдуулсан бол тогтоолын тогтоох хэсэгт Оросын Холбооны Улсын үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан торгуулийн дүнг шилжүүлэх төлбөр тооцооны баримт бичгийг бөглөх журмын дагуу шаардагдах мэдээллийг заана.

4. Тогтоолын тогтоох хэсэгт шийдвэрлэх бусад асуултууд

ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 309 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу энэ хуулийн 306¹³¹, 308¹³² дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд тогтоолын тогтоох хэсэгт дараах агуулгыг тусгана:

- 1) Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу иргэний нэхэмжлэлийн тухай шийдвэр;
- 2) Эд мөрийн баримтын талаарх асуудлыг шийдвэрлэх;
- 3) Процессын зардлыг (*орос хэлээр. процессуальные издержки*) хуваарилах тухай шийдвэр;

129 Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу эрх чөлөөг хязгаарлах ял гэж этгээдийг хорихгүйгээр түүний тодорхой эрхэнд хязгаарлалт тогтоохыг хэлнэ. Жишээлбэл: шүүхээс тогтоосон тодорхой хугацаанд тодорхой газар зорчихгүй байх, оршин суугаа газраа өөрчлөхгүй байх гэх мэт.

130 Уголовно-процессуальный кодекс Российской Федерации от 18.12.2001 № 174-ФЗ // Собрание законодательства РФ. - 24.12.2001. - № 52 (ч. I). - ст. 4921. // (2001 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн № 174 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга. – 2001.12.24. -№ 52 (1 х.). 4921 х).

131 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 306 дугаар зүйл. Цагаатгах тогтоолын тогтоох хэсэг.

132 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 308 дугаар зүйл. Шийтгэх тогтоолын тогтоох хэсэг.

Мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагатай, иргэний нэхэмжлэлтэй холбоотой нэмэлт тооцоо хийх шаардлагатай бол шүүх иргэний нэхэмжлэгчийн иргэний нэхэмжлэлийг хангуулах эрхийг хүлээн зөвшөөрч иргэний нэхэмжлэлийн нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой асуудлыг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан үзүүлэхээр шилжүүлнэ. Энэ тохиолдолд шүүгдэгч биш эсвэл шүүгдэгчийн үйлдлийн төлөө хуулийн дагуу эд хөрөнгийн хариуцлага хүлээсэн этгээдийн иргэний нэхэмжлэлийн шаардлагын дагуу гаргасан тогтоолын биелэлтийг хангахын тулд битүүмжилсэн эд хөрөнгийн битүүмжлэлийг зогсооно. Иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай эрүүгийн хэргийн материалуудын хуулбарыг харьяаллыг нь хуулиар тогтоосон шүүхэд шилжүүлнэ.

Мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу тогтоолын тогтоох хэсэгт энэ хуулийн 45.1 дүгээр бүлэгт заасан шаардлагын дагуу тогтоолыг давж заалдах хугацаа болон журмыг тайлбарлаж, шүүгдэгч болон цагаатгагдсан этгээд эрүүгийн хэргийг давж заалдах шатны шүүхэд хянан шийдвэрлэхэд оролцох хүсэлт гаргах эрхтэй болохыг тусгана.

Тус улсад шүүхийн тогтоол гаргахад дараах шаардлагыг хангасан байх ёстой гэж үздэг байна. Үүнд:

- ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 297 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу **шүүхийн тогтоол нь хууль ёсны, үндэслэлтэй бөгөөд шударга байх ёстой.**¹³³
- ОХУ-ын Дээд Шүүхийн Нийт Шүүгчдийн хуралдааны “Шүүхийн тогтоолын тухай” тогтоолын 41 дэх хэсэгт заасны дагуу **тогтоол нь тодорхой, ойлгомжтой үг хэллэгээр бичигдэх ёстой. Тогтоолд албан ёсны баримт бичигт ашиглагддаггүй, хүлээн зөвшөөрөгддөггүй товчлол**¹³⁴,

133 Уголовно-процессуальный кодекс Российской Федерации от 18.12.2001 № 174-ФЗ // Собрание законодательства РФ. - 24.12.2001. - № 52 (ч. 1). - ст. 4921. // (2001 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн № 174 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга. – 2001.12.24. -№ 52 (1 х.). 4921 х).

134 Росстандартын 2019.04.29-ний өдрийн (2020.12.30 ред.) «ОХУ-ын Үндэсний стандартыг батлах тухай» № 175-р тушаалд заасны дагуу орос хэлээр: «ОХУ» (орос хэлээр. РФ) гэсэн товчилсон үгийг албан ёсны баримт бичигт заавал «Оросын Холбооны Улс» (орос хэлээр. Российская Федерация) гэж бичнэ.

үг¹³⁵ ашиглаж болохгүй мөн түүнчлэн хянан үзэж буй хэрэгт хамааралгүй нөхцөл байдлыг тайлбарлан бичиж тогтоолыг хэт төвөгтэй болгож болохгүй.¹³⁶

Тухайн эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулсан тохиолдолд мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг шүүхийн шийдвэрт хэрхэн тусгаж байгааг судлан үзвэл, ОХУ-д мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн нь холбогдох эрүүгийн хэргийн нотлох баримт болно.¹³⁷ **Шүүхийн тогтоолд мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг холбогдох эрүүгийн хэргийн нотлох баримтын хувьд тусгана.** Шүүхийн дүгнэлтэд үндэслэл болсон нотлох баримтыг ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 307 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасны дагуу шийтгэх тогтоолын тайлбарлан – тодорхойлох хэсэгт тусгана.

Шүүхийн шийдвэрт нотлох баримтыг тусгаж буй байдлыг судлан үзвэл дараах онцлог шинжүүд ажиглагдлаа. ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 240 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн дагуу **шүүхийн тогтоолыг зөвхөн шүүх хуралдаанд судлагдсан нотлох баримтад үндэслэн гаргана.**

ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу **нотлох баримтын хувьд сэжигтэн, шүүгдэгчийн мэдүүлэг, хохирогч, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт болон мэдүүлэг, мэргэжилтний дүгнэлт болон мэдүүлэг, эд мөрийн баримт, шүүхийн болон мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэл, бусад баримт бичгүүдийг хүлээн зөвшөөрнө.**¹³⁸

135 Росстандартын 2019.04.29-ний өдрийн (2020.12.30 ред.) «ОХУ-ын Үндэсний стандартыг батлах тухай» № 175-р тушаалд заасны дагуу албан ёсны баримт бичигт бүдүүлэг үгсийг (жишээ нь: папан гэх мэтийг) ашиглаж болохгүй. **Эх сурвалж:** Приказ Росстандарта от 29.04.2019 № 175-ст (ред. от 30.12.2020) «Об утверждении национального стандарта Российской Федерации». – М.: Росстандарт, 2019. // (Росстандартын 2019.04.29-ний өдрийн (2020.12.30 ред.) «ОХУ-ын үндэсний стандартыг батлах тухай» № 175-р тушаал – М.: Росстандарт, 2019.)

136 Постановление Пленума Верховного Суда РФ от 29 ноября 2016 г. № 55 «О судебном приговоре» // Бюллетень Верховного Суда Российской Федерации. – 2017. – № 1. // (Шүүхийн тогтоолын тухай: ОХУ-ын Дээд Шүүхийн Нийт Шүүгчдийн Хуралдааны 2016.11.29 № 55 тогтоол. //ОХУ-ын Дээд шүүхийн мэдээллийн эмхэтгэл. -2017.- № 1).

137 Халиков А. Н. Институт негласных следственных действий в уголовно-процессуальном законе России и стран ближнего зарубежья (сравнительно-правовое исследование) // Правовое государство: теория и практика. – 2024. – № 1 (75). – С. 143.

138 Уголовно-процессуальный кодекс Российской Федерации от 18.12.2001 № 174-ФЗ // Собрание законодательства РФ. - 24.12.2001. - № 52 (ч. 1). - ст. 4921.// (2001 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн № 174 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан

ОХУ-ын Дээд Шүүхийн Нийт Шүүгчдийн хуралдааны “Шүүхийн тогтоолын тухай” тогтоолын¹³⁹ 6 дахь хэсэгт заасны дагуу тогтоолын тайлбарлан – тодорхойлох хэсэгт ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 305 дугаар зүйлийн¹⁴⁰ 1 дэх хэсгийн 3, 4 дэх заалт, 307 дугаар зүйлийн¹⁴¹ 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасны дагуу шүүх хуралдаанд судлагдсан шүүгдэгчийг буруутгах болон цагаатгах бүх нотлох баримтыг үнэлнэ. Үүний зэрэгцээ, **шүүх тогтоол гаргахдаа шийдвэрлэх асуултуудаар гаргасан дүгнэлтдээ үндэслэсэн нотлох баримтыг заах ба шүүх зарим нотлох баримтаас татгалзсан шалтгаанаа тусгана.** Хэрэв шүүх ямар нэгэн судлагдсан нотлох баримтуудыг хэрэгт хамааралгүй гэж үзвэл тогтоолд энэ тухай заана.¹⁴²

ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 75 дугаар зүйлд¹⁴³ зааснаар хууль зөрчиж олж авсан нотлох баримтыг ашиглахыг хориглох тухай шаардлагын дагуу шүүх ийм зөрчлийг тогтоож, хуулийн зөрчил нь яаж илэрсэн гэдгийг зааж, үүнийг нотлох баримтын хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай болон нотлох баримтаас хасах тухай шийдвэрээ тайлбарлана. Дээр дурдсанаар, ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 307 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасны дагуу шүүх нотлох баримтаас татгалзсан үндэслэлээ шийтгэх тогтоолын тайлбарлан – тодорхойлох хэсэгт тусгана.

Шүүхийн шийдвэрийг хуульд заасны дагуу боловсруулаагүй нь гомдол гаргах үндэслэлд хамаарна. Анхан шатны шүүх шийдвэрээ хуульд заасны дагуу боловсруулаагүй нь давж заалдах

шийдвэрлэх тухай хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга. – 2001.12.24. -№ 52 (1 х). 4921 х).

139 Постановление Пленума Верховного Суда РФ от 29 ноября 2016 г. № 55 «О судебном приговоре» // Бюллетень Верховного Суда Российской Федерации. – 2017. – № 1. // (Шүүхийн тогтоолын тухай: ОХУ-ын Дээд Шүүхийн Нийт Шүүгчдийн Хуралдааны 2016.11.29 № 55 тогтоол. //ОХУ-ын Дээд шүүхийн мэдээллийн эмхэтгэл. -2017.- № 1).

140 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 305 дугаар зүйл. Цагаатгах тогтоолын тайлбарлан – тодорхойлох хэсэг.

141 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 307 дугаар зүйл. Шийтгэх тогтоолын тайлбарлан – тодорхойлох хэсэг.

142 Постановление Пленума Верховного Суда РФ от 29 ноября 2016 г. № 55 «О судебном приговоре» // Бюллетень Верховного Суда Российской Федерации. – 2017. – № 1. // (Шүүхийн тогтоолын тухай: ОХУ-ын Дээд Шүүхийн Нийт Шүүгчдийн Хуралдааны 2016.11.29 № 55 тогтоол. //ОХУ-ын Дээд шүүхийн мэдээллийн эмхэтгэл. -2017.- № 1).

143 Оросын Холбооны Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 75 дугаар зүйл. Хүлээн зөвшөөрөгдөхгүй нотлох баримтууд.

шатны шүүхэд гомдол гаргах үндэслэл болно. Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 389.6 дугаар зүйлийн¹⁴⁴ 1 дэх хэсгийн 4 дэх заалтад заасны дагуу давж заалдах гомдолд энэ хуулийн 389.15¹⁴⁵ дугаар зүйлд¹⁴⁶ заасан үндэслэлүүдээс дурдсан давж заалдах гомдлыг гаргасан этгээдийн үзэл бодлыг тусгасан байх ёстой.

Анхан шатны шүүх шийдвэрээ хуульд заасны дагуу боловсруулаагүй нь шүүх **ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн зөрчил болно.** Жич: Шүүхийн ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчих нь ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 389.15 дугаар зүйлийн¹⁴⁷ 1 дэх хэсгийн 2 дахь заалтад зааснаар давж заалдах журмаар шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох эсвэл өөрчлөх үндэслэл болно.

Шүүхийн шийдвэрт латин нэр томьёо ашиглаж байгаа эсэхийг судлан үзвэл, **ОХУ-ын эрүүгийн хэргийн шүүхүүд тогтоолдоо латин нэр томьёо ашиглах нь ховор байдаг байна.** Учир нь ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг орос хэлээр, түүнчлэн ОХУ-ын бүрэлдэхүүнд орох Бүгд Найрамдах Улсуудын албан ёсны хэлээр явуулна. Мөн хуулийн 303 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “шүүх тогтоолыг шүүх хуралдааныг явуулсан хэлээр боловсруулна”¹⁴⁸ хэмээн заасан байх бөгөөд хэрвээ шүүх тогтоолдоо латин нэр томьёог тусгасан тохиолдолд тус нэр томьёоны орос хэлээр эсвэл холбогдох ОХУ-ын бүрэлдэхүүнд орох

144 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 389.6 дугаар зүйл. Давж заалдах гомдол, эсэргүүцэл.

145 Уголовно-процессуальный кодекс Российской Федерации от 18.12.2001 № 174-ФЗ // Собрание законодательства РФ. - 24.12.2001. - № 52 (ч. I). - ст. 4921. // (2001 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн № 174 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга. – 2001.12.24. -№ 52 (1 х.). 4921 х).

146 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 389.15 дугаар зүйлд заасан давж заалдах журмаар шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох эсвэл өөрчлөх үндэслэлүүд нь: эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн; эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн;

147 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 389.15 дугаар зүйл. Давж заалдах журмаар шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох эсвэл өөрчлөх.

148 Уголовно-процессуальный кодекс Российской Федерации от 18.12.2001 № 174-ФЗ // Собрание законодательства РФ. - 24.12.2001. - № 52 (ч. I). - ст. 4921. // (2001 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн № 174 ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // ОХУ-ын хууль тогтоомжийн цуглуулга. – 2001.12.24. -№ 52 (1 х.). 4921 х).

Бүгд Найрамдах Улсын хэлээр ямар утгатай болохыг орчуулж, хажууд нь заавал бичдэг байна. Жишээлбэл: *Nulla poena sine lege* (орос хэлээр. «Нет наказания без закона»)¹⁴⁹ (монгол хэлээр. «Хууль үгүй бол гэмт хэрэг үгүй»).

7. МОНГОЛ УЛС

Монгол Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын бүтэц, агуулгыг судлахдаа эрх зүйн зохицуулалт (i) болон шүүхийн практик (ii) гэсэн хэсэгт хуваан авч үзэв.

I. Эрх зүйн зохицуулалт

Монгол Улсад эрүүгийн хэргийн шүүхээс гаргах шийдвэр нь ямар агуулга, бүтэцтэй байх талаар бусад улстай харьцуулахад өргөн хүрээнд хуульчлан тогтоожээ. Тодруулбал, Монгол Улсын шүүхийн тухай хууль (2021)¹⁵⁰-ийн 22 дугаар зүйлд Шүүхийн шийдвэрийн талаарх ерөнхий зохицуулалт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)¹⁵¹-ийн 36.2 дугаар зүйлд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн хэлбэр, бүтэц, шүүхийн шийдвэрт тавигдах шаардлагын талаарх ерөнхий зохицуулалт, Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2021 оны 09 дүгээр сарын 20-ний өдрийн “Шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлалыг батлах тухай” 29 дугаар тогтоол¹⁵²-д шүүхийн шийдвэрийн бүтцийн хэсгүүдэд тусгах мэдээллийн агуулгыг нарийвчлан тусгажээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана”, 2 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал, журмыг Улсын дээд шүүх батална” хэмээн заасан. Мөн уг хуулийн 22.4 дүгээр

149 Ефименко Е. Латынь в суде: зачем она юристам и судьям [Электронный ресурс]. – 2019. – URL: <https://pravo.ru/story/212053/> (Дата обращения: 21.05.2025). // Ефименко Е. Латин хэл шүүхэд: хуульч, шүүгчдэд яагаад хэрэгтэй вэ [Цахим эх сурвалж]. – 2019. – URL: <https://pravo.ru/story/212053/> (Хандсан огноо: 2025.05.21).

150 Монгол Улсын шүүхийн тухай хууль, 2021, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106892006021>, (Сүүлд үзсэн: 2025.09.14).

151 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>, (Сүүлд үзсэн: 2025.09.14).

152 Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдааны 2021 оны 09 дүгээр 20-ний өдрийн 29 дугаар тогтоол, “Шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлалыг батлах тухай”, <https://www.supremecourt.mn/media/files/2024/04/15/2021-09-20-29.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.09.14).

зүйлд “Шүүх хэрэг, маргааныг хянан хэлэлцээд гаргасан шийдвэр нь дараах хэлбэртэй байна: 22.4.1. анхан шатны шүүх шийтгэх ба цагаатгах тогтоол, шүүхийн шийдвэр, шүүгч шийтгэвэр...”. хэмээн тус тус хуульчилсан байна.

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид “ЭХХШТХ” гэх)-ийн 36.2 дугаар зүйлд “Шүүхийн шийдвэрийн хэлбэр, бүтэц”-ийг тодорхой хуульчилжээ. Уг зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нэрийн өмнөөс гаргах шүүхийн шийдвэр нь шийтгэх, эсхүл цагаатгах хэлбэртэй байна” гэснээс харвал шүүх шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь нотлогдсон тохиолдолд шийтгэх тогтоол, холбогдсон үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжгүй, эсхүл шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй бол цагаатгах тогтоол гаргахаар байна. Харин шүүхийн шийдвэр ямар бүтэцтэй байх талаар уг зүйлийн 2 дахь хэсэгт тусгажээ.

Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлалын тухай (2006)

2006 оны “Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлалын тухай” зөвлөмж нь тухайн үеийн хууль (Иргэний байцаан шийдвэрлэх хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль гэх мэт)-ийн хүрээнд гарсан ч өнөөг хүртэл суурь зарчмын хувьд үнэ цэнээ алдаагүй байна. Уг зөвлөмжид шүүхийн шийдвэрийн бүтэц, хэсэг тус бүрийн агуулгыг нэг мөр ойлгож зөв хэрэглэх талаар тайлбарласан бөгөөд иргэн, эрүү, захиргааны хэрэг тус бүрийн онцлогийг дурджээ. Тухайлбал, шийдвэрийн “үндэслэх хэсэг” гэсэн ойлголтыг иргэний хэрэгт тусад нь задалж байсан бол эрүүгийн хэрэгт үндэслэх хэсгийг тодорхойлох хэсэгтэй нэгтгэн үзэх нь зүйтэй талаар зөвлөмжид тэмдэглэж байжээ. Шүүхийн шийдвэрийн найруулга, үг хэллэгийн хувьд өгүүлбэрийн бүтцийг ойлгомжтой энгийн байлгах, орчин цагийн хэл найруулгын шаардлагад нийцүүлэх талаар зөвлөсөн байх бөгөөд эдгээр зарчим нь өнөөгийн шинэ журамд ч мөн шингэсэн гэж хэлж болохоор байна.

Шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлал (2021)

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Улсын Дээд шүүх Нийт шүүгчдийн хуралдаанаараа шүүхийн шийдвэрийн загвар, аргачлал батлан мөрдүүлэх эрхтэй” гэж заасны дагуу Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдааны 2021 оны 09 дүгээр сарын 20-ний өдрийн “Шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлалыг батлах тухай” (цаашид “Шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлал” гэх) 29 дүгээр тогтоолыг батлан гаргасан.¹⁵³ Ингэснээр шүүхийн шийдвэрийг бичгээр боловсруулах нь нэгдсэн журам, загвартай болж, улсын хэмжээнд мөрдөгдөх жигд нөхцөл бүрджээ.

Шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлалд шүүхийн шийдвэрийн бүтцэд хамаарах хэсэг тус бүрийг хэрхэн зөв агуулга, хэлбэрийн шаардлагад нийцүүлэн бичих талаар нарийвчилсан зааварчилгааг тусгасан. Жишээлбэл, уг журамд **“шүүхийн шийдвэрийн бүх хэсэг хоорондоо уялдаа холбоотой байх, тогтоох хэсэг нь удиртгал, тодорхойлох хэсгийн үргэлжлэл байна”** гэж тусгайлан зааж, хэрэв удиртгал/тодорхойлох хэсэгт дүгнэсэн зүйл нь тогтоох хэсэгт өөрөөр бичигдвэл тухайн шийдвэрийг үндэслэлгүйд тооцно гэжээ. Мөн дээрх аргачлал нь ЭХХШТХ-д заасан “шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, биелүүлэхэд эргэлзээгүй байх ёстой...” шаардлагыг хэрэгжүүлэх үүднээс нарийвчлан тусгасан байна. Тухайлбал, **өгүүлбэр зүйн болон найруулгын алдаагүй байх, хууль зүйн нэр томьёог оновчтой хэрэглэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь үйл явдлыг дэс дараалалтай зөв илэрхийлэх, хэрэгт авагдсан баримтуудыг дурдахдаа мөр, хуудасны дараалал алдахгүй байх, эцсийн шийдвэрлэх хэсэгт бүх асуудлыг бүрэн хамруулах** гэх мэт.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтцийг ЭХХШТХ-ийн 36.2 дугаар зүйлд дараах байдлаар хуульчилжээ.

153 Монгол улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.2-т «Шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал, журмыг Улсын Дээд шүүх батална:

Шигтгээ №6. Монгол Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны
шүүхийн шийдвэрийн бүтэц

Шийтгэх тогтоолын бүтэц:

- 1) Удиртгал;
- 2) Тодорхойлох;
- 3) Тогтоох.

Шүүхийн шийдвэрийн дээрх бүтцэд тусгах шаардлагатай мэдээллийг ЭХХШТХ-д нарийвчлан хуульчилсан байна.

1. Удиртгал хэсэг

ЭХХШТХ-ийн 36.6 дугаар зүйлд **“Шүүхийн шийдвэрийн удиртгал хэсэг”-ийн** талаар зохицуулсан байх бөгөөд шийдвэрийн удиртгал хэсэгт ямар мэдээллүүд багтахыг тусгажээ. Үүнд:

- 1) Монгол Улсын нэрийн өмнөөс шийдвэр гаргасан;
- 2) Шийдвэрийг хэзээ, хаана гаргасан;
- 3) Шийдвэр гаргасан шүүхийн нэр, шүүх бүрэлдэхүүн, иргэдийн төлөөлөгч, шүүхийн нарийн бичгийн дарга, талууд, оролцогч;
- 4) Хэргийн дугаар;
- 5) Шүүгдэгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн газар, он, сар, өдөр, түүний оршин суугаа газар болон ажлын газар, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол, мэргэжил, гэр бүлийн байдал, хэрэгт ач холбогдол бүхий биеийн байцаалтын талаарх бусад мэдээлэл;
- 6) Шүүгдэгчийн холбогдсон хэрэг Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад хамаарах.

Шийдвэрийг хэзээ, хаана гаргасан талаарх мэдээллийг бичихэд баримтлах агуулгыг Шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлалд дараах байдлаар ойлгоно хэмээн тусгасан.

- **Хэзээ** гэдэгт шүүх хуралдаан хэдийн хугацаанд үргэлжилсэн гэдгээс үл хамаараад Монгол Улсын нэрийн

өмнөөс шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосон буюу шүүхийн шийдвэр гаргасан өдрийг ойлгоно.

- **Хаана** гэдэгт шүүх хуралдааныг явуулж шүүх шийдвэрээ гаргасан газар, шүүх хуралдааны танхимыг хэлнэ.

Шүүгдэгчийн хувьд ЭХХШтХ-ийн 36.6 дугаар зүйлийн 1.5 дахь хэсэгт заасан биеийн байцаалтын талаарх мэдээллийг оруулахаас гадна төрийн албан ёсны бүртгэлийн эх сурвалж болох тухайн хүний ургийн овог, регистрийн дугаарыг багтаах нь ижил нэртэй өөр хүнийг гэмт хэрэгт хилсээр шийтгэх, эсхүл овог нэр солигдсон мэдээллээс үүдэн гарч болзошгүй алдаанаас сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнд гагцхүү өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн шаардлагыг хангахад ач холбогдолтой.¹⁵⁴ Мөн тогтоолын удиртгал хэсэгт шүүгдэгчийн холбогдсон эрүүгийн хэргийн товч агуулга, гэмт хэргийн шинжид хамаарч байгаа үйлдэл, үйл баримтыг ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэн бичиж, тухайн хэрэг нь Эрүүгийн хуулийн ямар зүйл, ангид хамаарч байгааг дурдана. Ийнхүү **хэргийн товч агуулгыг тодорхойлохдоо яллах дүгнэлтийг хуулбарлахгүйгээр гэмт хэрэг гарсан байдлыг хураангуй боловч бүрэн илэрхийлж бичихийг зөвлөдөг байна.**

2. Тодорхойлох хэсэг

Тодорхойлох хэсэг нь гэмт хэргийн үйл баримтын талаарх дүгнэлт болон шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон эрх зүйн дүгнэлтээс бүрдэх учиртай. Энэ хэсэгт хэрэгт авагдсан болон хэргийн оролцогч нарын зүгээс гаргасан, тухайн хэргийн талаар тогтоовол зохих нөхцөл байдалд хамааралтай бүх мэдээлэл агуулагдсан байх ёстой. Иймээс **шүүх хуралдаанд шинжлэн судалсан нотлох баримт, баримт сэлт, эд мөрийн баримт нэг бүрийн талаарх мэдээллийг оруулахдаа агуулгын хувьд алдаагүй, товч, ойлгомжтой, логик зохилдлогоог хангасан байдлаар тусгасан байвал зохино.**¹⁵⁵

¹⁵⁴ Өмнөх эшлэл 152, 1.3 дахь хэсэг.

¹⁵⁵ Өмнөх эшлэл 152, 2.1 дэх хэсэг.

ЭХХШтХ-ийн 36.7 дугаар зүйлд “Шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэг”-т тусгах зүйлсийг нарийвчлан хуульчилсан байна. Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэг нь:

- Шүүгдэгчийг гэм буруутайд тооцох хэсэг;
- Шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэсэг 2 хэсгээс бүрдэнэ.

Шүүгдэгчийг гэм буруутайд тооцох хэсэгт дараах зүйлийг тусгана:

- 1) Гэмт хэрэг үйлдэгдсэн газар, цаг, хугацаа, арга, гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл, гэм буруугийн хэлбэр, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэр хэмжээ, шинжийг тогтоосон хэргийн талаарх нөхцөл байдал;
- 2) Шүүх хэд хэдэн шүүгдэгчид холбогдох хэргийг шийдвэрлэж байгаа бол шүүгдэгч тус бүрийн үйлдэл, оролцоо, гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэр;
- 3) Шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тооцсон шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтын агуулга, шүүх тухайн нотлох баримтыг хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, хууль ёсны гэж үзсэн улсын яллагчийн дүгнэлт, өмгөөлөгчийн саналын үндэслэл болгосон баримт, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг няцаан үгүйсгэсэн үндэслэл;
- 4) Шүүх хуралдаанаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдалд хийсэн хууль зүйн дүгнэлт;
- 5) Хэд хэдэн шүүгдэгчээс заримыг нь цагаатгасан, эсхүл шүүгдэгчийг яллаж байгаа зарим хэргийг хэрэгсэхгүй болгосон бол яллах нотлох баримтыг үгүйсгэсэн үндэслэл, тэдгээрийг нотлох баримтын агуулга.

Шүүх хэргийг хянан хэлэлцээд тогтоосон үйл баримтыг дүгнэж бичихдээ прокурорын яллах дүгнэлтэд дурдагдсаныг эсхүл

нотлох баримтын агуулгыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хуулбарлах, нотлох баримтын жагсаалтыг бичих байдлаар бус, харин тэдгээрт түшиглэн харьцуулах, нягтлах, батлах, үгүйсгэх зэрэг танин мэдэхүйн аргуудыг хэрэглэн сэргээн тогтоосон үйл явдлыг шүүгч өөрийн үг, өгүүлэмжээр, ойлгомжтой байдлаар дүрслэн илэрхийлж бичих ёстой хэмээн Шүүхийн шийтгэх тогтоол боловсруулах аргачлалд дурдсан байна. Харин **нотлох баримтуудыг шалгаж үнэлсэн байдлыг** тухайлбал, нотлох баримтыг үнэлсэн, үнэлээгүй үндэслэлийг, шаардлага хангасан, хангахгүй байгаа, эсхүл нотлох чадвартай, чадваргүй, хэрэгт хамааралтай, хамааралгүй болон үйл баримтыг тогтооход ач холбогдолтой, холбогдолгүй байгааг, мөн нөгөө талууд тухайн баримтыг хэрхэн үгүйсгэж байгаа, түүнийг шүүх зөвшөөрч буй, эсхүл няцааж буй дүгнэлтээ бичнэ.

Шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэсэгт дараах зүйлийг тусгана:

- 1) Шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтын агуулга, хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал, эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний үндэслэл;
- 2) Шүүгдэгчид хорих ял оногдуулсан бол уг ялыг эдлүүлэх хорих байгууллагын дэглэмийг заасан үндэслэл;
- 3) Урьд сонсгосон ялыг шүүхээс хөнгөрүүлж өөрчилсөн бол түүний үндэслэл, тэдгээрийг нотлох баримтын агуулга;
- 4) Шүүгдэгчийг ял эдлэхээс чөлөөлсөн болон Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан албадлагын арга хэмжээ хэрэглэсэн үндэслэл;
- 5) Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигтай холбоотой нэхэмжлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хангах тухай, эсхүл хэрэгсэхгүй болгох, эсхүл хэлэлцэхгүй орших тухай үндэслэл;
- 6) Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, гэмт хэрэг үйлдэхэд

ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг хураах үндэслэл.

Шүүхээс аливаа гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага оногдуулахдаа тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршиг, шүүгдэгчийн хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзэх үүрэгтэй бөгөө ингэхдээ эрүүгийн хариуцлагын нийтлэг зорилгыг хангах, түүнчлэн гэмт үйлдлийн шинж чанар болон ял шийтгэлийн хэр хэмжээ нь хоорондоо хамгийн зүй зохистой харьцаагаар нийцсэн байх шударга ёсны зарчимд хэрхэн нийцсэн байгааг дүгнэж бичнэ.¹⁵⁶

3. Тогтоох хэсэг

Шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон тухай дүгнэлт, түүнд оногдуулсан ял болон хэргийн талаар шүүхээс гаргасан бусад шийдвэрүүдийг заана. Ийнхүү заахдаа ЭХХШТХ-ийн 36.8 дугаар зүйлд заасан Шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн дарааллыг баримтална:

- 1) Шүүгдэгч Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болох;
- 2) Шүүгдэгчид хэрэглэсэн албадлагын арга хэмжээ, оногдуулсан ялын төрөл, хэмжээ, Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлд заасны дагуу тодорхойлсон эдэлбэл зохих ялын хэмжээ;
- 3) Хорих ял оногдуулсан хүний ял эдлэх хорих байгууллагын дэглэм;
- 4) Шүүгдэгч нь шүүхийн шийтгэх тогтоол гарахын өмнө баривчлагдсан, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хугацааг ял оногдуулахдаа хэрхэн тооцсон;
- 5) Шүүхийн шийтгэх тогтоолыг хуулийн хүчин төгөлдөр болтол шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх эсэх тухай;

156 Өмнөх эшлэл 152, 2.1.5 дахь хэсэг.

- 6) Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд торгох ял оногдуулах, эсхүл хохирогчид хохирол, хор уршгийг нөхөн төлж барагдуулах бол мөнгөн төлбөр, хохирол барагдуулах ажиллагааг ямар хугацаанд, ямар хэмжээгээр хийх;
- 7) Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигтай холбоотой нэхэмжлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хангах тухай, эсхүл хэлэлцэхгүй орхих үндэслэл;
- 8) Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэх тухай;
- 9) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг хуваарилсан тухай.

Эдгээр заалтууд нь шүүгч шийдвэр бичихдээ хуульд заасан хэлбэрийг чанд мөрдөх, шүүхийн шийдвэрийг хуульд нийцүүлэх, шүүхийн шийдвэрийн нэгдмэл бүтцээр гаргахад үндэс суурь болж өгдөг байна.

Шүүх хуулийг тайлбарлан хэрэглэж буй эцсийн хэлбэр нь шүүхийн шийдвэр билээ. Иймд үндэслэл бүхий шүүхийн шийдвэрийг боловсруулах нь шүүхийн нэг чухал үүрэг юм. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд бий болсон шүүгчийн оюун дүгнэлт бүхий шүүхийн шийдвэр нь хувь шүүгчийн бодол бус, харин хуулийн засаглалыг хэрэгжүүлж, маргааны үйл баримтад хүний эрхийн заалтыг хэрэглэж буй магадлагаа байдгаараа онцлогтой.¹⁵⁷

Шүүхийн шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх ерөнхий шаардлагатай бөгөөд энэ нь дараах байдлаар тодорхойлогдоно.¹⁵⁸ Шүүхийн шийдвэр “хууль ёсны” байх шаардлагад:

- 1) Шүүх нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг¹⁵⁹,

157 Солтанмуратын Өмирбек, Шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэх эрх” [legalddata.mn](https://legalddata.mn/buteel/pdf?id=159), 2016, 4 дэх тал, <https://legalddata.mn/buteel/pdf?id=159>. (Сүүлд үзсэн: 2025.09.14).

158 Цэндийн Цогт, Анхан шатны шүүхийн шийдвэрт эрх зүйн дүгнэлт бичих (“Брайт пэйнт” ХХК-ийн нэхэмжлэлтэй хэргийн жишээ дээр), [legalddata.mn](https://legalddata.mn/buteel/pdf?id=340), 2016, <https://legalddata.mn/buteel/pdf?id=340>. (Сүүлд үзсэн: 2025.09.14).

159 Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”

Хорин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг¹⁶⁰, Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэг¹⁶¹-т заасан “Үндсэн хуульд нийцсэн, албан ёсоор нийтлэгдсэн” хууль, “нэгдэн орсон буюу соёрхон баталсан хууль хүчин төгөлдөр болсон Монгол Улсын олон улсын гэрээ” хэрэглэсэн байх;

- 2) Материаллаг хуулийн хэрэглээний зарчмуудад нийцсэн байх;
- 3) Процессын хуульд заасан процессын зохицуулалтад нийцсэн, хэргийн оролцогчдын эрхийг хангасан, процессын зөрчилгүй байх шаардлага хамаарна.

Шүүхийн шийдвэрт тавигдах зарим ерөнхий шаардлагыг ЭХХШтХ-ийн 36.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт **“Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байна”** хэмээн заасан байх бөгөөд үүнийг шүүхийн шийдвэрийн бичгийн соёл, агуулгын чанарт тавигдах суурь шаардлага хэмээн тодорхойлж болохоор байна. ЭХХШтХ-д зааснаар анхан шатны шүүхийн шийдвэрийн агуулгад хамаарах өөр нэг чухал зохицуулалт нь эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл гаргахтай холбоотой асуудал бөгөөд уг хуулийн 36.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх шийтгэх тогтоол гаргахдаа иргэний нэхэмжлэлийг түүний үндэслэл, хэмжээний нотлогдсон байдлыг харгалзан бүгдийг, эсхүл хэсэгчлэн хангах, эсхүл хэрэгсэхгүй болгоно” гэж зохицуулжээ.

Дашрамд дурдахад, шүүхийн шийдвэрийн загварууд нь зөвхөн ерөнхий бүтэц, хэсгүүдийн дарааллыг харуулсан байдгаас бус, хэрэг болгоны өвөрмөц нөхцөл байдлыг шүүгч өөрөө үндэслэлтэйгээр бичих учиртай. Иймд шүүхийн шийдвэрийн загвар ашиглахдаа дээр дурдсанчлан хууль, журмын шаардлагыг бүрэн тусгаж, хэргийн

160 Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно.”

161 Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх”

холбогдох дүгнэлтийг хийн эцэслэх нь шүүгчийн мэргэжлийн ур чадвар байна. Үр дүнд нь шүүхийн шийдвэр тодорхой, үндэслэл сайтай болж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар дээшлэх нөхцөл бүрддэг.

Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр нь хуульд заасан тодорхой бүтэц, хэсгүүдээс бүрдэж, тэрхүү хэсэг бүрд агуулга, хэлбэрийн өндөр шаардлага тавигддаг. Шүүхийн шийдвэр нь зөвхөн шүүгчийн дотоод итгэл, хэрэгт авагдсан нотлох баримтад сууриалаад зогсохгүй, түүнийг хэрхэн маргаангүй ойлгомжтой илэрхийлж бичсэн байхаас ихээхэн хамаардаг. Иймд хууль тогтоомж болон Улсын дээд шүүхээс баталсан журам нь шүүхийн шийдвэрийн бүтцийг жигдлэх, бичилтийн чанарыг дээшлүүлэхэд чиглэж байна.

II. Шүүхийн практик

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр нь ЭХХШтХ болон Шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлалд нийцсэн эсэх талаар давж заалдах болон хяналтын шатны шүүхээс дүгнэлт хийсэн магадлал, тогтоолыг шүүхийн практик хэсэгт судлав.

Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-д нийтлэгдсэн шийдвэрүүдээс харвал, хуульд заасан шүүхийн шийдвэрийн хэлбэр, бүтцийн талаарх шаардлагыг хангаагүй нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ноцтой зөрчил хэмээн үзэж дээд шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон эсвэл шийдвэрийг хэвээр үлдээсэн боловч цаашид анхаарах шаардлагатай гэж үзсэн давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоолууд байв. Эдгээр шийдвэрийг агуулгаар нь авч үзвэл:

- Анхан шатны шүүхийн шийдвэр нь хуульд заасан хэлбэр, бүтцийн шаардлагыг бүрэн хангаагүй;
- Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн байдлаар эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байх шаардлагыг хангаагүй;
- Хуулийн үндэслэл, нотлох баримтыг дутуу тусгасан зэрэг

үндэслэлээр дээд шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг тус тус хүчингүй болгожээ.

1) Анхан шатны шүүхийн шийдвэр нь хуульд заасан хэлбэр, бүтцийн шаардлагыг бүрэн хангаагүй

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэр нь ЭХХШтХ-д заасан шүүхийн шийдвэрийн хэлбэрийг баримтлаагүй нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн хэмээн үзэж, шийдвэрийг хүчингүй болгосон магадлалыг доорх хүснэгтэд харуулав. Ингэхдээ анхан шатны шүүхийн шийдвэр хуульд заасан хэлбэр, бүтцийг баримтлаагүй талаар гаргасан **гомдлын агуулга болон уг гомдолд шүүхээс өгсөн дүгнэлтийг** тусгав.

Шигтгээ №9. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 2025/ДШМ/605 дугаар магадлал

Давж заалдах шатны шүүхэд гаргасан прокурорын эсэргүүцэл:

Цагаатгах тогтоолын тогтоох хэсэгт "...шүүгдэгч Н.Т-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, шүүгдэгч Х.Х.Мг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт тус тус холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т зааснаар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, цагаатгасугай." гэж шийдвэрлэсэн байна. Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 29 дугаартай "Шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлалыг батлах тухай" тогтоолоор батлагдсан "Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх/цагаатгах/ тогтоол боловсруулах аргачлал"-ын 2.2-т Цагаатгах тогтоолын тодорхойлох хэсэг "Энэ хэсэгт тухайн үйлдлийг шүүгдэгч хийгээгүй буюу хийсэн үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдохгүй гэдгийг үндэслэх шаардлагатай", 3.1-т Тогтоолын тогтоох хэсэг "Тогтоолын бүх хэсэг нь хоорондоо харилцан уялдаа холбоотой тул тогтоох хэсэг нь удиртгал болон тодорхойлох хэсгийн үргэлжлэл юм. Тогтоох хэсэг нь удиртгал болон тодорхойлох хэсэгтэй зөрчилдвөл тогтоолыг үндэслэлгүй болсон гэж үзнэ" гэж тус тус заасан.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг "Шүүх хуралдааны үед шүүгдэгч гэм буруутай болох нь нотлогдсон бол шүүх шийтгэх тогтоол гаргана", 5 дахь хэсэгт "Шүүгдэгчийн холбогдсон үйлдэл, эс үйлдэхгүй нь гэмт хэргийн шинжгүй, эсхүл шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй бол шүүх цагаатгах тогтоол гаргана" гэснийг тус тус зөрчсөн байна. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүхээс шүүгдэгч Н.Т, Х.М нарыг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон гэж тогтоолын тодорхойлох хэсэгт дүгнэсэн атлаа тогтоох хэсэгт цагаатган шийдвэрлэж байгаа нь ойлгомжгүй, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлд заасан "Шүүхийн шийдвэрийн хэлбэр, бүтэц"-ийг зөрчсөн ба шүүгдэгч нарыг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон бол шийтгэх тогтоол гаргасан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.8 дугаар зүйлд заасан "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчих" гэсэн эсэргүүцэл бичих үндэслэлд хамаарч байна.

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 2025/ДШМ/605 дугаар магадлал¹⁶²

Анхан шатны шүүх "...Н.Т нь Х.М-г тус компанид монтёрын ажилд оруулж өгнө гэж 1.000.000 төгрөг авсан санаатай үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхийн тулд хахууль авсан гэмт хэргийн шинжтэй, шүүгдэгч Х.М нь Н.Тод 1.000.000 төгрөг өгсөн үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан өөртөө давуу байдал бий болгох зорилгоор бусдад албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдалтай нь холбогдуулан хахууль өгсөн гэмт хэргийн шинжтэй байх тул тэднийг дээрх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцов..." гэсэн хууль зүйн дүгнэлт хийсэн атлаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т зааснаар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, тэднийг цагаатгаж шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй болжээ.

162 НЭХДЗШШ-ийн 2025 оны 05 сарын 21-ний өдрийн 2025/ДШМ/605 магадлал, https://shuukh.mn/single_case/22339?bb=1&court_cat=2&end_date=&id=2&start_date=&utm

Шигтгээ №10. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 499 дугаар магадлал

Давж заалдах шатны шүүхэд гаргасан прокурорын эсэргүүцэл:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нэрийн өмнөөс гаргах шүүхийн шийдвэр нь шийтгэх эсхүл... хэлбэртэй байна” мөн 4 дэх хэсэгт “...шүүгдэгч гэм буруутай болох нь нотлогдсон бол шүүх шийтгэх тогтоол гаргана” гэж хуульчилсан байхад Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тогтоол гэж гаргасан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6 дахь заалтад зааснаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн байна.

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 499 дугаар магадлал¹⁶³

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нэрийн өмнөөс гаргах шүүхийн шийдвэр нь шийтгэх эсхүл... хэлбэртэй байна” мөн 4 дэх хэсэгт “...шүүгдэгч гэм буруутай болох нь нотлогдсон бол шүүх шийтгэх тогтоол гаргана” гэж, мөн хуулийн 39.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6 дахь заалтад “шүүхийн шийдвэр нь энэ хуулийн 36.2, 36.6, 36.7, 36.8, 36.9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй” бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчсөн гэж үзнэ гэж хуульчилжээ. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол нь бичгэн хэлбэртэй гарч, хэргийн оролцогчдод гардуулахдаа буюу прокурорт очсон хувь нь шүүхийн тогтоол хэлбэрээр гардуулагдсан байгаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчсөн байна.

163 НЭХДЗШШ-ийн 2022 оны 05 сарын 10-ны өдрийн 2022/ДИМ/499 магадлал, https://shuukh.mn/single_case/14286?bb=1&court_cat=2&end_date=&id=2&start_date=&utm

Шигтгээ №11. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 1058 дугаар магадлал

Давж заалдах шатны шүүхэд гаргасан прокурорын эсэргүүцэл:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нэрийн өмнөөс гаргах шүүхийн шийдвэр нь шийтгэх, эсхүл цагаатгах хэлбэртэй байна.” гэж заасныг зөрчсөн, өөрөөр хэлбэл Э.Г-т холбогдох эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг “Шийтгэвэр”-ээр гаргасан нь үндэслэлгүй байна.

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 1058 дугаар магадлал ¹⁶⁴

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 3 дахь заалтад зааснаар “шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байх” хуулийн заалтыг зөрчиж гарсан байна. Учир нь, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нэрийн өмнөөс гаргах шүүхийн шийдвэр нь шийтгэх, эсхүл цагаатгах хэлбэртэй байна.” гэж шүүхийн шийдвэрийн хэлбэр бүтцийг тодорхойлсон бөгөөд мөн хуулийн 4 дэх хэсэгт “шүүгдэгч гэм буруутай болох нь нотлогдсон бол шүүх шийтгэх тогтоол гаргана”, 5 дахь заалтад “шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй бол шүүх цагаатгах тогтоол гаргана”, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “шүүхээс гарах шийдвэр нь шийтгэвэр хэлбэртэй байна” гэж тодорхой заажээ. Гэтэл анхан шатны шүүх шүүгдэгч Э.Г-т холбогдох хэргийг шийдвэрлэж 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 74 дугаартай шийтгэх тогтоолыг хэрэгт хавсаргасан атлаа 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр улсын яллагчид Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 74 дугаартай “шийтгэвэр”-ийг гардуулсан байна.

Анхан шатны шүүх эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж шүүгдэгчийг гэм буруутайд тооцон **шийтгэх тогтоол гаргасан байх боловч тухайн тогтоолоо улсын яллагчид гардуулахдаа “шийтгэвэр” гэсэн хэлбэртэйгээр гаргасныг давж заалдах шатны шүүхээс зөвтгөх боломжгүй байх тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.8 дугаар зүйлд зааснаар шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болж байна.**

164 НЭХДЗШШ-ийн 2020 оны 08 сарын 20-ны өдрийн 1058 магадлал, https://shuukh.mn/single_case/10752?bb=1&court_cat=2&end_date=&id=2&start_date=&utm

Дээрхээс үзэхэд, зарим тохиолдолд анхан шатны шүүхээс “шийтгэвэр”, “шүүхийн тогтоол” гэх мэт буруу нэршил ашигласан, хэргийн оролцогч нарт зарим хуудас нь өөр шийдвэрийн хэсгийг хавсаргасан шийдвэр гардуулсныг дээд шатны шүүхээс шүүхийн шийдвэрийн хэлбэр, бүтцийг хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзжээ. Мөн түүнчлэн, хэргийн оролцогч нарт гардуулсан шүүхийн шийдвэр нь техникийн шинжтэй алдаатай буюу зарим хуудас нь солигдсон зэрэг нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй боловч шүүх сонсгож танилцуулсан шийдвэрээ албажуулж, гардуулахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Эрүүгийн хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал, Шүүхийн шийдвэр боловсруулах журмыг тус тус ягштал баримтлах ёстой¹⁶⁵ байна.

2) Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн байдлаар эргэлзээ төрүүлэхгүй байх

ЭХХШтХ-д шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байх шаардлагыг тавьдаг бөгөөд уг шаардлагыг хангаагүй гэж үзсэн давж заалдах шатны шүүхийн магадлал болон хяналтын шатны шүүхийн тогтоолыг доорх хүснэгтэд харуулав.

165 УДШ-ийн 2024 оны 07 сарын 03-ны өдрийн 99 тогтоол,
https://shuukh.mn/single_case/3621?daterange=2024-07-03%20-%202024-07-03&id=3&court_cat=2&bb=1

Шигтгээ №12. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 2025/ДШМ/856 дугаар магадлал

Давж заалдах шатны шүүхэд гаргасан прокурорын эсэргүүцэл:

Шүүх шийдвэрээ уншиж сонсгох үедээ “шүүгдэгч М.Г-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хулгайлах” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хорих ял оногдуулахгүйгээр 1 жилийн хугацаагаар тэнсэж, 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2, 2.5-д зааснаар “сургалтад хамрагдах, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх” үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх ял оногдуулж шийдвэрлэсэн” гэж танилцуулсан атлаа шүүхээс гарсан шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 2-т “шүүгдэгч М.Г-т Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг журамлан тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хорих ял оногдуулахгүйгээр 1 жилийн хугацаагаар тэнсэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад заасан “Зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгож сургалтад хамрагдах, 3 дахь хэсгийн 3.1 дэх заалтад заасан “Тодорхой газар очих, тодорхой хүнтэй хязгаарлах” үүрэг хүлээлгэж, түүнд хяналт тавихыг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт даалгаж” шийдвэрлэсэн гэж зөрүүтэй бичсэн байгаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.9-д заасан “анхан шатны шүүх хуралдааны тэмдэглэл, дуу, дүрсний бичлэг зөрүүтэй бол” гэх заалтыг зөрчсөн байна.

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 2025/ДШМ/856 дугаар магадлал¹⁶⁶

Шүүгдэгч М.Г-т холбогдох хэргийн анхан шатны шүүх хуралдааны дуу-дүрсний бичлэгийн тогтоох хэсгийг сонсоход шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсгээс зөрүүтэй бичигдсэн байна. Тодруулбал, шүүх шүүхийн шийдвэрийг уншиж, сонсгоходоо “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1 дэх заалтад заасан “тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах” үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг аваагүй болох нь шүүх хуралдааны дуу-дүрсний бичлэгээр тогтоогдож байна.

166 НЭХДЗШШ-ийн 2025 оны 07 сарын 22-ны өдрийн 2025/ДШМ/856 магадлал, https://shuukh.mn/single_case/22967?start_date=&end_date=&id=2&court_cat=2&bb=1.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байна” гэж заасан шаардлагад нийцэхгүй.

Шигтгээ №13. Улсын дээд шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 09 ний өдрийн 2024/ХШТ/118 дугаар тогтоол

Хяналтын шатны шүүхэд гаргасан прокурорын эсэргүүцэл:

Магадлалын 4 дүгээр хуудсанд “оногдуулсан торгох ялд хэрхэн дүйцэгдэж хасагдан тооцогдох нь тодорхойгүй буюу «Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байна.» гэсэн шаардлагыг хангахгүй байна. Түүнчлэн шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 7, 8 дахь заалтуудын дугаарлалтад гар аргаар засвар оруулсан нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан «Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам»-ын 8.1 дүгээр зүйлийн 8.1.5 дахь хэсэгт «Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хориглох зүйл: Баримт бичгийн батлагдсан эх хувийг өөрчлөх, засварлах, устгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн.

Улсын дээд шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 2024/ХШТ/118 дугаар тогтоол¹⁶⁷

Хэргийн материалаас үзэхэд шүүгдэгч Б.Э нь урьд 5 удаа, шүүгдэгч Д.У нь урьд 7 удаа тус тус шүүхээс гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдож, ял шийтгүүлж байжээ. Гэтэл Хөвсгөл аймгийн прокурорын газрын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 406 дугаар ялах дүгнэлт, шийтгэх тогтоол, магадлалын удиртгал хэсэгт шүүгдэгч Б.Э-ын биеийн байцаалтыг “...урьд 7 удаагийн ял шийтгэлтэй, Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 02 дугаар сарын 21-ний 64 дугаартай шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 1 жил 6 сарын хугацаагаар хорих ял оногдуулж шийдвэрлэсэн...” гэж 8 удаагийн ял шийтгэлтэй мэтээр, шүүгдэгч Д.У-ын биеийн байцаалтыг “...урьд 6 удаагийн ял шийтгэлтэй, Хөвсгөл аймаг дахь

167 Улсын Дээд шүүхийн 2024 оны 10 сарын 09-ний өдрийн 2024/ХШТ/118 тогтоол, https://shuukh.mn/single_case/3635?daterange=2024-10-09%20-%202024-10-09&id=3&court_cat=2&bb=1

сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 198 дугаартай шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, хорих ял оногдуулахгүйгээр 1 жилийн хугацаагаар тэнсэж шийдвэрлэсэн ..." гэж 7 удаагийн ял шийтгэлтэй мэтээр ойлгомжгүй байдлаар, буруу бичсэн байгаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, ... бичигдсэн байна" гэж заасантай нийцэхгүй байна. Хэдийгээр энэ нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох хуулийн үндэслэлд хамаарахгүй боловч цаашид анхаарах нь зүйтэй болохыг тэмдэглэв.

Шигтгээ №14. Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 17 дугаар магадлал

Давж заалдах шатны шүүхэд гаргасан прокурорын эсэргүүцэл:

Ялтны зүгээс торгох ялыг хэсэгчлэн төлөх талаар санал гаргаагүй, шүүх торгуулийг хэсэгчлэн төлүүлэх шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 160 дугаар зүйлийн 160.1 дэх хэсэгт зааснаар 90 хоног буюу 3 сарын дотор ялтан торгох ялыг биелүүлэх үүрэгтэй. Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт «торгох ялыг биелүүлэх хугацааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар тогтоох нь зүйтэй» гэж дүгнэсэн байх бөгөөд хуульд тодорхойлон заасан хугацааг шүүхээс дахин тогтоох шаардлагагүй. Түүнчлэн шийтгэх тогтоолд шүүгдэгч Ц.Т-ын үйлдсэн гэмт хэргийн талаар шүүхээс дүгнэлт хийхдээ гэмт хэрэг гарсан цаг хугацааг «2019 он, 2020 он» гэж 2 өөр байдлаар дурьдсан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй.

Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 17 дугаар магадлал¹⁶⁸

Шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт “торгох ялаар шийтгэж торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно” гэснийг дагаж мөрдөөгүй хугацаа тогтоож өгөөгүй байж “шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол” гэж зааж өгсөн нь ойлгомжгүй болжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийн хэлбэр, бүтцэд зааснаар “шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байна” гэсэн заалтыг биелүүлж ажиллах нь зүйтэй.

168 Булган аймгийн ЭНХДЗШШ-ийн 2020 оны 04 сарын 02-ны өдрийн 17 магадлал, https://shuukh.mn/single_case/9506?start_date=&end_date=&id=2&court_cat=2&bb=1

Шигтгээ №15. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 688 дугаар магадлал

Давж заалдах шатны шүүхэд гаргасан прокурорын эсэргүүцэл:

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдаанаар Л.О-ыг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 500 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 500.000 төгрөгөөр торгох ял оногдуулсан. Гэтэл 363 дугаартай шийтгэх тогтоолд Л.О-ыг 450 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 450.000 төгрөгөөр торгох ял оногдуулсан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэр уншиж сонсгосноор хүчинтэй болно” гэж, мөн хуулийн 36.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т “...Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлд заасны дагуу тодорхойлсон эдэлбэл зохих ялын хэмжээ...” гэж тус тус заасныг зөрчиж, Л.О-т холбогдох эрүүгийн хэргийн 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн шүүх хуралдааны тэмдэглэлд “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Л.О-ыг 500 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 500.000 төгрөгөөр торгох ялаар шийтгэх” гэж заажээ.

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 688 дугаар магадлал¹⁶⁹

Анхан шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлээд гаргасан шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 2 дахь заалтад “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Л.О-ыг 450 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 450.000 төгрөгөөр торгох ялаар шийтгэсүгэй.” гэж ял оногдуулсан атлаа шүүх хуралдааны тэмдэглэл болон ял шийтгэлийн тэмдэглэлд 500 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 500.000 төгрөгөөр торгох ял гэж бичсэн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.10 дугаар зүйлийн 4-д “Шүүхийн шийдвэр уншиж сонсгосноор хүчинтэй болно.” гэж, мөн хуулийн 36.2 дугаар зүйлийн 3-т “Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байна” гэсэн дээрх хуулийн заалтуудыг зөрчжээ.

169 НЭХДЗШШ-ийн 2019 оны 07 сарын 02-ны өдрийн 668 магадлал, https://shuukh.mn/single_case/7907?bb=1&court_cat=2&end_date=&id=2&start_date=&

Шигтгээ №16. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 423 дугаар магадлал

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд

“Daewoo загварын 94-25 ОРО улсын дугаартай тээврийн хэрэгсэл битүүмжилснийг хохиролд тооцон олгож, Toyota Estima загварын 47-42 УБА улсын дугаартай тээврийн хэрэгслийг эзэнд нь буцаан олгож” шийдвэрлэсэн.

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 423 дугаар магадлал¹⁷⁰

Шүүхийн шийтгэх тогтоол нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байх хуулийн шаардлагатай байдаг.

Гэтэл анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 5 дахь заалт ойлгомжгүй байдлаар бичигдсэн байх тул Daewoo маркийн 94-25 ОРО улсын дугаартай тээврийн хэрэгслийг хохиролд тооцуулахаар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж, Toyota Estima маркийн 47-42 УБА улсын дугаартай тээврийн хэрэгслийг өмчлөгч Д.Батжаргалд буцаан олгож хэмээн агуулгын хувьд өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Дээрхээс үзэхэд, шүүгдэгчийн ял шийтгэл, гэмт хэрэг үйлдсэн байдлыг буруу эсвэл тодорхойгүй байдлаар тэмдэглэсэн, тодорхойлох хэсэгт гэм буруутай гэж дүгнэсэн атлаа цагаатгаж шийдвэрлэсэн зэрэг нь шүүхийн шийдвэр тодорхой, ойлгомжтой байх хуулийн шаардлагыг хангаагүй гэж үзэх үндэслэл болжээ. Мөн түүнчлэн шүүх шийдвэрийг уншиж сонгосон агуулгаас өөр агуулгаар бичгээр гаргасныг шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байх шаардлагыг хангаагүй хэмээн үзсэн байна.

170 НЭХДЗШШ-ийн 2019 оны 05 сарын 07-ны өдрийн 423 магадлал,
https://shuukh.mn/single_case/7635?bb=1&court_cat=2&end_date=&id=2&start_date=&utm

3. Хуулийн үндэслэл, нотлох баримтыг дутуу тусгасан.

Шигтгээ №17. Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 2023/ДШМ/12 дугаар магадлал

Давж заалдах шатны шүүхэд гаргасан шүүгдэгчийн өмгөөлөгчийн гомдол:

Шүүгдэгч Э.З- нь эхнэр, бага насны 3 хүүхдүүдийн хамт амьдарч амьдралаа залгуулж явдаг зэрэг байдлыг харгалзаж Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэлд хамаарах буюу үйлдсэн хэрэгтээ чин сэтгэлээсээ гэмшиж буй байдал, амьдралын талаарх хүсэл зорилго, хандлага, хүмүүжил болоод цаашид гэр бүлээ тэжээн тэтгээж, хариуцлага хүлээж байгаа байдал зэрэг онцгой нөхцөл байдлыг харгалзан үзэж мөн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.3-т “...гэмт хэрэг үйлдсэн хүн тухай гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол тухайн зүйл хэсэг заалтад заасан ялын доод хэмжээний хоёрны нэгээс багагүй ял оногдуулах заасан байна. Иймд түүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал зэргийг харгалзан үзэж түүнд оногдуулсан хорих ялыг хөнгөрүүлэн өөрчилж өгнө үү.

Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 2023/ДШМ/12 дугаар магадлал¹⁷¹

Шүүгдэгчид 2 жил 1 сарын хорих ял оногдуулахаар тогтоохдоо “...гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн, хувийн байдал, хохирлын хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нөхцөл...” зэргийг харгалзан үзсэн гэх боловч шүүгдэгчийн өмгөөлөгчийн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-т зааснаар ялыг хөнгөрүүлж өгөх талаар гаргасан саналын талаар ямар нэгэн дүгнэлт, няцаалт хийгээгүй байгаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-ийн “шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтын агуулга, хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал, эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний үндэслэлийг тусгана” гэсэн заалтад нийцээгүй байна.

Анхан шатны шүүх шийдвэр гаргахдаа хууль зүйн дүгнэлт хийгээгүйгээс шүүхийн шийдвэрт тавигдах хуулийн шаардлагыг хангаагүй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.8 зүйлийн 1 дэх хэсгийн 1.6-д заасан ноцтой зөрчил гаргасан байна.

171 Хэнтий аймгийн ЭИХДЗШШ-ийн 2024 оны 02 сарын 28-ны өдрийн 2023/ДШМ/12 магадлал, https://shuukh.mn/single-case/18925?bb=1&court_cat=2&end_date=&id=2&start_date=&utm

Шигтгээ №18. Улсын дээд шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 594 дүгээр тогтоол

Хяналтын шатны шүүхэд гаргасан шүүгдэгчийн гомдол:

2020.04.24-ний өдөр анхан шатны шүүх дахин хуралдаж надад 5 жил 5 сар 4 хоногийн хорих ялыг оногдуулж давж заалдах гомдол гаргасан боловч хохирлын хэмжээг Ж.Ц, О.Б, Т.Т нартай хамтран төлөлцөөгүй учир ялыг минь хэвээр үлдээж шийдвэрлэсэн. Иймд хохирлоо төлөлцөх хүсэлт байсан боловч нөхцөл байдал нь бүрдээгүй хоригдож байсан учир мөн хийсэн хэрэгтээ гэмшиж байна, эрх зүйн байдал болон хувийн байдлыг минь харгалзан үзэж ялыг минь хөнгөрүүлж өгнө үү” гэжээ.

Улсын дээд шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 594 дүгээр тогтоол¹⁷²

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйл, мөн хуулийн 36.7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангах ёстой. Тодруулбал, шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт “... шүүгдэгч Ж.Ц нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, гэмт хэргийн улмаас хохирогчид учруулсан оногдох хохирлоо нөхөн төлсөн байх тул түүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.2 дугаар зүйлийн 1, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйлийн 2-т зааснаар 1 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэхээр шийдвэрлэж хорих ялыг хөнгөрүүлэв” гээд хуулийн баримтлах зүйл заалтыг орхигдуулсан байх бөгөөд үүнийг зөвхөн тогтоох хэсэгт дурдсан зөрчил гаргасан байгааг тэмдэглэж байна.

Дээрхээс харвал шүүх эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа үндэслэл, шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтын агуулга, хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал, эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний үндэслэлийг шүүхийн шийдвэрт тусгах ёстой байна. Мөн түүнчлэн хэргийн оролцогчид, өмгөөлөгчдийн санал, хууль зүйн дүгнэлт болон нотлох баримтад хийсэн дүгнэлт хангалтгүй буюу шүүх зарим нотлох баримтыг бусад нотлох баримтаас илүү үнэлэхдээ, яагаад тэр баримт илүү жинтэй гэж дүгнэсэн эсэхийг шүүхийн шийдвэрт дутуу тусгасан зэрэг нь шүүхийн шийдвэрт тавигдах хуулийн шаардлагыг

172 УДШ-ийн 2020 оны 10 сарын 21-ний өдрийн 594 тогтоол, https://shuukh.mn/single_case/2635?start_date=&end_date=&id=3&court_cat=2&bb=1

хангаагүй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчсөн болохыг дурдсан байна.

Монгол Улсад шүүхийн шийдвэрийн бүтэц, шийдвэрт тавигдах шаардлагыг ЭХХШтХ болон Шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлалд нарийвчлан тусгасан ч эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрүүд нь хуульд заасан шүүхийн шийдвэрийн бүтэц, хэлбэрийн шаардлагыг хангаагүй, шийдвэр тодорхой, ойлгомжтой бичигдсэн байх шаардлагыг хангаагүй шийдвэрүүд гарч байгаа нь ажиглагдлаа.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Эх газрын эрх зүйн бүлд хамаарах улсуудыг судлан үзвэл шүүхийн шийдвэрийн үндэслэлийг эхлээд зөвхөн шүүх байгууллага дотроо гаргадаг, харин хэргийн оролцогч, олон нийтэд нууц хэвээр үлддэг байжээ. Гэвч шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, шүүх хэргийг дур зоргоор шийдвэрлээгүй гэдгийг батлан харуулах зорилгоор шүүх шийдвэрийн үндэслэлийг бичгээр гаргах болсон бөгөөд шийдвэрийн үндэслэлийг бичгээр гаргах үүргийг улсууд Үндсэн хууль болон процессын эрх зүйн хэм хэмжээнд тусгайлан хуульчилдаг болсон байна. Ингэснээр шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэх эрх хэрэгжих, шударгаар шүүлгэх эрхийг баталгаатай эдлүүлэх боломж бүрджээ.

Шүүхийн шийдвэр нь шүүхээс гаргаж буй мэргэжлийн бичвэр бөгөөд уг бичвэрийг шүүгдэгч, иргэд, олон нийт, дээд шатны шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэсэн хэд хэдэн этгээдэд хандаж гаргадаг байна. Шүүхийн шийдвэрийг хуульч мэргэжил эзэмшсэн болон эзэмшээгүй хэд хэдэн этгээдэд хандаж гаргах нь ойлголтын зөрүү үүсгэх боломжтой бөгөөд үүнийг даван туулахын тулд шүүх шийдвэрээ тодорхой бүтцэд оруулан, тухайн бүтцэд хамаарах хэсгүүд нь хэнд чиглэж байгаа, ямар чиг үүрэг гүйцэтгэж байгаагаас хамааран ялгаатай хэв маягаар бичигддэг байна.

Эх газрын эрх зүйн бүлд хамаарах улсуудын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын бүтцийг судлан үзвэл дараах онцлог шинж байна.

Бичгээр гаргах шүүхийн шийдвэрийн бүтцийг Монгол Улс, ОХУ-д тусгайлан хуульчилсан байхад Герман Улс, Япон Улс, БНСУ, БНФУ-д шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсгийг тусгайлан хуульчилжээ. БНСУ, ОХУ болон Монгол Улсад шүүхийн шийдвэрийн бүтцийн агуулгыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд тусгасан байхаас гадна эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр боловсруулах нарийвчилсан журмыг дээд шатны шүүхээс боловсруулан гаргасан байна. Үүний үр дүнд шүүхийн шийдвэр цэгцтэй, нэг ижил бүтцээр гарах нөхцөл бүрджээ.

Дээрх улсуудад Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц нь удиртгал, тодорхойлох, тогтоох гэсэн хэсгүүдтэй байх бөгөөд эдгээр хэсгүүдийн байршил ялгаатай байна. Тухайлбал, Герман Улс, Япон Улс, БНСУ-д удиртгал хэсэг, тогтоох хэсэг, үндэслэх хэсэг гэсэн бүтэцтэй байхад БНФУ, ОХУ болон Монгол Улсад удиртгал хэсэг, үндэслэх хэсэг (тодорхойлох), тогтоох хэсэг гэсэн дарааллаар бичигддэг. Онолын үүднээс судлан үзвэл шүүхийн шийдвэрийн дээрх хэсгүүд нь ямар дараалалд бичигдсэн байхаас илүүтэй тухайн хэсгийг хэнд зориулан бичиж байгаад анхаарал хандуулдаг байна. Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг хэргийн оролцогчдод зориулан тэдэнд шүүхээс гаргаж буй шүүхийн шийдвэрийг танилцуулах чиг үүргийн хүрээнд иргэдэд ойлгомжтой, тодорхой бичихийг, харин шийдвэрийн үндэслэх хэсэг нь зөвхөн хэргийн оролцогчдод бус давж заалдах шатны шүүхэд мөн хандсан байдаг учраас мэргэжлийн үг хэллэг, объектив байдлаар бичсэн байхыг шаарддаг байна.

Эх газрын эрх зүйн бүлд хамаарах улсуудад шүүхийн шийдвэрийн удиртгал, тодорхойлох, тогтоох хэсэгт тусгах мэдээлэл нь агуулгын хувьд төстэй байна.

Удиртгал хэсэгт шүүхийн нэр, шийдвэрийн дугаар, шүүгдэгчийн хувийн мэдээлэл, түүний холбогдсон хэргийн талаар болон шүүх хуралдаанд оролцсон хэргийн оролцогчдын талаарх мэдээллийг тусгадаг. Удиртгал хэсэгт шүүгдэгчийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй бичих нь нэг талаас уг мэдээллийг өөр баримт бичиг ашиглахгүйгээр харах, хавтаст хэрэг устсан тохиолдолд шүүгдэгчийн хувийн мэдээллийг шийдвэрээс олж авах боломжтой байдаг, нөгөө талаас ижил нэртэй өөр хүнийг гэмт хэрэгт хилсээр шийтгэхээс сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн шаардлагыг хангах зэрэг ач холбогдолтой байна. Монгол Улсын хувьд шийдвэрийн удиртгал хэсэгт шүүгдэгч эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх мэдээллийг тусгадаг бол Герман Улс болон Япон Улсад уг мэдээллийг үндэслэх хэсэгт дурдаж байгаагаараа ялгаатай байна.

Тогтоох хэсэг нь иргэдэд шүүхийн шийдвэрийг мэдээлэх зорилготой байдаг бөгөөд тодорхой, ойлгомжтой бичигдсэн байхыг шаарддаг. Япон Улсын шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт хуулийн зүйл, заалтыг дурдахгүйгээр шүүгдэгчид оногдуулсан ял шийтгэлийг бичдэгээрээ онцлог байна. Тогтоох хэсгийг шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох үед хэргийн оролцогчдод танилцуулдаг учраас бичгээр гаргахад уншиж сонсгосон агуулгаас зөрүүтэй гаргахыг хориглодог. Мөн уг хэсэгт шүүдэгчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай талаар, мөн түүнд оногдуулсан эрүүгийн хариуцлагын талаар, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал, цагдан хоригдсон хугацаа, эрүүгийн ялаас чөлөөлөх, шийтгэх тогтоолыг хойшлуулах, шүүхэд гаргасан иргэний нэхэмжлэлийг хэрхэн шийдвэрлэсэн зэрэг мэдээллийг тусгадаг байна.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгийг тодорхой, ойлгомжтой байлгах үүднээс дотор нь дэд хэсгүүдэд хуваадаг. Тухайлбал, Герман Улс, Япон Улс болон БНСУ-д үйл баримтыг тогтоох, нотлох баримт үнэлэх, эрх зүйн дүгнэлт, ял оногдуулах үндэслэл зэрэг дэд хэсгүүдэд хуваан бичдэг. Харин Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэрийн

тодорхойлох хэсэг гэм буруутайд тооцох хэсэг болон шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн 2 хэсгээс бүрддэг байна.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт нотлох баримтад тулгуурлан тогтоосон хэргийн үйл баримт, түүнд хамаарах эрх зүйн хэм хэмжээ, түүнийг тайлбарласан байдал, талуудын дэвшүүлсэн асуудалд хариулсан буюу өгсөн дүгнэлтийг бичдэг. Нотлох баримтыг шүүхийн шийдвэрт тусгахдаа шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судалсан нотлох баримтыг дурдаад өнгөрөх бус, харин уг нотлох баримтад тулгуурлан шүүгч ямар дүгнэлтэд хүрсэн талаар дэлгэрэнгүй тайлбарладаг байна. Мөн нотлох баримтыг үндэслэл хэсэгт тусгахдаа яллах дүгнэлтээс шууд хуулбарлан бичихийг хориглодог. Япон Улс болон БНСУ-д хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтуудыг жагсаалтын хэлбэрээр дурддаг байна. БНФУ-д эрүүгийн ял шийтгэл оногдуулах үндэслэлийг заавал бичих шаардлагыг хуульчилсан тогтоожээ.

БНСУ-д шийдвэрийн бүтцийг боловсруулан хэрэглэж хэвшсэн нөхцөлд шүүхийн шийдвэр бичих процессыг хялбарчлах зорилгоор БНСУ-д “шүүхийн шийдвэр боловсруулах систем”-ийг ашигладаг байна. Дээрх улсуудад шүүхийн шийдвэр нь хуульч бус хүмүүст тодорхой, ойлгомжтой байлгах үүднээс хууль зүйн латин нэр томъёог хэрэглэхийг хориглоогүй ч хэрэглэх шаардлагатай гэж үзвэл уг нэр томъёоны тайлбарыг дурдахыг зөвлөдөг байна.

ХОЁР. ЖИШГИЙН ЭРХ ЗҮЙН БҮЛИЙН УЛСУУД

1. ЖИШГИЙН ЭРХ ЗҮЙН БҮЛ ДЭХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН БҮТЦИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, ОНЦЛОГ

Жишгийн эрх зүйн бүл нь дундад зууны үед шүүхийн шийдвэрүүд дээр үндэслэн бий болсон бөгөөд шүүхийн шийдвэр нь хууль тогтоомжийг тайлбарлаж, эрх зүйн зарчмуудыг тогтоодог.¹⁷³ Тус эрх зүйн бүлд шүүх шийдвэр гаргахдаа **stare decisis**¹⁷⁴ зарчмыг баримталдаг онцлогтой. Stare decisis зарчмын дагуу шүүх хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ өмнө нь төсөөтэй хэргийг шийдвэрлэсэн шийдвэрт буюу прецедент (precedent)¹⁷⁵-д үндэслэдэг. **Прецедентийг ашиглан гэмт хэргийн бүрэлдэхүүн хангагдсан эсэх, нотлох баримтыг үнэлэх, гэм буруугийн талаар дүгнэлт хийх, ялын төрөл, хэмжээг оногдуулах зэрэг асуудлыг шийдвэрлэдэг байна.**

Иймд жишгийн эрх зүйн бүлд шүүхийн шийдвэр нь эрүүгийн эрх зүйн эх сурвалж болж хууль тогтоох байгууллагаас баталсан хууль, гүйцэтгэх эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн хэм хэмжээний акттай ижил түвшинд хүлээн зөвшөөрөгддөг тул онцгой ач холбогдолтой байдаг.

Жишгийн эрх зүйн бүл дэх шүүхийн шийдвэрийн бүтцийн үүсэл, хөгжил

Жишгийн эрх зүйн бүл дэх **шүүхийн бичмэл шийдвэр нь анх Англи Улсад үүссэн бөгөөд үүнээс өмнө шүүгч шийдвэрийг амаар уншиж, танилцуулдаг байсан.** Шүүхийн шийдвэрийг амаар танилцуулах нь жишгийн эрх зүй цааш хөгжих, төсөөтэй хэргийг шийдвэрлэсэн шийдвэрийн үндэслэлийг дараагийн шүүхүүд ашиглах боломжгүйд хүргэж, хууль хэрэглээний нэгдмэл бус байдлыг бий болгож байсан учраас шүүхийн шийдвэрийг бичгээр боловсруулах зайлшгүй шаардлага үүссэн. Улмаар XIII зууны үеэс эхлэн гуравдагч

173 “The Evolution of Common Law: A Historical Perspective on Legal Development” Code & Justice Editorial, April 12, 2024, https://codeandjustice.com/evolution-of-common-law/?utm_ (last visited Sep.09, 2025).

174 “Stare decisis” гэдэг нь латин хэлний “stare decisis et non quia movere” гэсэн хэлц үгийн товчилсон хэлбэр бөгөөд “шийдэгдсэн зүйл дээр тогтож, тайван байдлыг бүү эвд” гэсэн утгатай. Amy Barret, “Stare Decisis and Due Process”, University of Colorado Law Review, 74 (2003),1016.

175 “...Шүүхийн шийдвэр нь тухайн хэрэгтэй төсөөтэй хэргийг шийдвэрлэх ажиллагаанд иш үндэс болсноор прецедентийн хүчин чадлаа олдог...” Болдбаатарын Гүнбилэг, Жишгийн эрх зүй, (Улаанбаатар: Соёмбо, хэвлэлийн газар, 2008), 20 дахь тал.

этгээдүүд шүүх хуралдааныг тэмдэглэх, эмхэтгэж нийтлэх, шүүгч шийдвэрээ бичмэл хэлбэрээр боловсруулах зэргээр шүүхийн шийдвэр нь тодорхой бүтэцтэй болж өнөөгийн хэлбэрээ олжээ. Иймд тус эрх зүйн бүл дэх шүүхийн шийдвэрийн бүтцийн үүсэл, хөгжлийг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

i. Шүүх хуралдааны жилийн эмхэтгэлүүд буюу Year Books (XIII-XVI зуун)

Англи Улсын хаан I Эдвардийн үед буюу 1290-1335 оны хооронд шүүхийн материалуудыг жил бүрийн тусгай номд цуглуулж эхэлсэн нь Year Books юм. Энэ үед Year Books нь Англи-Норманд хэл дээр бичигдсэн,¹⁷⁶ албан бус, формаль бус шинжтэй байжээ. Энэхүү эмхэтгэл нь нэрээ нууцалсан бичээчид болон хуулийн оюутнуудын шүүх хуралдааны явц, маргааны тэмдэглэлүүдийг агуулдаг бөгөөд эрх зүйн зарчмуудыг маш бага тусгасан байдаг.¹⁷⁷

ii. Шүүхийн шийдвэрийн нэр бүхий эмхэтгэлүүд буюу Nominate Reports (XVI зуун)

Nominate Reports нь 1220-1867 оны хооронд хувийн хэвлэлийн газарт хэвлэгдэн гарсан, шүүхийн шийдвэрийн албан бус эмхэтгэлийн цуврал юм. Өмгөөлөгч, дадлагажигч оюутнууд өөрсдийн нэрээр шүүхийн шийдвэрийн эмхэтгэлүүдийг гаргаж эхэлсэн¹⁷⁸ бөгөөд эдгээр эмхэтгэлийг ихэвчлэн хэвлэсэн эсвэл бичсэн хүний нэрээр нэрлэж байжээ.¹⁷⁹ Эдгээрийн олонх нь өнөөдөр ч иш татагдан ашиглагддаг хэдий ч хамрах хүрээ, үнэн зөв, найдвартай байдал нь харилцан адилгүй ялгаатай байдаг.

iii. Шүүхийн Шийдвэр Эмхэтгэлийн Зөвлөл буюу Law Reporting Council (XIX зууны дунд үе)

¹⁷⁶ “Law reporting: a history”, Paul Magrath, May 13 2024, <https://www.counselmagazine.co.uk/articles/law-reporting-a-history?utm,> (last visited Sep.09, 2025).

¹⁷⁷ “Year Books”, Justia Legal Reference Network, <https://law.jrank.org/pages/11428/Year-Books.html?utm,> (last visited Sep.13, 2025).

¹⁷⁸ “History”, Incorporated Council of Law Reporting for England and Wales (ICLR), <https://www.iclr.co.uk/history/>, (last visited Sep.09, 2025).

¹⁷⁹ “Nominate Reports”, New Zealand Law Foundation, <http://law.foundation.org.nz/style-guide2018/chapter-pt.8.4.2.html,> (last visited Sep.12, 2025).

Англи Улсад Шүүхийн Шийдвэр Эмхэтгэлийн Зөвлөл (Law Reporting Council)-анх 1865 онд байгуулагдсан. Энэ үеэс эхлэн шийдвэрүүдийг бичиж тэмдэглэх, нийтлэх тогтолцоо боловсронгуй болж эхэлсэн байна.¹⁸⁰ Шүүхийн Шийдвэр Эмхэтгэлийн Зөвлөл байгуулах саналыг гаргасан W.T.S. Daniel¹⁸¹ нь өөрийн саналын товч танилцуулгад “...шүүхийн шийдвэрийн бичвэр нь алдаагүй, чухал болон ач холбогдол бүхий мэдээллийг агуулсан, эдгээр зорилгод нийцсэн байдлаар товч байвал зохино. Тодруулбал, хэргийн оролцогч, үйл баримт, өмгөөлөгчдийн маргаж буй гол асуудал, шүүхийн шийдвэр гарах болсон үндэслэлийг тусгах ёстой...” гэж дурдсан байна. Эдгээр зааварчилгааг өнөөг хүртэл дагаж мөрдөж байгаа бөгөөд энэ нь шүүхийн шийдвэр тодорхой бүтэцтэй, бүрэн, ойлгомжтой байх шаардлагын үндсийг тавьсан.¹⁸² Улмаар дээд шатны шүүхийн шийдвэрийн үндэслэлийг бүрэн тодорхой бичсэн, баталгаатай шүүхийн шийдвэрийн эмхэтгэл нь жишгийн эрх зүйн тасралтгүй, системтэй хөгжлийг хангах хэрэгсэл болсон.¹⁸³

Жишгийн эрх зүйн бүлд шүүхийн шийдвэрийг бичмэл хэлбэрээр боловсруулах үндсэн 3 шалтгаан байдаг. Үүнд: ¹⁸⁴

- 1) Хэргийн оролцогч талуудад шүүхийн шийдвэрийн үндэслэлийг танилцуулах;
- 2) Дээд шатны шүүхээс шийдвэрийг хүчингүй болгох эсвэл хэвээр үлдээх эсэхийг шийдвэрлэхэд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дүгнэлт хийдэг тул бичгээр боловсруулагдах шаардлагатай байдаг;
- 3) Дээд шатны шүүхээс маргаантай эрх зүйн асуудлыг

180 The History of The Incorporated Council of Law Reporting for England & Wales”, ICLR, [http: https://web.archive.org/web/20100116090616/http://www.lawreports.co.uk/AboutICLR/history.htm#H](https://web.archive.org/web/20100116090616/http://www.lawreports.co.uk/AboutICLR/history.htm#H), (last visited Sep.09, 2025).

181 William Thomas Shave Daniel (1806-1891) нь Англи ба Уэльсийн Шүүхийн Шийдвэрийн Эмхэтгэлийн зөвлөлийн дэд дарга бөгөөд шүүхийн шийдвэрийн эмхэтгэлийн тогтолцоог шинэчлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн хуульч юм. “William Thomas Shave Daniel”, Wikipedia, August 31, 2023, https://en.wikipedia.org/wiki/William_Thomas_Shave_Daniel?utm, (last visited Sep.13, 2025).

182 “The History of The Incorporated Council of Law Reporting for England & Wales”, ICLR, [http: https://web.archive.org/web/20100116090616/http://www.lawreports.co.uk/AboutICLR/history.htm#H](https://web.archive.org/web/20100116090616/http://www.lawreports.co.uk/AboutICLR/history.htm#H), (last visited Sep.09, 2025). [http: https://web.archive.org/web/20100116090616/http://www.lawreports.co.uk/AboutICLR/history.htm#H](https://web.archive.org/web/20100116090616/http://www.lawreports.co.uk/AboutICLR/history.htm#H)

183 Lord Hudge, Justice of The Supreme Court of the United Kingdom, “The scope of judicial law-making in common law tradition Max Planck Institute of Comparative and International Private Law”, (Oct 2019), 5-6.

184 “What’s the point of a judgment?”, May 3, 2024, <https://transparencyproject.org.uk/whats-the-point-of-a-judgment/>, (last visited Sep.11, 2025).

шийдвэрлэсэн эсвэл доод шатны шүүхүүдэд эшлэл болгон ашиглаж болох чухал зааварчилгааг агуулсан шийдвэрийг нийтэд мэдээлэх.¹⁸⁵

Дээрх шалтгаанаар шүүхийн шийдвэр нь бичмэл хэлбэрээр боловсруулагддаг бөгөөд бичмэл хэлбэрээр боловсруулах нь дараах зорилго болон ач холбогдолтой. Үүнд:

1. Эрх зүйн эх сурвалж бий болгох

Эх газрын эрх зүйн бүлийн шүүхийн шийдвэр нь тодорхой хэргийг шийдвэрлэх зорилготойгоор бичигддэг бөгөөд уг шийдвэр нь ирээдүйд шүүх хэрэглэх жишиг болох зорилго агуулдаггүй.¹⁸⁶ Харин жишгийн эрх зүйн бүлд шүүхийн шийдвэр нь жишиг болон ашиглагддаг тул шийдвэрийн үндэслэлийг бичгээр боловсруулан хадгалж эх сурвалжийг бүрдүүлдэг.

2. Ил тод байдал ба хариуцлага

Бичгээр боловсруулсан шийдвэр нь талуудад шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй танилцах, шүүх хэргийг шударгаар шийдвэрлэсэн гэдгийг харуулах зорилготой.

3. Баримт бичиг

Шүүхийн шийдвэр нь давж заалдах шатны процесст чухал үүрэгтэй. Анхан шатны шүүхийн бичмэл шийдвэр нь хууль хэрэглээ, үйл баримтыг хэрхэн дүгнэсэн талаар болон шийдвэр гаргах болсон эрх зүйн үндэслэл зэргийг агуулдаг. Иймд дээд шатны шүүх нь давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэхдээ доод шатны шүүхийн шийдвэрт дүгнэлт хийдэг тул шийдвэрийг бичмэл хэлбэрээр боловсруулдаг байна.¹⁸⁷

Жишгийн эрх зүйн бүлд хамаарах улс орнууд (жишээлбэл, Шинэ Зеланд Улс, Австрали Улс, Канад Улс, АНУ, ИБУИНХУ гэх мэт)-д шүүхийн шийдвэрийн бүтэц, агуулгыг хууль, тогтоомжоор тусгайлан

185 Ibid.

186 Thomas Risse, "Common Law and its Basic Principles", International Scholars Journals 10, no1 (2022).

187 Gerald Lebovits, "Judgment Writing in Kenya and the Common-Law World", Kenya Law Review, no2 (Oct 2009), 220.

журамлан зохицуулдаггүй бөгөөд энэ нь дараах шалтгаантай байж болно. Үүнд:

- Жишгийн эрх зүйн бүлд шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжоос гадна прецедентийг хэрэглэдэг. Иймд **шүүхийн шийдвэрийн бүтцийг хатуу тогтоох нь шийдвэрийн үндэслэл, дүгнэлт гаргах уялдааг хязгаарлах эрсдэлтэй;**
- Бичгээр гаргасан шүүхийн шийдвэрүүд нь хэрэг, маргааныг шийдвэрлэх болон жишиг тогтоох үүргийг биелүүлдэг. Иймд тус эрх зүйн бүлд шүүхийн шийдвэр нь нэг өгүүлбэртэй, хэвлэгдээгүй, товч шийдвэрээс эхлэн албан ёсны бүтэцтэй, олон ишлэлтэй, дэлгэрэнгүй тайлбартай янз бүр байж болдог.¹⁸⁸

Жишгийн эрх зүйн бүлд хамаарах зарим улсын Дээд шүүх, Холбооны шүүх, сургалт судалгааны байгууллагаас шүүхийн шийдвэрийн бүтэц, аргачлалын тухай зөвлөмж, гарын авлага гаргадаг. Гэхдээ эдгээр нь заавал дагаж мөрдөх шинжгүй байна. Тухайлбал, Австрали Улсын Викториа мужийн Шүүхийн Коллеж (Judicial College of Victoria)-оос гаргасан шүүхийн шийдвэр бичих зөвлөмжид “...шийдвэр бичих нь заавал мөрдөх хатуу дүрэм тогтоож болдог сэдэв биш юм. Зөвлөмжид заагдсан зүйлс нь шийдвэрт тохирохгүй үед тухайн хэргийн онцлогт хамгийн тохиромжтой аргаар үндэслэлийг боловсруулах нь бүрэн зөвшөөрөгдөнө...” хэмээн тодорхой тусгажээ.¹⁸⁹

Жишгийн эрх зүйн бүлд хамаарах улсуудын шүүхийн шийдвэр нь нийтлэг байдлаар 5 үндсэн хэсгээс бүрддэг¹⁹⁰ бөгөөд зарим тохиолдолд бүтэц нь шүүгчийн сонголтоос хамааран ялгаатай байж болдог.

188 The Federal Judicial Center of USA, Judicial Writing Manual (A Pocket Guide for Judges), 2nd ed. (Federal Judicial Center, 2020), 3.

189 Judicial College of Victoria, “Judgment writing guide”, 2024, 1.

190 “Precedent and Analogy in Legal Reasoning”, Stanford Encyclopedia of Philosophy, 2006, [http: https://plato.stanford.edu/entries/legal-reas-prec/](https://plato.stanford.edu/entries/legal-reas-prec/), (last visited Sep.19, 2025).

1. Хэргийн үйл баримтыг дэлгэрэнгүй тайлбарласан хэсэг;
2. Эрх зүйн асуудлыг тодорхойлох (шүүхээс шийдвэрлэх гэж буй маргаантай хууль зүйн асуудал);
3. Тухайн асуудлыг зохистойгоор шийдвэрлэх үндэслэл;
4. Эрх зүйн асуудлыг шийдвэрлэх;
5. Хэргийн эцсийн шийдвэр буюу үр дүн.

Дээрх нийтлэг бүтцийн дагуу шүүхийн шийдвэрийг боловсруулахаас гадна шийдвэрийг ойлгомжтой, тодорхой болгох үүднээс зарим тохиолдолд гарчиг, дэд гарчгийг ашигладаг.¹⁹¹ Тухайлбал, Канад Улсын Ньюфаундленд ба Лабрадор мужийн анхан шатны шүүхийн эрүүгийн хэргийн шийдвэр нь дараах дэд гарчгийн хүрээнд бичигдсэн байна.¹⁹²

- 1) Удиртгал хэсэг: Шүүгдэгчийн холбогдсон гэмт хэрэг, шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн эсэх асуудлыг тусгана;
- 2) Үйл баримт: Хэргийн үйл баримт, хэрэгт авагдсан нотлох баримтын нэрийг тоочих байдлаар жагсаан бичнэ;
- 3) Эрх зүйн асуудал: Талуудын маргаагүй үйл баримтыг дүгнэн, тухайн хэрэгт хөндөгдөж буй эрх зүйн гол асуудлыг тодорхойлно;
- 4) Хэрэглэгдэх хуулийн заалт: Хэргийг шийдвэрлэхэд ашиглагдах бүх хууль, тогтоомж, оногдуулах ялын төрөл, хэмжээ, ял хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тодорхой тусгана;
- 5) Шүүхэд ирүүлсэн эрх зүйн эх сурвалжууд: Прокурорын ирүүлсэн төсөөтэй хэргийг шийдвэрлэсэн шүүхийн прецедентүүдийн үндэслэл, шийдвэрүүдийг товч дурдана;
- 6) Яллах талын байр суурь: Прокурорын гаргасан үндэслэл, тайлбарыг товч дурдана.
- 7) Өмгөөлөх талын байр суурь: Шүүгдэгч, шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан үндэслэлийг товч дурдана;

191 Andrew Godwin, "Judgment writing", China Law Journal, 8 May 2024.

192 R. v M.S., 2015 CanLII 59234 (NL PC), <https://canlii.ca/t/gl8h2>.

- 8) Дүн шинжилгээ ба дүгнэлт: Шүүхийн шийдвэрийн энэхүү хэсэгт хэргийг шийдвэрлэхэд ашиглагдах хууль, тогтоомж эрх зүйн асуудалд дүн шинжилгээ хийх, төсөөтэй хэргийг шийдвэрлэсэн прецедентүүдийг судлах; тухайн хэргийн үйл баримт нь шийдвэрийн үндэслэл болсон прецедентийн үйл баримттай төсөөтэй эсвэл ялгаатай эсэхэд харьцуулалт, дүгнэлт хийх; нотлох баримтыг хэрхэн үнэлсэн, энэ нь шийдвэрийн үндэслэл болсон эсэх; эрх зүйн хэм хэмжээ, зарчмуудыг хэрхэн хэрэглэсэн талаар тайлбарлаж эцсийн шийдвэр (гэм буруутай эсэх, оногдуулах ялын төрөл, хэмжээ)-ийг гаргадаг.

Жишгийн эрх зүйн бүлийн улс орнуудад эрх зүйн дүгнэлт хийхэд логикийн аналог¹⁹³ болон дедуктив оюун дүгнэлт¹⁹⁴-ийн аргийг ашигладаг.¹⁹⁵ Эрх зүйн дедуктив оюун дүгнэлт нь эрх зүйн ерөнхий суурь зарчмуудаас тусгай дүрмийг гаргах аргачлалаар явагддаг.¹⁹⁶ Жишээ нь, Хүнийг алах нь гэмт хэрэг. “Д” нь хүнийг алсан. “Д” нь гэмт хэрэг үйлдсэн.

Эх газрын эрх зүйн бүлийн улс орнуудын шүүхийн шийдвэр нь гол төлөв хуульчид буюу мэргэжлийн уншигчдад зориулсан хэлбэрээр бичигддэг бол жишгийн эрх зүйн бүлийн улс орнуудын шийдвэр нь энгийн үг хэллэгээр, өгүүлэмжийн хэв маягаар боловсруулагддаг бөгөөд хууль зүйн салбарын бус, соёл, хэлний хувьд ялгаатай хүмүүст ойлгомжтой хүртээмжтэй хэлбэрээр бичих ёстой гэсэн зарчим хүлээн зөвшөөрөгддөг.¹⁹⁷

193 “Аналоги аргийг төсөөтэй хэргийг шийдвэрлэсэн прецедентийг одоогийн шийдвэрлэж буй хэргийн үйл баримттай харьцуулж шийдвэр гаргахад ашигладаг. Жишээлбэл, өмнө нь ийм нөхцөлд шүүх ингэж шийдвэрлэсэн бол одоо ийм нөхцөлд ижил шийдвэр гаргана.” “Precedent and Analogy in legal Reasoning”, Stanford Encyclopedia of Philosophy Archive, June 20, 2006, <https://plato.stanford.edu/archives/fall2024/entries/legal-reas-prec/>, (last visited Sep.19, 2025).

194 “Дедуктив оюун дүгнэлт нь “ерөнхийгөөс тусгай руу шилждэг” бөгөөд хэрэв үндэслэлүүд нь үнэн бол заавал үнэн дүгнэлтэд хүргэдэг гэсэн санааг илэрхийлдэг.” William Thomas Worster, “The Inductive and Deductive Method in Customary International Law Analysis: Traditional and Modern Approaches”, Georgetown Journal of International and Modern Approaches, 45, no2, (2014), 455.

195 Ихэнх судлаачид жишгийн эрх зүйн бүлийн улс орнууд логикийн дедуктив оюун дүгнэлтийн аргийг ашиглах бус индуктив оюун дүгнэлтийн аргийг ашигладаг гэж үздэг бол зарим судлаачид тус хоёр оюун дүгнэлтийн аргийн аль алныг нь ашигладаг гэж үздэг. Иймд тус эрх зүйн бүлд шүүгч эрх зүйн дүгнэлт хийх логикийн ямар арга хэрэглэдэг талаарх судлаачдын тайлбар, хандлага харилцан адилгүй байна.

196 Ibid.

197 Andrew Godwin, “Judgment writing”, China Law Journal, 8 May 2024.

Үүнээс гадна жишгийн эрх зүйд **хууль бол шүүгчийн гаргасан шийдвэр гэж үздэг тул шүүгч шийдвэртээ өөрийн хувийн үзэл бодлоо тусгадаг.**¹⁹⁸ Иймд тус эрх зүйн бүлд хамаарах улс орнуудын шүүхийн шийдвэрт шүүгч дангаар хэргийг шийдвэрлэж байгаа тохиолдолд шүүгчийн талаас **“БИ”**, бүрэлдэхүүнтэйгээр хэргийг шийдвэрлэж байгаа тохиолдолд **“БИД”** гэсэн биеийн төлөөний үгийг түгээмэл хэрэглэдэг байна. Жишээ нь Канад Улсын Дээд шүүхийн шийдвэрт “...анхан шатны шүүгч ДНХ-ийн нотолгоо дангаараа гэм бурууг тогтооход хангалтгүй болохыг хүлээн зөвшөөрсөн. Би энэ дүгнэлттэй санал нэг байна...”¹⁹⁹

Жишгийн эрх зүйн бүлд шүүгч шийдвэрээ хэнд зориулж боловсруулдаг талаар тодорхойлохын өмнө эрх зүйн системд шүүхийн үүргийг тодорхойлох нь зүйтэй. Жишгийн эрх зүйн бүлийн улс орны шүүх нь

- Хэрэг, маргааныг шийдвэрлэх (dispute setting function),
- Хууль тогтоох (law making)²⁰⁰ гэсэн хоёр үндсэн үүргийг гүйцэтгэдэг.²⁰¹

Хэрэг, маргааныг шийдвэрлэх шүүхийн үүрэгтэй холбоотой шийдвэрийн тохиолдолд (ихэвчлэн анхан шатны шүүх) шүүхийн шийдвэр нь хэргийн оролцогч, талууд, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн төрийн байгууллага эсвэл гуравдагч этгээдүүдэд (хөрөнгө царцаах шийдвэрийн тохиолдолд банк) хамааралтай байдаг.²⁰² Харин шүүхийн хууль тогтоох үүрэгтэй холбоотой шийдвэрийн тохиолдолд (ихэвчлэн дээд шатны шүүх) шийдвэрийг талууд, бусад шүүхүүд, мэргэжлийн хуульч, өмгөөлөгч,

198 Douglas E. Edlin, Common Law Judging: Subjectivity, Impartiality, and the Making of Law, (University of Michigan Press, 2016), 14.

199 R. v. Metzger, 2023 SCC 5, <http://decisions.scc-csc.ca/scc-csc/scc-csc/en/item/19677/index.do?q=2023>, (last visited Sep.12, 2025).

200 “...Жишгийн эрх зүйн бүлд шүүх зөвхөн хууль тайлбарлах, хэрэглэх бус хууль тогтоодог. Хууль тогтоомж нь нийгмийн бүхий л харилцааг нарийвчлан зохицуулдаггүй тул шүүх нь шийдвэрээрээ дамжуулан, хууль, тогтоомжоор зохицуулагдаагүй эсвэл тодорхойгүй асуудлыг эрх зүйн зарчим, жишигт үндэслэн шийдвэрлэх замаар хуулийг бий болгодог. Жишээлбэл, жишгийн эрх зүйн гэрээний эрх зүй, үндэслэлгүй хөрөнгөжих, өмчийн эрх зүй, гэм хорын эрх зүй, захиргааны эрх зүй зэрэг нь шүүхийн шийдвэрүүдээс үүсэлтэй...” Robert Sharpe, Good Judgment: Judicial Decisions, 2nd ed. (University of Toronto Press, 2020) 77-78.

201 Debbie Mortimer, “Some Thoughts on Writing Judgments in and for, Contemporary Australia”, Melbourne University Law Review Annual Lecture, (March 2018), 285.

202 Ibid, 284.

мөн хэргийн оролцогчид, хууль зүйн салбарын эрдэмтэн, судлаачид уншиж, судалдаг. Өөрөөр хэлбэл тухайн хэргийг шийдвэрлэж буй шүүхийн шийдвэр нь эрх зүйн зарчим, жишиг тогтоох гэж буй тохиолдолд шүүх шийдвэрийн үндэслэлийг дэлгэрэнгүй тусгаж доод шатны шүүх, хэргийн оролцогч, хууль зүйн салбарын мэргэжлийн уншигчдад зориулан боловсруулдаг. Харин шүүх шийдвэрийг эрх зүйн зарчим, жишиг тогтоох бус аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэх зорилгоор боловсруулж байгаа тохиолдолд хэргийн оролцогч, гуравдагч этгээдүүдэд зориулан бичдэг.

Харин өргөн хүрээнд авч үзвэл шүүхийн шийдвэрийн гурван гол зорилтот бүлэг байдаг. Нэгдүгээрт, **шүүх шийдвэрээ хэргийн оролцогч талуудад зориулан гаргадаг** (юун түрүүнд шүүхийн шийдвэрийн үндэслэлийг талууд мэдэх эрхтэй). Хоёрдугаарт, дээд шатны шүүх доод шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар хянан хэлэлцдэг тул **анхан болон давж заалдах шатны шүүгч өөрийн шийдвэрийн үндэслэл, дүгнэлтийг дээд шатны шүүхэд зориулан тодорхой тайлбарлаж бичдэг.**²⁰³ Гуравдугаарт, **шүүхийн шийдвэр нь эрх зүйн салбарынхан төдийгүй бүх нийтэд зориулагдан бичигддэг.**²⁰⁴

Эрүүгийн хэргийн анхан шатны шийтгэх тогтоолын бүтэц, түүний агуулгыг дэлгэрүүлэн судлах зорилгоор жишгийн эрх зүйн бүлд хамаарах Англи болон АНУ-ын зохицуулалтыг тус тус судлав.

2. АНГЛИ УЛС

Англи Улсад эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг бичгээр гаргахад баримтлах бүтцийн талаар хуульд нарийвчлан тусгаагүй. Иймээс шүүгч шүүхийн шийдвэрийг бичихдээ тухайн хэргийн онцлогт тохирсон байдлаар бичих эрхтэй байдаг.²⁰⁵ Хуульд нарийвчлан тусгаагүй ч Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр нь

203 Robert Sharpe, *Good Judgment: Judicial Decisions*, 2nd ed. (University of Toronto Press, 2020) 137.

204 Ibid,

205 The National Archives, “Find Case Law, Understanding judgments and decisions”, <https://caselaw.nationalarchives.gov.uk,> 2025, (Сүүлд үзсэн: 2025.09.09).

дараах хэсгийг багтаасан байх нь нийтлэг байна.²⁰⁶ Үүнд:

Шийтгээ №7. Англи Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны
шүүхийн шийдвэрийн бүтэц

Шийтгэх тогтоолын бүтэц:

- 1) Товч танилцуулга ба товч мэдээлэл;
- 2) Баримт (факт)-ын тойм;
- 3) Эрх зүйн асуудал;
- 4) Талуудын байр суурь, дүгнэлт;
- 5) Дүгнэлт, шийдвэр (Verdict) ба үндэслэл;

1) Товч танилцуулга ба товч мэдээлэл

Шийдвэрийн эхэнд хэргийн талууд, дугаар, шүүх танхим, шүүгчийн нэр зэрэг хэргийн талаарх үндсэн мэдээллийг агуулсан «гарчиг» хэсэг байдаг.

2) Үйл баримт (факт)-ын тойм

Шүүгч тухайн гэмт хэргийн үйл баримтыг дурдан, хэргийн нөхцөл байдлыг үнэлсэн тайлбар өгдөг. Энэ хэсэгт яллах болон өмгөөлөх талаас шүүхэд гаргасан гол мэдүүлэг, нотлох баримтын хураангуйг тусгана. Журмын дагуу шүүхэд хэлэлцэгдсэн гол асуудлууд, талуудын маргаан, гаргасан нотлох баримтуудыг шүүгч эмх цэгцтэйгээр өгүүлдэг.

3) Эрх зүйн асуудал

Шүүгч хэрэгт хамаарах хууль тогтоомж, эрх зүйн нэр томьёо, stare decisis зарчим буюу төсөөтэй хэргийг урьд нь шийдвэрлэж байсан шүүхийн шийдвэрийг дурдаж, тухайн хэрэгт ямар хууль зүйн шалгуур, элементийг хангасан эсэхийг хэлэлцдэг.

4) Талуудын байр суурь, дүгнэлт

Шийдвэрийн явцад талуудын гаргасан гол аргументуудыг дурдан, шүүгч тэдгээрийг хэрхэн авч үзэж дүгнэснээ тайлбарладаг. Энэ хэсэгт яллагч болон өмгөөлөх талын байр суурь, тэдний үндэслэлүүдийг товч дурдана.

²⁰⁶ Ibid,

5) Дүгнэлт, шийдвэр (Verdict) ба үндэслэл

Шийдвэрийн төгсгөлд шүүгч хэргийн үр дүн, эцсийн шийдэл (яллах эсвэл цагаатгах, эсхүл оногдуулах ял зэргийг) гаргаж, яагаад ийм шийдвэрт хүрсэн үндэслэлээ тайлбарладаг. Англи Улсын практикт шүүгч эцсийн шийдвэрээ ямагт төгсгөл хэсэгт байршуулж, түүнд хүрэх болсон үндэслэл, нотолгооны үнэлгээгээ урьдчилан дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг.

Дээрх бүтэц нь хуульд заасан албан ёсны **“үлгэрчилсэн загвар” биш бөгөөд “шүүхийн шийдвэр бичих арга барил нь шүүгчийн мэдэлд байдаг” болохыг онцолжээ.**

Шүүхийн шийдвэр нь олон хуудастай эсвэл цөөн хуудастай гаргах эсэхэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй, тухайн хэргийн онцлогоос хамааран дэлгэрэнгүй эсвэл товч байдлаар гарах боломжтой. English v. Emery Reimbold & Strick (2002) хэмээх хэргийн шийдвэрт Англи Улсын Давж заалдах шатны шүүхээс **«шүүгчийн шийдвэр ямар байх талаар нэгдсэн загвар гаргах боломжгүй, урт байх албагүй, харин шийдвэрийн үндэслэл болсон чухал асуудлуудыг тодорхойлон тусгасан байх ёстой»** гэж тэмдэглэсэн байна.²⁰⁷ Өөрөөр хэлбэл, шүүхийн практикт анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрхэн бичих талаар нарийн журамласан зүйл байхгүй ч шүүгч тухайн хэргийн онцлогт тохируулан дээрх ерөнхий бүтэц, зарчмыг баримтлан өөрийн үгээр шийдвэрээ үндэслэлтэйгээр бичдэг.

Англи Улсын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн хэлбэр нь шүүх бүрэлдэхүүнээс хамааран өөр байдаг. Тодруулбал, тус улсад эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг магистратын шүүх (англ. Magistrates Court) байхаас гадна илүү ноцтой хэргийг Хааны шүүх (англ. Crown Court) анхан шатны журмаар шийдвэрлэдэг. Хааны шүүх нь Jury буюу тангарагтны шүүх бүрэлдэхүүнтэйгээр хэргийг шийдвэрлэх ба энгийн иргэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, шүүгдэгч гэм буруутай

207 Sarah Hopkinson, Kate Longson, “A Few Pieces Short of a Jigsaw: Appealing Inadequately Reasoned Judgments”, <https://ropewalk.co.uk>, 2021, (Сүүлд үзсэн: 2025.09.09).

эсэх тухай товч дүгнэлт гаргадаг. Уг дүгнэлтэд хүрсэн үндэслэлийн талаарх ямар нэгэн шийдвэрийг бичгээр гаргадаггүйгээрээ онцлог байна.

Тангарагтны шүүх шүүгдэгчийг гэм буруутай гэсэн шийдвэр гарсны дараа шүүгч ял оногдуулах ажиллагааг явуулж, ял оногдуулах болсон үндэслэлийн талаар амаар тайлбар өгдөг ба үүнийг “sentencing remarks” гэнэ.²⁰⁸ Харин шүүгч дангаар (District Judge эсвэл Crown Court-ийн шүүгч зөвхөн өөрөө) хэргийг шийдвэрлэсэн тохиолдолд шүүгч (эсвэл магистрат шүүгчид) шийтгэх тогтоолын үндэслэлийг шүүх хуралдааны танхимд амаар уншин танилцуулж, шаардлагатай үед бичгээр тэмдэглэдэг. Өнөөгийн практикт магистратын шүүгчид шүүхийн шийдвэрээ товчхон боловч ойлгомжтой байдлаар танилцуулж, гол үндэслэлээ хэлэх нь ердийн жишиг болсон. Тангарагтны шүүхийн хувьд шийдвэрт дэлгэрэнгүй үндэслэл гардаггүйн улмаас анхан шатны шүүх бичгээр хэлбэржүүлсэн шийдвэрийн бүтэц, тайлбар дутагдалтай байдаг талтай.

Шүүхийн шийдвэрт тавигдах нийтлэг шаардлага

Англи Улсын эрх зүйн тогтолцоонд шүүхийн шийдвэр бичгээр гаргахад тавигдах тодорхой шаардлагыг тусгайлан хуульчлаагүй ч шүүхийн шийдвэр нь:

- Ойлгомжтой, тодорхой байх;
- Хууль ёсны ба үндэслэл бүхий байх;
- Биелүүлэхэд эргэлзээ төрүүлэхгүй байх;
- Хэргийн оролцогч талуудад шүүхийн мэтгэлцээнд ялсан болон ялагдсан учир байдлыг ойлгохуйц байх гэсэн шаардлагыг хууль зүйн уламжлал болон шүүхийн практикт тавьсаар иржээ.

208 Alexander Chandler, “What’s the point of a judgment”, <https://transparencyproject.org.uk/whats-the-point-of-a-judgment/>, 2024, (Сүүлд үзсэн: 2025.09.09).

1. Шүүхийн шийдвэр ойлгомжтой тодорхой байх

Шүүхийн шийдвэрийн үндэслэл, учир шалтгааныг ойлгомжтой тайлбарлах нь шударга ёсны шаардлага юм. Англи Улсын Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн *Flannery v. Halifax Estate Agencies Ltd* (1999) хэргийн шийдвэрт шүүгч Хэнри Лорд **шүүхийн шийдвэрийг талууд, ялангуяа ялагдсан талд яагаад ийм үр дүнд хүрснийг нь ойлгогдохуйц байдлаар тайлбарлах нь шударга ёсны үндсэн зарчим болохыг онцлон тэмдэглэсэн байдаг.**²⁰⁹ Тэрээр “Шүүхийн шийдвэр учир шалтгаантай, үндэслэлтэй байх нь үндсэн эрхэд халдах зайлиггүй зүй ёсны ажиллагаа (*due process*)-ны нэг хэсэг юм. Ялагдсан талд шударга хандахын тулд яагаад ялагдсаныг нь ойлгуулах нь чухал... Үндэслэл бичих шаардлага нь шүүгчийн оюун санааг төвлөрүүлж, нотлох баримтад тулгуурласан, найдвартай шийдвэр гаргахад тустай” хэмээн дурджээ.²¹⁰ Өөрөөр хэлбэл, шийдвэр нь ялагдсан талын хувьд ямар алдаанаас болж эсвэл ямар нотлох баримт, хууль зүйн дүгнэлтээр ялагдсан болохыг ойлгож, улмаар давж заалдах эсэхээ шийдэх боломжийг олгодог байна. Лорд Хоффман мөн энэ талаар: “Шүүгчийн үндэслэл нь талууд яагаад ялж, ялагдсаныг ойлгуулах, мөн давж заалдах шатны шүүх тухайн шийдвэр үндэслэлтэй эсэхийг дүгнэхэд хангалттай мэдээлэл өгөхүйц байх ёстой” гэжээ.²¹¹ Тэгэхдээ бүх баримт, маргааныг нарийвчлан нэг бүрчлэн дурдах албагүй, харин шийдвэрт шийдвэрлэх гол асуудлууд болон тэдгээрийг хэрхэн шийдсэнийг тодорхой бичсэн байх нь хамгийн чухал гэж үздэг.²¹² Тухайлбал, хэргийн эцсийн үр дүн гэрчийн мэдүүлгээс хамаарсан бол “аль гэрчийн мэдүүлгийг үнэмшилтэйд тооцож, яагаад бусад гэрчийн мэдүүлгээс илүү итгэл үнэмшил төрүүлсэн талаар товч дурдсан байхад хангалттай гэж шүүх үзсэн байдаг.”²¹³ Ийм төрлийн тодорхой тайлбар нь шийдвэрийн

209 Alexander Chandler, “What’s the point of a judgment”, <https://transparencyproject.org.uk/whats-the-point-of-a-judgment/>, 2024, (Сүүлд үзсэн:2025.09.09).

210 Мөн тэнд.

211 Мөн тэнд.

212 Мөн тэнд.

213 Sarah Hopkinson, Kate Longson, “A Few Pieces Short of a Jigsaw: Appealing Inadequately Reasoned Judgments”, 2021, <https://ropewalk.co.uk/>, (Сүүлд үзсэн:2025.09.09).

ойлгомжтой байдлыг хангаж, уг шийдвэрийг хожим гомдлын үндсэн дээр хянахад чухал үндэслэл болдог.

2. Хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлага

Англи Улсын шүүхийн шийдвэр нь хуульд нийцсэн, тухайн хэрэгт баримталбал зохих материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээнд заасан бүх шаардлагыг хангасан байх ёстой. Шүүгч шийдвэр гаргахдаа тухайн хэрэгт хэрэглэсэн хууль, журам бүрийг зөв оновчтой хэрэглэсэн, мөн хэргийн нотлох баримтуудад хийсэн дүгнэлт нь үндэслэл сайтай, логик зүй тогтолтой байх ёстой. Хэрэв хууль зүйн алдаа (жишээ нь, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хэрэглэх ёстой хуулийг хэрэглээгүй орхигдуулсан) эсвэл нотлох баримтын үнэлгээнд алдаа гарвал (жишээ нь, огт авч үзээгүй баримт, эсвэл үндэслэлгүй дүгнэлт) уг шийдвэрийг давж заалдах шатны шүүхээс хүчингүй болгож болдог. Английн эрх зүйд “lawful and well-founded” буюу хууль ёсны, үндэслэл сайтай байх нь бүх шүүхийн шийдвэрт тавигдах нийтлэг шалгуур юм.²¹⁴

Англи Улсын шүүхийн байгууллага сүүлийн жилүүдэд шүүн таслах ажиллагааны ил тод байдал, шийдвэрийн ойлгомжтой байдлыг сайжруулахад анхаарал хандуулсаар иржээ. Тус улсад 1990-ээд оноос “plain English” буюу энгийн, ойлгомжтой англи хэлээр шүүхийн шийдвэр, баримт бичиг боловсруулах хөдөлгөөн өрнөж, шүүгч нар хэрэгт хамааралгүй хуучны латин хэллэг, мэргэжлийн үг хэллэгээс зайлсхийж, иргэдэд шууд ойлгогдох загвараар бичихийг уриалж эхэлсэн.²¹⁵ Уг хөдөлгөөнд “Шүүх шийдвэрээ бичихдээ ил тод байдлыг баримтлах нь хамгийн чухал зарчим байх ёстой” хэмээн онцолсон байна.²¹⁶ Үүний үр дүнд зөвхөн хуульчид гэлтгүй, шүүгдэгч, хохирогч, цаашлаад энгийн иргэд ч шүүхийн шийдвэрийг ойлгох боломжтой болно гэж үздэг.

214 The National Archives, “Find Case Law, Understanding judgments and decisions”, <https://caselaw.nationalarchives.gov.uk>, 2025, (Сүүлд үзсэн: 2025.09.09).

215 Clare Dyer, “Civil courts drop broken Latin for plain English in effort to simplify cases”, <https://www.theguardian.com/uk/1999/jan/30/claredyer>, (Сүүлд үзсэн: 2025.09.09).

216 Sarah Hopkinson, Kate Longson, “A Few Pieces Short of a Jigsaw: Appealing Inadequately Reasoned Judgments”, 2021, <https://ropewalk.co.uk>, (Сүүлд үзсэн: 2025.09.09).

2003 онд баталсан Эрүүгийн эрх зүйн актын (Criminal Justice Act) -ийн 174 дүгээр зүйлд **эрүүгийн хэрэгт ял оногдуулахдаа шүүгдэгчид ял оногдуулах үндэслэл, шалтгааныг тайлбарлах үүргийг (шүүгчид) хүлээлгэсэн** байна. Тодруулбал, Ял оногдуулахад шүүх «яагаад тийм хэмжээний шийтгэл оногдуулж байгааг болон уг шийтгэлийн утга, үр нөлөө нь юу болохыг» шүүн таслах ажиллагааны төгсгөлд тайлбарлах ёстой байдаг нь хуульчлагдсан байдаг.²¹⁷ Эдгээр нь шүүхийн шийдвэр нь аль болох ойлгомжтой, хууль ёсны, бүрэн үндэслэлтэй байх ёстойг баталгаажуулсан зохицуулалтууд юм.

3. Шүүхийн шийдвэрт нотлох баримтыг тусгах нь

Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрт нотлох баримтуудыг хэрхэн тусгаж, дүгнэж бичдэг талаар шүүхийн практикт хэд хэдэн онцлог ажиглагддаг. Дээр дурдсанчлан, шүүгч нь шийдвэрт хэргийн үйл баримтыг тоймлон бичихдээ хэргийн оролцогч талуудаас гаргасан гол нотлох баримтуудыг дурдана. Үүнд гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, бичиг баримт, зураг, дүрс бичлэг, эд мөрийн баримт зэрэг бүх төрлийн нотлох баримтыг хамруулдаг. Шүүгч нотлох баримтуудыг нарийн дэс дараалалтайгаар жагсаан бичихээс илүүтэйгээр маргааны гол асуудал тус бүрээр бүлэглэн, тухайн асуудалд хамаарах нотлох баримтыг хэлэлцэж, үнэлсэн байдлаар бичдэг нь түгээмэл байна.²¹⁸

а) Гэрчийн мэдүүлэг

Шүүхийн шийдвэрт гол гэрч нарын мэдүүлгийг товчхон өгүүлж, шүүгч мэдүүлгийн үнэн зөв байдал, найдвартай байдлыг хэрхэн үнэлснээ дурдана. Жишээлбэл, маргаж буй асуудлын талаарх хоёр гэрчийн мэдүүлэг зөрүүтэй байвал шүүгч шийдвэртээ «А гэрчийн мэдүүлгийг В гэрчийн мэдүүлгээс илүү үнэмшилтэйд тооцов, учир нь А гэрч болсон явдлын талаар илүү тодорхой санаж байхад В гэрчийн мэдүүлэг зарим талаар зөрчилтэй, санаанд оромгүй байсан» гэх зэргээр тайлбарладаг.

217 Scottish Sentencing Council, “How are sentencing guidelines developed”, <https://www.scottishsentencingcouncil.org.uk>, 2023, (Сүүлд үзсэн:2025.09.09).

218 England and Wales Court of Appeal (Civil Division), 2002.04.30, English v. Emery Reimbold & Strick Ltd [2002] EWCA Civ 605, <https://www.casemine.com/judgement/> (Сүүлд үзсэн:2025.09.09).

English v. Emery Reimbold & Strick (2002)-ийн шийдвэрт тусгаснаар, шийдвэрийн үндэслэл болгож буй нотлох баримт тус бүрийг жагсаах албагүй боловч шийдвэрт нөлөөлсөн гол асуудал болон тэдгээрт хамаарах нотлох баримтын үнэлгээ, дүгнэлтийг заавал тусгах хэрэгтэй гэжээ.²¹⁹ Өөрөөр хэлбэл, **шүүгч бүх гэрчийн мэдүүлгийг нарийн хуулбарлан бичих шаардлагагүй ч аливаа маргаан бүхий шийдвэрт ач холбогдолтой нотлох баримтыг дурдсан байх ёстой байдаг.** Шаардлагатай үед шүүгч зарим гэрчийн мэдүүлэгт илүү итгэсэн шалтгаанаа тайлбарлах замаар нотлох баримтыг шийдвэртээ тусгадаг.

б) Шинжээчийн дүгнэлт, бичиг баримтууд

Шүүх шийдвэр гаргахад нөлөөлсөн шинжээчийн дүгнэлт, шинжилгээний үр дүн, бичиг баримтын нотолгоонуудыг дурдана. Жишээлбэл, ДНХ-ийн шинжилгээ, хурууны хээ нь хэрэгт ач холбогдол бүхий чухал нотлох баримт байна гэж шүүгч үзвэл энэ талаар шүүхийн шийдвэрт “шинжээчийн дүгнэлтээр шүүгдэгч Х-г хэргийн газарт байсныг нотолж байна” гэх байдлаар тусгадаг байна.

в) Эд мөрийн баримт болон бусад нотолгоо

Шүүгч хэргийн газраас хураагдсан биет баримт (зэвсэг, хэрэгсэл гэх мэт) болон зураг, дуу-дүрсний бичлэг зэрэг нотлох баримтыг дурддаг. Ингэхдээ уг нотлох баримтыг хадгалсан нөхцөл, найдвартай байдал зэргийг давхар хэлэлцсэн байдлаар бичнэ. Тухайлбал, «хяналтын камерын бичлэгт харагдах хүн нь шүүгдэгч мөн болохыг батлах хангалттай төсөөтэй байдал ажиглагдсан» гэх байдлаар шүүгч дүгнэлт хийнэ.²²⁰

Шүүгч нотлох баримтыг шийдвэрийн үндэслэл хэсэгт дээрх байдлаар тусгах бөгөөд энэ нь шүүгчийн гаргасан дүгнэлт нь нотолгоотой, үндэслэл бүхий болохыг харуулах зорилготой байдаг. Шүүхийн шийдвэрт нотлох баримтыг тусгахдаа ямар нэг тогтсон форматаар “баримт бүрээр” жагсаалт хийхээс илүү тухайн хэргийг

219 Мөн тэнд.

220 Judicial College, “Crown Court Compendium Part I (2023 edition)”, 2023, 15-14, <https://www.judiciary.uk> (Сүүлд үзсэн: 2025.09.09).

шийдвэрлэхэд ач холбогдолтой баримтуудыг онцлон авч үзэж, “*гол асуудлуудад хамаарах баримтуудын үнэлгээ*”-г тусгадаг гэж хэлж болно.²²¹ Шүүгч шийдвэртээ нотлох баримтуудыг ойлгомжтой байдлаар тайлбарлаж, ямар баримтад илүү жин өгснөө дурдах замаар нотолгоог тусгадаг нь давж заалдах шатанд чухал ач холбогдолтой (давж заалдах шүүх анхан шатны шийдвэрийг уншаад ямар баримтад тулгуурлаж, юу гэж дүгнэсэн болохыг ойлгох боломжтой байх шаардлагатай).

Тангарагтны шүүхийн хувьд дээр дурдсанчлан шүүхийн шийдвэрийн үндэслэлийг дэлгэрэнгүй байдлаар бичгээр гардаггүй. Тангарагтны шүүх зөвлөлдөж шүүгдэгч буруутай эсвэл буруугүй гэсэн товч шийдвэр хэлдэг тул тэр нь бичмэл тайлбартай үлддэггүй байна. Харин шүүгч тангарагтанд хандаж хэрэгт авагдсан нотлох баримтыг хэлэлцүүлэхдээ “summing-up” буюу хэргийн талаарх дүгнэлт, зааварчилгааг аман хэлбэрээр өгдөг.²²² “Summing-up” нь тангарагтны шүүхэд хандаж нотлох баримтуудыг хэрхэн ойлгох, хууль зүйн шалгуурыг хэрхэн хэрэглэхийг тайлбарласан аман хэллэг бөгөөд шүүхийн шийдвэрийн нэг хэсэг болдоггүй (зарим тохиолдолд дээд шүүхэд гомдол гаргах үед протокол, бичлэгээр шалгагддаг). Тиймээс, тангарагтны шүүхийн эрүүгийн хэргийн хувьд анхан шатны “шийдвэрийн бүтэц” нь дээр хэлсэнчлэн зөвхөн шүүхийн протокол, ялын тогтоол (магадлал) болон шүүгчийн ялын талаарх тайлбараар хязгаарлагддаг. Харин давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан тохиолдолд давж заалдах шатны шүүгч нар тухайн хэргийн баримт, нотолгооны талаар өөрсдийн бичгээр үндэслэл бүхий шийдвэрийг гаргадаг.

4. Шийдвэрийг хуульд заасан ёсоор боловсруулахгүй байх нь гомдлын үндэслэл болох талаар

Англи Улсад “*шийдвэрийн бичлэгийн алдаа*” гэж нэрлэсэн гомдлын төрөл байдаггүй ч, **шийдвэрийн үндэслэл дутуу, ойлгомжгүй,**

221 Sarah Hopkinson, Kate Longson, “A Few Pieces Short of a Jigsaw: Appealing Inadequately Reasoned Judgments”, <https://ropewalk.co.uk>, 2021, (Сүүлд үзсэн: 2025.09.09).

222 Judicial College, “Crown Court Compendium Part I (2023 edition)”, 2023, 15-14, <https://www.judiciary.uk> (Сүүлд үзсэн: 2025.09.09).

эргэлзээтэй байдал нь давж заалдах гомдол гаргах нэг нөхцөл болж болно. Тодруулбал, анхан шатны шүүхийн шийдвэрт шүүгч яагаад тийм үр дүнд хүрснийг ойлгоход хүндрэлтэй, чухал асуудлуудыг дурдалгүй орхигдуулсан, эсвэл дүгнэлтийн логик холбоос алдагдсан бол ялагдсан тал “шүүхийн шийдвэр хангалттай үндэслэлтэй байж чадаагүй” гэсэн агуулгаар давж заалдах гомдол гаргах боломжтой.²²³

Гэвч практикт зөвхөн шийдвэрийн үндэслэл дутуу гэдгээр давж заалдах нь ховор тохиолддог. *English v. Emery Reimbold & Strick (2002)* хэргийн дараа үндэслэл дутуу гарсны улмаас давж заалдах гомдол гаргах явдал ихэссэн бөгөөд үүнийг шүүхүүд «давж заалдах гомдлын нэг жижиг үйлдвэрлэл болж хувирлаа» хэмээн шүүмжилсэн байдаг.

Филлипс Лорд шүүгч энэ хэргийн шийдвэрт: “Давж заалдах журмаар хэргийг хянахад шүүгчийн шийдвэрээс яагаад тийм шийдвэр гарсныг ойлгох боломжтой байх ёстой. Гэхдээ энэ нь шүүгч нотлох баримтыг үнэлэхдээ толгойдоо орсон бүх бодлоо бичих ёстой гэсэн үг биш. Шийдвэр гаргахад нөлөөсөн гол маргаантай асуудлуудыг тодорхойлж, хэрхэн шийдсэнийг нь тайлбарласан байхад хангалттай... Шаардлагагүй зүйлсийг нуришиж, хэт дэлгэрэнгүй бичих хэрэггүй, харин шийдвэрт шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байсан асуудлууд, баримтуудыг л онцолж бичнэ” хэмээн тайлбарласан байдаг.²²⁴ Энэ нь шүүхийн шийдвэр тодорхой асуудлуудаар дутуу байвал давж заалдах үндэслэл байж болох ч, бүх зүйлийг бичээгүй байлаа гээд автоматаар хүчингүй болохгүй гэсэн санаа юм.

Англи Улсын давж заалдах шатны шүүхээс шүүхийн шийдвэрийн үндэслэл тодорхой бус байвал эхлээд анхан шатны шүүгчээс тайлбар, нэмэлт үндэслэл гаргуулах боломжийг талууд ашиглах хэрэгтэй талаар зөвлөсөн байна. Тухайлбал, давж заалдах шатны шүүх *English v. Emery Reimbold* хэрэгт “Хэрэв үндэслэл дутуу гэсэн гомдол гаргах гэж байгаа бол анхан шатны шүүгчээс өөрөөс нь энэ талаар тодруулга,

223 Sarah Hopkinson, Kate Longson, “A Few Pieces Short of a Jigsaw: Appealing Inadequately Reasoned Judgments”, <https://ropewalk.co.uk>, 2021, (Сүүлд үзсэн: 2025.09.09).

224 Мөн тэнд.

нэмэлт үндэслэл авч болох эсэхийг харгалзах ёстой. Шүүгч үнэхээр дутуу бичсэн гэдгээ ойлговол нэмэлт үндэслэл бичиж, гомдол гаргах шаардлагагүй болгож болно...” гэж тэмдэглэсэн байдаг.²²⁵ Ингэснээр шууд давж заалдах, цаг мөнгө үрэхийн оронд тухайн шүүгчээс тодруулга авах нь зөв гэж үзсэн байна. Хэрэв шүүгч нэмж тодруулсан ч, эсвэл тухайн шийдвэр үнэхээр учир дутагдалтай бол давж заалдах шатны шүүх шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэх (шинээр хэлэлцүүлэх) захирамж гаргаж болно. Гэхдээ энэ нь тун ховор, онцгой тохиолдолд хэрэглэгддэг арга хэмжээ юм гэж шүүх тэмдэглэсэн байдаг.²²⁶

Дээрхээс харвал, **шийдвэрийг хуульд зааснаар буюу дээр дурдсан шаардлагад нийцүүлэн бичээгүй нь** (үндэслэл муутай, ойлгомжгүй, гол асуудлыг орхигдуулсан гэх мэт) онолын хувьд давж заалдах гомдол гаргах нэг үндэслэл болно. Гэвч давж заалдах шатны шүүх уг үндэслэлийг нягтлан үзэхдээ, тухайн шийдвэрийг бүхэлд нь уншиж, шүүгч шийдвэрийн үр дүнг ойлгогдохуйц тайлбарласан эсэхэд эргэлзээ төрвөл л хөнддөг. Ихэнх тохиолдолд шийдвэрийн бичилтийн жижиг алдаа, дутуу тайлбар байсан ч шүүхийн шийдвэр логик ойлгомжтой байвал хүчингүй болгодоггүй.²²⁷ Зөвхөн давж заалдах шатны шүүх үнэхээр ойлгох боломжгүй нөхцөлд л хүчингүй болгох нь элбэг. Жишээ нь, хэрэв шүүгч ямар нэг маргаантай гол нотлох баримтыг огт дурдаагүй, эсвэл хоёрдмол утгатай шийдвэр гаргасан тохиолдолд давж заалдах шатны шүүхээс «шийдвэрийн үндэслэл хангалтгүй» гэж үзэн буцаах, дахин хэлэлцүүлэх магадлалтай байна.

5. Шүүхийн шийдвэрт латин нэр томьёоны хэрэглээ

Латин нэр томьёо нь Англи Улсад олон зуун жилийн туршид хуульчдын гол хэл байсан бөгөөд хууль зүйн олон ойлголтыг латинаар нэрлэж ирсэн. Жишээлбэл, “*mens rea*”, “*actus reus*”, “*habeas corpus*”, “*prima facie*” зэрэг латин хэллэгүүд нь өнөөг хүртэл хууль зүйн салбарт ашиглагддаг нийтлэг нэр томьёонууд юм. Шүүхийн шийдвэр

225 Мөн тэнд.

226 Мөн тэнд.

227 Judicial College, “Crown Court Compendium Part I (2023 edition)”, 2023, 15-14, <https://www.judiciary.uk> (Сүүлд үзсэн: 2025.09.09).

бичихэд эдгээр нэр томъёог шүүгч хэрэглэж болох ч, одоо үед аль болох энгийн орчуулга, англи хувилбарыг хэрэглэхийг эрмэлздэг болсон.²²⁸

1999 онд тус улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх шинэ журам (Woolf-ийн шинэтгэл) хэрэгжиж эхлэхдээ, уламжлалт зарим латин нэр томъёог халж, оронд нь англи нэр томъёог хэрэглэхээр болсон байна.²²⁹ Жишээлбэл:

- “Plaintiff” (нэхэмжлэгч) гэх латин гаралтай үгийг “Claimant” болгож өөрчилсөн.
- Шүүх хуралдааныг олон нийтээс нууцаар хийхийг илэрхийлдэг “in camera” (хаалттай) гэдэг хэллэгийг “in private” гэж,
- “ex parte” гэдгийг “without notice” (нөгөө талд мэдэгдэлгүйгээр) гэж орлуулсан,
- Мөн “Mareva injunction” гэх мэт нэр томъёог “freezing injunction” гэж өөрчилсөн байна,
- Эрүүгийн шүүхийн хувьд ч “bind over”, “recognizance” зэрэг хуучны хэллэгүүдийг энгийн үг хэллэгээр солих чиглэл баримталж ирсэн.

Энэ мэтээр, хууль зүйн латин нэр томъёоны хэрэглээ шүүхийн шийдвэрт эрс багассан. **Plain English** буюу энгийн англи хэлний хөдөлгөөний нөлөөгөөр, шүүгч нар шийдвэр бичихдээ олон нийтэд танил бус латин үг хэллэгээс зайлсхийх хандлагатай болсон юм.²³⁰ Латин нэр томъёо хэрэглэх шаардлагатай тохиолдолд, тухайн нэр томъёо нь хуульчдад өргөн танигдсан, товч тодорхой бол яг тэр чигээр нь хэрэглэдэг. Жишээ нь *prima facie*, *habeas corpus* гэх мэт нь одоо хууль зүйн англи хэлний нэг хэсэг болсон тул шууд хэрэглэдэг. Гэхдээ шүүгч тодруулж бичихийг хүсвэл, заримдаа хаалт дотор орчуулга, тайлбар нэмж өгдөг. Жишээ нь, “*prima facie (at first sight)*”

228 Judicial College, “Guide to Judicial Conduct”, 2023, <https://www.judiciary.uk/> (Сүүлд үзсэн: 2025.09.09).

229 Clare Dyer, “Civil courts drop broken Latin for plain English in effort to simplify cases”, <https://www.theguardian.com/uk/1999/jan/30/claredyer>, (Сүүлд үзсэн: 2025.09.09).

230 Мөн тэнд.

гэж тайлбарлах зэрэг нь бий. Тодруулбал, “*prima facie*” гэдэг нь латинаар “*анх харахад*” гэсэн утгатай бөгөөд хуульд аливаа нотлох баримт эсвэл кейс гаднаас нь харахад хангалттай үндэслэлтэй мэт санагдаж буй байдлыг хэлдэг.²³¹

Өөр нэг жишээ, эрүүгийн хэрэгт “*mens rea*” (латинаар “гэм буруугийн санаа”) гэдэг ойлголтыг байнга хэрэглэдэг. Шүүхийн шийдвэрт “*mens rea нь нотлогдсон*” гэх мэтээр бичиж болно. Энэ нэр томьёо нь эрх зүйн ном, сургалтад түгээмэл тул шүүгч нар тайлбаргүй хэрэглэвэл ч ойлгогдоно. Гэхдээ өнөө үед шүүгч нар үүнийг “*criminal intent*” буюу “зорилгот тавьсан гэм буруугийн санаа” гэж англиар нь шууд бичдэг.²³²

Дээрхээс харвал, тус улсын шүүхийн шийдвэрт латин нэр томьёог аль болох энгийн үгээр орлуулж бичих чиглэлтэй болсон. Гэхдээ зарим хууль зүйн ухагдахуунууд нийтлэг ойлголт болсон тул хэвээр хэрэглэгдэж байна. Хэрэв хэрэглэвэл бичгийн хэлбэрт налуу үсгээр (*italic*) бичих нь элбэг (энэ нь гадаад үг хэллэг болохыг тэмдэглэдэг бичгийн стандарт юм).²³³

5. Мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг шүүхийн шийдвэрт тусгах нь

Орчин үеийн эрүүгийн хэрэгт хяналттай тээвэрлэлт, харилцаа холбоо чагнах, зэрэг тусгай арга, нууц ажиллагаа явуулах тохиолдол их гардаг. Англи Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нууц мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг шүүхийн хэлэлцүүлэгт хэрхэн ашиглах, шийдвэрт тусгах талаар тодорхой зарчмууд тогтсон байдаг.

Ерөнхий зарчим: Мөрдөн шалгах явцад олж авсан аливаа нотлох баримт нь шүүхэд ил тод, нотлох баримтын хэлбэрээр танилцуулагдсан тохиолдолд шүүхийн шийдвэрт бусад нотлох баримттай адил авч үздэг. Хуульд заасан үндэслэл, журмаар нууц мөрдөн шалгах

231 Barбора Korcova, “The Top 10 Most Used Latin Legal Terms”, 2024, <https://emlaw.co.uk>, (Сүүлд үзсэн: 2025.09.09).

232 Judicial College, “Crown Court Compendium Part I (2023 edition)”, 2023, 15-14, <https://www.judiciary.uk> (Сүүлд үзсэн: 2025.09.09).

233 Ryan McCarl, “When should lawyers italicize Latin phrases”, 2023, <https://www.elegantlegalwriting.com/>, (Сүүлд үзсэн: 2025.09.09).

ажиллагааны хүрээнд цуглуулсан нотлох баримтуудыг шүүх хуралдаан дээр хэлэлцүүлсэн бол шүүгч уг баримтуудыг үнэлж, шийдвэртээ дурдах эрхтэй байдаг. Жишээ нь, хууль бусаар хар тамхи худалдан борлуулах гэмт хэргийг мөрдөн шалгахдаа цагдаа нар нууц ажилтан илгээж, худалдан авалт хийсэн бол тэр нууц ажилтан шүүхэд гэрчээр мэдүүлж, эсхүл бичлэг нотлох баримтаар гаргаж ирэн, шүүгч түүнийг нь шийдвэртээ дүгнэн тусгана.²³⁴

Мөрдөн шалгах нууц ажиллагааны үед цуглуулсан зарим баримт нь улсын нууцад хамаарах баримт байж болно. Тухайлбал, терроризм, улсын аюулгүй байдалтай холбоотой мөрдлөгийн явцад олдсон мэдээлэл, эсвэл тагнуулын байгууллагын ажиллах арга барил илэрч болзошгүй баримтууд гэх мэт. Энэ тохиолдолд шүүх “Нийтийн ашиг сонирхлын халдашгүй байдал” (Public Interest Immunity, PII) гэх механизмыг ашигладаг. Энэ нь прокурор, хууль хамгаалах байгууллагаас зарим нотлох баримтыг нууцлах буюу хаалттай хэлбэрээр шүүхэд танилцуулах хүсэлт гаргаж, шүүх хүсэлтийн дагуу хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа юм.²³⁵

Нууц ажиллагааны үр дүнг шүүхийн шийдвэрт хэрхэн тусгах нь тухайн хэргийн нөхцөлөөс ихээхэн хамаарна:

- **Нээлттэй шүүх хуралдаан:** Мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад олж авсан нотлох баримтыг задруулахаар шийдэж, шүүх хуралдаан дээр ил болгосон бол, тэр нь бусад нотлох баримттай адил шийдвэрт дурдагдана.²³⁶ Жишээ нь, цагдаагийн нууц мөрдөгчийн өгсөн мэдүүлэг, эсвэл камерын бичлэгийг нотлох баримтаар хэлэлцсэн бол шийдвэрт «нууц мөрдөгч Х-ийн өгсөн мэдүүлэгт дурдсанаар...” гэх мэтээр энгийнээр бичиж тусгана. Энэ үед тухайн мөрдөгчийн жинхэнэ нэрийг нууцлах шаардлагатай бол шүүх өөр нэр буюу хоч

234 Police and Criminal Evidence Act (1984), <https://www.legislation.gov.uk/ukpga/1984/60/contents> (Сүүлд үзсэн:2025.09.09).

235 United Kingdom House of Lords Decisions, 1968.02.28, UKHL 2, Conway v Rimmer [1968] AC 910 (HL) <https://www.bailii.org/uk/cases/UKHL/1968/2.html> (Сүүлд үзсэн:2025.09.09).

236 Regulation of Investigatory Powers Act (2000), <https://www.legislation.gov.uk/ukpga/2000/23/contents>, (Сүүлд үзсэн:2025.09.09).

(жишээ нь “Officer A”, “Mr. X” гэх мэт) ашигладаг.²³⁷

- **Хаалттай шүүх хуралдаан, нууц хавсралт:** Хэрэв нотлох баримтыг нийтэд ил болгох нь аюултай гэж шүүх үзсэн, уг нотлох баримт нь хэргийн шийдвэрт ач холбогдолтой бол шүүх хаалттай шүүх хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрийнхээ нууц хэсэгт тусгах боломжтой. Жишээлбэл, давж заалдах шатны шүүх *Stoke-on-Trent*-ийн гэмт хэргийн нууц мэдээллийг харгалзан ял шийтгүүлсэн шүүгдэгч нарын ялыг хөнгөрүүлэн өөрчилсөн байдаг. Энэ тохиолдолд давж заалдах шатны шүүхийн шийдвэрт уг нууц материалыг дурдаагүй, харин “итгэмжлэгдсэн нууц хавсралт” болгон боловсруулж, зөвхөн шүүгчид ба холбогдох талууд үзэх эрхтэйгээр хавсаргасан байна. Өөрөөр хэлбэл, нийтэд нээлттэй болсон шүүхийн шийдвэрт нууц нотлох баримтыг оруулдаггүй байна.
- **Нууц мэдээллийг огт ашиглахгүй байх:** Зарим тохиолдолд мөрдөн байцаалтын явцад олдсон нууц мэдээллийг шүүх хуралдаанд ашиглах боломжгүй (жишээ нь, шүүх нууцлах хүсэлтийг зөвшөөрөхгүй буюу эсвэл ашиглахыг хориглосон нь хууль зүйн үндэслэлтэй бол).

3. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС (АНУ)

АНУ-д шүүхийн систем нь муж бүрд өөрийн шүүхийн тогтолцоотой бөгөөд холбооны шүүх тусдаа байдаг. АНУ нь жишгийн эрх зүйн бүлд хамаардаг учраас шүүхийн шийдвэр буюу прецедент нь эрх зүйн эх сурвалж болдог, шүүгч шийдвэр гаргахдаа үүнийг харгалзан үздэгээрээ онцлог байна.

Тус улсад эхэн үедээ шүүхийн шийдвэрийг бичгийн хэлбэрээр гаргадаггүй байсан бөгөөд ихэвчлэн шүүх хуралдааны оролцогч талуудад шийдвэрийг амаар танилцуулдаг байсан. Шүүхийн дээрх практик нь 1789 онд байгуулагдсан Холбооны шүүхийн үеэс эхлэлтэй

²³⁷ Judicial College, “Crown Court Compendium Part I (2023 edition)”, 2023, 15-14, <https://www.judiciary.uk> (Сүүлд үзсэн:2025.09.09).

байна. Үүний дараа 1880-аад оноос эхлэн шүүхийн шийдвэрийг бичгээр гаргах практик тогтсон бөгөөд энэ нь шүүхийн шийдвэрийг аман хэлбэрээр гаргахаас илүү үр дүнтэй, ойлгомжтой болгох боломжтой гэж үзсэн байна.²³⁸

Шүүх шийдвэрийг бичгээр гаргах нь шүүхийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, олон нийтэд шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдүүлэх, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ач холбогдолтой гэж үздэг байна. Үүнээс гадна тус улсад шүүхийн шийдвэрийг бичгээр гаргах нь дараах шалтгаантай. Үүнд:²³⁹

- АНУ-ын Үндсэн хууль болон Хүний эрхийн тунхаглалд гэмт хэрэг үйлдсэн гэм бурууг тогтоох, ял оногдуулах шийдвэр нь шударга ёс, нотолгоонд тулгуурласан байх ёстой гэж заасан. Үүний хэрэгжилтийн нэг хэлбэр нь шүүхийн шийдвэрийг бичгээр гаргах явдал байна.
- Шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл хэргийн оролцогчид тухайлбал, шүүгдэгч, түүний өмгөөлөгч, прокурор нь давж заалдах гомдол гаргах эрхтэй. Уг эрхийн хэрэгжилтэд бичгээр гаргасан шүүхийн шийдвэр нь чухал ач холбогдолтой байдаг.²⁴⁰
- Тус улсын эрх зүйн тогтолцооны онцлогоос үүдэн бичгээр гарч буй шийдвэр зөвхөн тухайн хэрэгт бус ирээдүйд шийдвэрлэх ижил төстэй хэргүүдэд жишиг болдог. Хэрэв бичгээр шүүхийн шийдвэрийг гаргаагүй бол жишиг болох боломжгүй байна.²⁴¹

АНУ нь муж улсуудын эрх зүйн зохицуулалт, хуулиас шалтгаалан Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн бүтэц, шийдвэрийг олон нийтэд нийтлэх стандарт зэрэг нь харилцан адилгүй байдаг. Тус улсад 1946 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх Холбооны

238 Federal judicial center, “Reporting of decisions in the early federal courts”, <https://www.fjc.gov/history/spotlight-judicial-history/reporting-decisions>, (Сүүлд үзсэн: 2025.08.22).

239 Cornell law school, legal information center, “Due process”, https://www.law.cornell.edu/wex/due_process, (Сүүлд үзсэн: 2025.08.26).

240 United states court of UK, “Written opinions are essential for appellate review, allowing higher courts to examine the reasoning and evidence underlying the lower court’s judgment. This ensures that the right to appeal is meaningful and supports judicial accountability”, <https://www.uscourts.gov/about-federal-courts/educational-resources/educational-activities/first-amendment-activities/us-v-alvarez/glossary-us-v-alvarez>, (Сүүлд үзсэн: 2025.08.26).

241 Public health law map-Beta, “The Importance of precedent”, <https://biotech.law.lsu.edu/map/TheImportanceofPrecedent.html?utm>, (Сүүлд үзсэн: 2025.08.26).

дүрэм²⁴² (англ. Federal Rules of Criminal Procedure)-д шүүхийн шийдвэрийн бүтцийн талаар тусгасан байна. Гэхдээ шүүхийн шийдвэрийн бүтцийг нарийвчлан зохицуулсан журам байдаггүй гэдгийг дурдах нь зүйтэй.

32 дугаар дүрэм (Rule 32)

“Шүүх шийтгэх тогтоолдоо шүүгдэгчийн мэдүүлэг, тангарагтны шүүхийн шийдвэр эсхүл шүүхийн дүгнэлт, шийдвэр, ялын төрлийг тусгах ёстой. Хэрэв шүүгдэгч гэм буруугүй нь тогтоогдсон эсвэл өөр үндэслэлээр ялаас чөлөөлөгдсөн бол шүүх тэрхүү шийдвэрийг гаргах ёстой. Шүүгч шүүхийн шийдвэрт гарын үсэг зурж, шүүхийн бичиг хэргийн ажилтан түүнийг бүртгэх ёстой.”²⁴³

Дээрхээс харвал уг дүрэмд шүүхийн шийдвэрийн бүтцийг ерөнхий байдлаар тусгасан байна. Тус улсын хуульч, судлаачдын үзэл баримтлалд шүүхийн шийдвэр нь дараах хэсгүүдээс бүрдвэл зохистой хэмээн тайлбарлажээ. Үүнд:

- Баримт тогтоох хэсэг (англ. fact-finding),
- Хууль зүйн үндэслэл хэсэг (англ. legal reasoning),
- Шийдвэрлэх хэсэг (англ. judgment) гэсэн үндсэн хэсэг.

Мөн Холбооны шүүх болон Мужийн шүүхийн шийдвэрийн бүтэц харилцан адилгүй хэдий ч нийтлэг байдлаар дараах бүтэцтэй байна.²⁴⁴

- 1) Удиртгал хэсэг (англ. Case caption)- Хэргийг шийдвэрлэж буй шүүхийн нэр, хэргийн дугаар, шүүх хуралдаанд оролцогчдын мэдээлэл, шүүхийн шийдвэр гарч буй он, сар, өдөр зэрэг байна.
- 2) Процессын түүх (англ. Procedural history)- Анхан шатны шүүх хянан шийдвэрлэсэн бол тухайн шүүхийн шийдвэр байна;
- 3) Нотлох баримт (англ. Facts)- Мөрдөн шалгах ажиллагаанд нотлогдсон шүүхээр хянан шийдвэрлэгдэх гол нотлох баримтууд/хэрэгт холбогдох гол баримтууд/;

242 Federal Rules of Criminal procedure (1946), <https://www.law.cornell.edu/rules/frcrmp> (Сүүлд үзсэн: 2025.09.22)

243 Federal Rules of Criminal procedure(1946), Rule 32.

244 Federal Judicial Center, “Judicial writing manual: A pocket guide for judges”, second edition,(2013), p11-13.

- 4) Шүүхээр хэлэлцэгдэх асуудал (англ.Issue)- Тухайн хэрэгт шүүх шийдвэрлэх гол хууль зүйн асуудал, хууль зөрчсөн маргаан байгаа эсэх тухай талуудын хүсэлт, гомдол зэрэг байна;
- 5) Хууль зүйн асуудал (англ.Reasoning)- Үндэслэж буй хуулийн заалтыг тайлбарлах хэсэг /Эрх зүйн удиртгал болсон зарчмууд, тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай тайлбар/;
- 6) Шийдвэр (англ.Judgment)-Шүүхээс гарч буй эцсийн шийдвэр.

АНУ-ын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн бичгээр гарч буй шийдвэр давж заалдах болон дээд шатны шүүхэд хянагдах боломжтой, шүүхийн зорилготой нийцсэн байх шаардлагатай байдаг.

Холбооны шүүхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд заавал бөглөх “Эрүүгийн хэргийн шийдвэр AO245 маягт” (англ. Judgment in a Criminal Case AO245B Form) гэх баримт бичиг байх бөгөөд үүнийг шүүгч, шүүхийн нарийн бичиг бөглөх үүрэгтэй байдаг. Уг маягтыг шүүхийн архивд хадгалах, хэргийн оролцогч талуудад өгөх болон олон нийтэд нээлттэй тавих боломжтой байна. Маягт нь 9 үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд агуулгын хувьд шүүхийн шийдвэрт бичигдэх шаардлагатай мэдээллүүд байдаг. Жишээлбэл, хэргийг шийдвэрлэсэн шүүх, хэргийн дугаар, холбогдох хуулийн заалт, гэмт хэргийн төрөл, оногдуулсан ялын төрөл, хэмжээ, гэмт хэргийн улмаас бий болсон хохирол, төлбөр, хугацаанаас нь өмнө суллах нөхцөл зэргийг заана.²⁴⁵

Муж улсуудын хувьд Техас, Мичиган зэрэг мужуудад Шүүхийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад шүүхийн шийдвэрийн бүтцийг дэлгэрэнгүй тусгасан байдаг бол “Эрүүгийн хэргийн шийдвэр AO245” маягтад үндэслэн шүүхийн шийдвэрийн бүтцийг боловсруулсан мужууд ч мөн байдаг. Иймд АНУ-ын мужуудын нэг болох Вашингтон мужийг сонгон авч тус мужийн эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн бүтцийг судлав.

²⁴⁵ Judgment in a Criminal Case AO245B Form, <https://www.uscourts.gov/sites/default/files/ao245b.pdf> , (Сүүлд үзсэн: 2025.08.22).

Вашингтон муж /Washington/²⁴⁶

Тус мужид Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр ямар стандарт болон бүтэцтэй байх талаар Мужийн Шүүхийн тухай хууль (англ. Court act) болон Эрүүгийн хэргийн шүүхийн дүрэм (англ. Washington Courts Criminal Rules for Courts of Limited Jurisdiction 2025)-д тус тус заажээ.

Мужийн Шүүхийн тухай хууль, дүрэмд зааснаар (англ. Criminal Rules (CrRLJ) шүүгч шүүх хуралдааны үеэр нотлох баримтыг хэрхэн үнэлсэн болон ямар үндэслэлээр шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай гэж үзсэн эсхүл цагаатгасан тухай шүүхийн шийдвэрт заавал дурдаж бичгээр гаргана²⁴⁷ хэмээн хуульчилжээ.

Шүүхийн шийдвэрийн бүтцийг мужийн Эрүүгийн хэргийн шүүхийн дүрэм (англ. Courts of Limited Jurisdiction)-ийн 1.5 дахь хэсэгт ерөнхийлөн тусгасан байна. Мөн тус дүрмийн 7.3 дугаар хэсэгт шүүхийн шийдвэрийг заавал бичгээр гаргаж, шүүгч, шүүгч нар гарын үсэг зурж баталгаажуулах, 7.3 дугаар зүйлд хөнгөн төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхэд гарч буй шүүхийн шийдвэрийн бүтэц болон бичгээр гаргах журмыг зохицуулсан байдаг.²⁴⁸

Шигтгээ №.8 АНУ-ын Вашингтон мужийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Шийтгэх тогтоолын бүтэц:

- 1) *Удиртгал хэсэг (англ. caption);*
- 2) *Хэргийн индекс, шүүх хурлын талаарх мэдээлэл (англ. Introduction);*
- 3) *Хууль зүйн дүгнэлт, дүн шинжилгээ (англ. conclusions of law);*
- 4) *Шүүхийн шийдвэрийн үндэслэл (англ. order);*
- 5) *Шүүгчийн гарын үсэг (англ. signature).*

Дүрэмд зааснаар шүүхийн шийдвэрт шүүгдэгч шүүх хуралдаанд өмгөөлөгчтэй оролцсон, эсхүл өөрийгөө өмгөөлж оролцсон эсэх, шүүх

²⁴⁶ Washington Courts. Superior Court Criminal Rules(2025). Olympia: Washington State Courts.

²⁴⁷ CrRLJ 6.1(d) "In a case tried without a jury, the court shall enter findings of fact and conclusions of law. If an opinion or memorandum of decision is filed, it will be sufficient if findings of fact and conclusions of law appear therein."

²⁴⁸ Ibid.

хуралдаанд гаргасан хүсэлт, гомдол, шийдвэр гаргасан үндэслэлийг зайлшгүй бичих шаардлагатай. Түүнчлэн шүүх шийтгэх тогтоолдоо онцгой нөхцөл буюу нэмэлт шаардлагыг бичиж болно. Үүнд: Торгууль, нөхөн төлбөр, шүүх хуралдаантай холбогдон гарсан зардал, түүнийг төлөх хуваарь зэрэг байна.²⁴⁹

Эрүүгийн хэргийн шүүхийн дүрэмд шүүхийн шийдвэрт заавал дурдагдах зүйлсийн талаар тусгажээ. Үүнд:

- Шүүгдэгчийн нэр (англ. Defendant's name);
- Шүүгдэгчийн хувийн мэдээлэл, иргэний дугаар (англ. Defendant's ID numbers);
- Шүүгдэгчийн холбогдсон гэмт хэргийг зүйлчилж буй хуулийн заалт (англ. Citation to the statute or ordinance, including subsections, under which the defendant was sentenced);
- Шүүгдэгчийг гэм буруутай гэж үзсэн нотлох баримт болон хэрэв шүүгдэгч гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэгт²⁵⁰ холбогдсон бол үүнийг тусгайлан тэмдэглэнэ (англ. identification of any charge to which the defendant pleaded guilty or was found guilty that is a crime of domestic violence under state law;);
- Хэрэг үйлдсэн болон хэргийн талаар гомдол, мэдээлэл ирсэн өдөр, хэрэг нээсэн өдөр (англ. Arraignment date);
- Шүүх хуралдаанд оролцогчдоос гаргасан хүсэлт (англ. The plea, and the date entered);
- Шүүгдэгч шүүх хуралдаанд өмгөөлөгчтэй оролцсон эсэх, эсвэл өөрийгөө өмгөөлж оролцсон эсэх, мөн өмгөөлөгчөөс татгалзсан хүсэлт байгаа эсэх;
- Шүүх хуралдаанд оролцож буй талуудын нэрс, гэрч нарын нэрс;

249 Ibid.

250 Тус улсын эрх зүйн зохицуулалтад энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүнийг тусгайлан тэмдэглэх, бүртгэх шаардлагатай байдаг.

- Шийдвэр бичигдэж буй огноо (англ. Verdict or findings, and the date entered);
- Шийдвэр гарч буй үндэслэл болон торгууль, нөхөн төлбөр, бусад зардал зэргийг дурдана.

Хэрэв шүүгдэгч гэм буруугүй нь тогтоогдсон, эсвэл хуульд заасан өөр үндэслэлээр суллагдах шийдвэр гарсан тохиолдолд тухайн үндэслэлийг шүүхийн шийдвэрт тодорхой дурдана. Шүүхийн шийдвэрийг цаасан хэлбэрээр эсхүл цахим хэлбэрээр гаргаж хадгалах ёстой байна.²⁵¹

Тус Мужийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр нь шүүх хуралдааны хэлбэрээс шалтгаалан шүүх хуралдааны шийдвэр, шийтгэл оногдуулсан шийдвэр гэсэн 2 төрлөөр гардгаараа онцлог байна.

Шүүх хуралдааны шийдвэр (англ.bench trial): Шүүх хуралдаан хуульд заасны дагуу явагдсаны дараагаар гарч буй шүүхийн шийдвэр бөгөөд прокурор болон өмгөөлөх талын үндэслэл, нотлох баримтыг хэрхэн үнэлэх мөн шүүхийн шийдвэрийн үндэслэл зэргийг тусгайлан нэг бүрчлэн дурдсан байх шаардлагатай. Энэ төрлийн шүүхийн шийдвэр гарч буй зорилго нь тухайн гэмт хэрэгт шүүгдэгч яагаад гэм буруутай, эсхүл гэм буруугүй вэ гэдгийг нотолж, хууль зүйн үндэслэлийг гаргах юм.

Шийтгэл оногдуулсан шийдвэр (англ.Judgment and Sentence): Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэдгээ хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайлан гэм буруугийн хурал явагдах шаардлагагүйгээр ямар төрлийн гэмт хэрэгт буруутай болохыг дурдаж эрүүгийн хариуцлага оногдуулсан шийдвэр байна.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Жишгийн эрх зүйн бүлд шүүх шийдвэр гаргахдаа stare decisis буюу шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхдээ өмнө нь төсөөтэй хэргийг шийдвэрлэсэн шийдвэрт (precedent) үндэслэн гэх зарчмыг

251 Washington Courts,(2025),Criminal Rules for Courts of Limited Jurisdiction (CrRLJ).

баримталдаг. Шүүхийн шийдвэрийг бичгээр гаргаагүй нь төсөөтэй хэргийг шийдвэрлэсэн шийдвэрийн үндэслэлийг дараагийн шүүхүүд ашиглах боломжгүйд хүргэх, хууль хэрэглээний нэгдмэл бус байдал бий болгох зэрэг сөрөг үр дагавартай байжээ. Иймээс шийдвэрийг бичгээр гаргах шаардлага бий болсон байна. Улмаар Англи Улсад Шүүхийн Шийдвэр Эмхэтгэлийн Зөвлөл байгуулагдсанаар шүүхийн шийдвэрийг бичиж тэмдэглэх, нийтлэх тогтолцоо боловсронгуй болсон гэж үздэг.

Жишгийн эрх зүйн бүлд шүүхийн шийдвэрийг бичмэл хэлбэрээр боловсруулснаар уг шийдвэр нь эрх зүйн эх сурвалж болох, талуудад шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй танилцах боломж олгох, дээд шатны шүүхээс доод шатны шүүхийн шийдвэрт дүгнэлт хийх боломж олгох зэрэг ач холбогдолтой байна.

Уг эрх зүйн бүлд хамаарах зарим улсад шүүхийн шийдвэрийн бүтэц, түүний агуулгыг хуульд тусгайлан зохицуулаагүй ч шүүхийн шийдвэр нь хэргийн үйл баримтыг тайлбарлах хэсэг, эрх зүйн асуудлыг тодорхойлох, тухайн асуудлыг зохистойгоор шийдвэрлэх хэсэг, шийдвэр буюу үр дүн гэсэн хэсгүүдээс бүрддэг байна.

Жишгийн эрх зүлд хамаарах улсуудыг төлөөлүүлэн Англи Улс болон АНУ-ын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтцийг судлан үзвэл дараах онцлог шинжтэй байна.

Англи Улсад Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг боловсруулах арга зүй, бүтэц, агуулгыг хууль тогтоомжуудад тусгайлан заадаггүй ч шийдвэр нь хэргийн товч танилцуулга, үйл баримтын тойм, эрх зүйн асуудал, талуудын байр суурь болон дүгнэлт, шийдвэр гэсэн нийтлэг бүтцийн дагуу бичигддэг. Тус улсад гэмт хэргийн ангилал, шүүхийн харьяаллаас хамааран шийдвэрийн бүтэц ялгаатай байж болдог. Тухайлбал, тангарагтны шүүх хэргийг шийдвэрлэх тохиолдолд энгийн иргэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, шүүгдэгч гэм буруутай эсэх тухай товч дүгнэлт гаргадаг. Уг дүгнэлтэд хүрсэн үндэслэлийн талаарх

ямар нэгэн шийдвэрийг бичгээр гаргадаггүйгээрээ онцлог байна. Мөн тус улсад шүүхийн шийдвэр иргэдэд ойлгомжтой байдлаар бичих шаардлагыг тавихаас гадна шүүгдэгчид ял оногдуулсан бол ял оногдуулсан үндэслэл, шалтгааныг тайлбарлах үүргийг шүүгчид хүлээлгэсэн байна.

АНУ-ын хувьд 1880 оноос эхлэн шүүхийн шийдвэрийг бичгээр гаргах практик тогтсон бөгөөд шийдвэрийг бичгээр гаргах нь шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх, иргэд шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэх зэрэг ач холбогдолтой хэмээн үздэг. Тус улсад 1946 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх Холбооны дүрэмд шүүхийн шийдвэрт тусгах мэдээллийн талаар хуульчилсан байна. АНУ-д эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн бүтэц, агуулгыг муж тус бүрд харилцан адилгүй хэлбэрээр тогтоодог, Тухайлбал, Вашингтон мужид Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр ямар бүтэцтэй байх талаар Мужийн Шүүхийн тухай хууль болон Эрүүгийн хэргийн шүүхийн дүрэмд тус тус заасан байна. Үүнээс харвал жишгийн эрх зүйн бүлд хамаарах зарим улсад шүүхийн шийдвэрийн бүтцийг хуульд тусгадаг байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Монгол Улсын шүүхийн тухай хууль, 2021 он.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, 2017 он.
4. Эрүүгийн хууль, 2015 он.
5. Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 29 дүгээр тогтоол, 2021 он.
6. Монгол Улсын Дээд шүүхийн зөвлөмж дугаар 17, 2006 он.

Б. Ном, сурах бичиг

1. Б.Гүнбилэг, Жишгийн эрх зүй, 2008 он.
2. Т.Саруул, Эрх зүйг хэрэглэх арга зүй, 2014 он.
3. Йоахим Кают, Монгол Улсын шинэ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, Шүүхийн шийдвэр, тогтоол бичих арга техник, 2015 он.
4. Эмнести Интернэшнл, Шударгаар шүүлгэх эрх, 2014 он.

В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Б.Буянхишиг, “Иргэний хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”, Шүүх эрх мэдэл сэтгүүл, №3, 2015 он.
2. Ц.Цогт, Анхан шатны шүүхийн шийдвэрт эрх зүйн дүгнэлт бичих (“Брайт пэйнт” ХХК-ийн нэхэмжлэлтэй хэргийн жишээ дээр), legaldata.mn, 2016 он.
3. О.Мөнхсайхан, “Шүүхийн шийдвэр яагаад үндэслэгдсэн байх ёстой вэ”, Шүүх эрх мэдэл сэтгүүл, №2, 2016 он.
4. Л.Галбаатар, “Шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг хангах нь: Шүүхийн

шийдвэрийн чанарыг сайжруулах хүчин зүйлс”, *legaldata.mn*, 2016 он.

5. С.Өмирбек, Шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэх эрх, *legaldata.mn*, 2016 он.

В. Бусад

1. Улсын Дээд шүүхийн 2024 оны 07 сарын 03 өдрийн 99 дүгээр тогтоол.
2. Улсын Дээд шүүхийн 2024 оны 10 сарын 09 өдрийн 2024/ХШТ/118 дугаар тогтоол.
3. Улсын Дээд Шүүхийн 2024 оны 10 сарын 21 өдрийн 594 дүгээр тогтоол.
4. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 07 сарын 22 өдрийн 2023/ДШМ/856 дугаар магадлал.
5. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 05 сарын 07 өдрийн 423 дугаар магадлал.
6. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 05 сарын 10 өдрийн 2022/ДШМ/499 дүгээр магадлал.
7. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 05 сарын 21 өдрийн 2025/ДШМ/605 дугаар магадлал.
8. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 08 сарын 20 өдрийн 1058 дугаар магадлал.
9. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 07 сарын 02 өдрийн 668 дугаар магадлал.
10. Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 02 сарын 28 өдрийн 2023/ДШМ/12 дугаар магадлал.
11. Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 04 сарын 02 өдрийн 17 дугаар магадлал.
12. Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны

шүүхийн 2020 оны 12 сарын 16 өдрийн 2020/ДШМ/50 дугаар магадлал.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

Англи хэл дээр:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Federal Rules of Criminal procedure 1946.
2. Federal Judicial Center, “Judicial writing manual: A pocket guide for judges”, 2013.
3. Washington Courts. Superior Court Criminal Rules 2025.
4. Judgment in a Criminal Case AO245B Form.
5. Washington Courts, Criminal Rules for Courts of Limited Jurisdiction (CrRLJ), 2025.

Б. Ном, сурах бичиг

1. Graham Mayeda, “Uncommonly Common: The Nature of Common Law Judgment”, Canadian Journal of Law and Jurisprudence, 2006.
2. Richard K. Neumann and Kristen Konrad Tiscione, Legal Reasoning and Legal Writing, 4th ed. Aspen Law & Business, 2001.
3. Thomas Risse, “Common Law and its Basic Principles”, International Scholars Journals 10, 2022.
4. Gerald Lebovits, “Judgment Writing in Kenya and the Common-Law World”, Kenya Law Review, 2009.
5. The Federal Judicial Center of USA, Judicial Writing Manual (A Pocket Guide for Judges), 2020.
6. Andrew Godwin, “Judgment writing”, China Law Journal, 2024.
7. Douglas E. Edlin, Common Law Judging: Subjectivity, Impartiality, and the Making of Law, 2016.
8. Robert Sharpe, Good Judgment: Judicial Decisions, 2020.

В. Бусад

1. Debbie Mortimer, “Some Thoughts on Writing Judgments in and for, Contemporary Australia”, Melbourne University Law Review Annual Lecture, 2018.
2. William Thomas Worster, “The Inductive and Deductive Method in Customary International Law Analysis: Traditional and Modern Approaches”, Georgetown Journal of International and Modern Approaches, 45, no2, 2014.
3. Judicial College of Victoria, “Judgment writing guide”, 2024.
4. Lord Hudge, Justice of The Supreme Court of the United Kingdom, “The scope of judicial law-making in common law tradition Max Planck Institute of Comparative and International Private Law”, 2019.

Герман хэл дээр:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Grundgesetz für die Bundesrepublik Deutschland, GG, 1949.
2. Gerichtsverfassungsgesetz (GVG), 1950.
3. Strafprozeßordnung (StPO), 1950.
4. Strafgesetzbuch (StGB), 1871.

Б. Ном, сурах бичиг

1. Manfred Heinrich, Deutsches Strafverfahrensrecht. 2nd ed, 2018.
2. Volker Erb, Robert Esser, Ulrich Franke, Kirsten Graal-mann-Scheerer, Hans Hilger, Alexander Igno, Die Strafprozeßordnung und das Gerichtsverfassungsgesetz, Großkommentar, 2013.
3. Urs Kindhäuser, Kay H. Schuman, Strafprozessrecht, 2023.
4. Lutz Meyer-Goßner, Ekkehard Appl, Theodor Kroschel, Karl Doerner, Die Urteile in Strafsachen, 2021.
5. Steffen Breyer, Koblenz, Volkmar Mehle, Bonn: Strafprozessrecht, 2005.

6. Manfred Heinrich, Deutsches Strafverfahrensrecht. 2nd ed, 2018.

В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Suzanna Ballansat, “Attendu que“ Französische Gerichtsurteile als Herausforderung für den Übersetzer,“ 2021.
2. Sten Lind, Magister, erfassungsrechtliche Grundlagen der Pflicht zur Begründung von Gerichtsurteilen, Juridica, № 24 , 2016.
3. Iwona Jacewicz, Didaktik des Fachübersetzens am Beispiel der Rechtstexte: polnische und deutsche Strafurteile im Vergleich, 2010.
4. Ekkehard Appl, Über die „Kunst des Urteilschreibens“ Festschrift für Ruthrissing-Van Saan zum 65. Geburtstag, 2018.

Орос хэл дээр:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Уголовный кодекс Российской Федерации от 13.06.1996 N 63-ФЗ // Собрание законодательства РФ, 17.06.1996, N25, ст. 2954.
2. Уголовно-процессуальный кодекс Российской Федерации от 18.12.2001 № 174-ФЗ // Собрание законодательства РФ. - 24.12.2001. - № 52 (ч. I). - ст. 4921.
3. Постановление Пленума Верховного Суда РФ от 29 ноября 2016 г. № 55 «О судебном приговоре» // Бюллетень Верховного Суда Российской Федерации. – 2017. – № 1.
4. Приказ Росстандарта от 29.04.2019 № 175-ст (ред. от 30.12.2020) «Об утверждении национального стандарта Российской Федерации». –М.: Росстандарт, 2019 он.

В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Халиков А. Н. Институт негласных следственных действий в уголовно-процессуальном законе России и стран ближнего зарубежья (сравнительно-правовое исследование) // Правовое государство: теория и практика. – 2024 он

Солонгос хэл дээр:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хууль 1953 он.
2. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 1954 он.
3. Бүгд найрамдах Солонгос улсын Шүүхийн тухай хууль 1949 он.
4. Бүгд Найрамдах Солонгос улсын Шүүхийн үйл ажиллагааг дэмжих тухай хууль 1989 он.
5. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр боловсруулах тухай журам 2014 он.
6. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх журам 2022 он.

Б. Эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл

1. 사법정책연구원 “법조일원화 시대에 걸맞은 제1심 판결서 작성 방식의 개선 방안”, 연구 보고서, 2023.

Япон хэл дээр:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 1948 он.
2. Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам 1948 он.

Б. Ном, сурах бичиг

3. 司法研修所編『刑事判決書起案の手引』2007.

Франц хэл дээр:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Code de procédure pénale.
2. European court of human rights, De la requête no 53607/99 présentée par André COHEN et Gilbert SMADJA contre la France.

3. Cour de cassation, La definition de la motivation enrichie, 2023.
4. Cour d'Appel de LYON, 16 l'ÉVRIER 2019, 19168000015.
5. Cour de cassation, criminelle, Chambre criminelle, 2 février 2022.

Б. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Me Manuel Abitbol, La forme du jugement, 2018.
2. Aurélien Bamdé, La rédaction des jugements: forme, mentions obligatoires, motivation, dispositif et force probante - Le Droit dans tous ses états, 2019.
3. Hélène Colombet, Alice Gouttefangeas, La qualité des décisions de justice. Quels critères?, 2019.
4. Léa Fernandes, Absence de motifs et nullité soulevée in limine litis, une opportunité pour la juridiction d'appel de réaffirmer la culpabilité du prévenu ainsi que la légitimité de la peine, 2024.
5. Stéphane de Navacelle, Ne bis in idem: France stays on the sidelines of the European stance.
6. Dalloz Etudiant, À propos des adages latins du droit français, 2017.

3. Цахим эх сурвалж:

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://legalinfo.mn/mn>
2. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан: <https://shuukh.mn/>
3. Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль зүйн нэгдсэн портал: <https://www.law.go.kr/>
4. Бүгд Найрамдах Солонгос Улсын Дээд Шүүхийн цахим хуудас: <https://www.scourt.go.kr/search/total/TotalSearch.work>
5. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын эрх зүйн нэгдсэн сан: <https://www.gesetze-im-internet.de/index.html>
6. Япон Улсын эрх зүйн хэм хэмжээний актын орчуулгын цахим хуудас: <https://www.japaneselawtranslation.go.jp/en/dicts/>

7. Япон Улсын эрх зүйн хэм хэмжээний актын цахим хуудас:
<https://laws.e-gov.go.jp/law/323AC00000000131>
8. Япон Улсын шүүхийн шийдвэрийн цахим хуудас:
https://www.courts.go.jp/app/hanrei_jp/search1
9. Ефименко Е. Латынь в суде: зачем она юристам и судьям [Электронный ресурс]. – 2019. – URL: <https://pravo.ru/story/212053/>
10. Precedent and Analogy in legal Reasoning”, Stanford Encyclopedia of Philosophy Archive, June 20, 2006, http: <https://plato.stanford.edu/archives/fall2024/entries/legal-reas-prec/>

